



ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

ЦАЦ

**СУРГАЛТ, СУДАЛГАА,
АРГА ЗҮЙН УЛИРАЛ
ТУТМЫН СЭТГҮҮЛ**

2021 №20/43/

- **Б.Эрдэнэчимэг М.Хонгорзул: Хүчний шилжилтийн онол ба Америк-Хятадын сөргөлдөөн**
- **Б.Мандахбаяр: Багшийг хөгжүүлэх асуудал**
- **С.Дэнсмаа: Цэргийн бакалаврын хөтөлбөрийн чанарыг сайжруулах зарим боломж**
- **Н.Жалбажав, С.Байгалмаа: Төрийн хууль цааз ба Үндэсний ой санамж**
- **Т.Эрдэнэхишиг: Модун Шаньюйн цэрэг**



ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИАС ЭРХЛЭН ГАРГАВ





ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:

Хурандаа Б.Өлзийхуяг ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэлийн асуудал хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Ахмад Н.Мөнх-Очир Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн Нэгдсэн лабораторийн цэргийн зориулалттай лабораторийн эрхлэгч, магистр

Редакцийн гишүүд:

Дэд хурандаа Д.Мандахбаяр Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн дарга, доктор (Ph.D)
Хурандаа Г.Эрдэнэбаатар БХУА-ийн Цэргийн стратегийн төвийн дарга, докторант
Хошууч Л.Одмаа ЦНДС-ийн Цэргийн холбоо, кибер аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)
Б.Баатарсүрэн БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)
Х.Орхончимэг БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Техник редакцийн гишүүд:

Д.Насанжаргал Дизайнер

Редакцийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, БНМАУ-ын баатар Д.Нянтайсүрэнгийн гудамж, 16 дугаар хороо, Улаанхуаран

Утас/факс: 976 11 480172

Шуудангийн хайрцаг: 13300

Веб хаяг: www.mndu.gov.mn

Цахим шуудан: tsats@mndu.gov.mn

Олон улсын индекс: ISSN 2313-8076

Эрхлэх байгууллага: Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургууль

Хэвлэх үйлдвэр: ҮБХИС-ийн Хэвлэх үйлдвэр



FOR INTELLECTUAL AND CREATIVE THINKING

EDITORIAL BOARD

Editor-In-Chief

Colonel B.Ulziikhuyag Deputy Director for Research and social partnership Prof. (Sc.D)

Deputy Editor-In Chief

Captian N.Munkh-Ochir Chief of Laboratory for Military uses of Unified Laboratory of Department for Research and innovation, MNDU

Editorial Panel

Lieutenant Colonel B.Mandakhbayar Chief of Division for Research and innovation, MNDU, Ph.D
Colonel G.Erdenebaatar Chief of Military strategic center of Defense Management Academy, MNDU
Major L.Odmaa Senior Lecturer of Military Signaling and cyber security Department of Joint Military School, MNDU, Ph.D
B.Baatarsuren Research fellow, Center of Defense Analyses, Institute of Defense Studies, MNDU, Ph.D
Kh.Orkhonchimeg Research fellow, Center of Security and Defense Studies, Institute for Defense Studies, MNDU, Ph.D

Technical Editor

Nasanjargal.D Designer, Illustrator

Address:

Mongolian National Defense University
Nyantaisuren Street, Bayanzurkh District, Ulaanbaatar, Mongolia, 13300

Phone: 976 11 480177

Fax: 976 11 480172

Mail box: 13300

Website: www.mndu.gov.mn

E-mail: news@mndu.gov.mn

ISSN: 2313-8076

Host: Mongolian National Defense University

Published by: Defense Press



ҮНДЭСНИЙ БАТЛАН
ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛИАС
ЭРХЛЭН ГАРГАВ.

2021

№20/43/

СУРГАЛТ,
СУДАЛГАА, АРГА
ЗҮЙН УЛИРАЛ
ТУТМЫН
СЭТГҮҮЛ

ДУГААРЫН ТОВЧООН

Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал

Б.Эрдэнэчимэг М.Хонгорзул: Хүчний шилжилтийн онол ба Америк-Хятадын сөргөлдөөн	6
Т.Мөнх-Оргил: ОХУ-ын Цэргийн энхийг сахиулах ажиллагааны зарим асуудал.....	11
П.Цэдэв Ж.Дамбадаржаа: Короновирус "Ковид-19" цар тахалтай тэмцэж буй олон улсын зарим туршлага, сургамж.....	17
А.Амартайван: Япон улсын чөлөөт ба нээлттэй Энэтхэг -Номхон далайн стратеги.....	21
Б.Нарантуяа: Цахим халдлага түүнээс хамгаалах эрх зүйн зохицуулалтын тухай.....	24
Ж.Цэсэн: Иргэний нийгэм ба аюулгүй байдал.....	30
Н.Норовсүрэн Н.Эрдэнэжаргал: Хүний хувийн мэдээлэл цуглуулж буй өнөөгийн байдал.....	35

Цэргийн сургалт, боловсрол судлал

С.Дэнсмаа: Цэргийн бакалаврын хөтөлбөрийн чанарыг сайжруулах зарим боломж.....	40
Б.Мандахбаяр: Багшийг хөгжүүлэх асуудал	45
Б.Баатарсүрэн: Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсооход бидний оролцоо	52
Д.Анхбаяр, О.Цогцолмаа: Шинэ нөхцөл байдлын үеийн цахим ба CDIO үнэлгээний арга зүй, стратеги	61

Шинжлэх ухаан судлал, түүх, сургамж

Н.Жалбажав, С.Байгалмаа: Төрийн хууль цааз ба Үндэсний ой санамж	66
Т.Эрдэнэхишиг: Модун Шаньюйн цэрэг	69
Х.Орхончимэг: Монголын эртний цэргийн сургалтын зарим аргын үндсийг тодруулах нь	73
Ч.Сосорбарам Н.Оюундэлгэр: Үндэсний ой санамжийг хадгалж өвлүүлж ирсэн түүх уламжлал	77
Н.Наранхүү: МАХЦ-ийг өргөтгөн хөгжүүлэх талаар Маршал Г.Дэгмидийн удирдан хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	82
О.Гэрэлмаа Т.Эрдэнэхишиг: Юань гүрний түүхэнд холбогдох нэгэн Япон хэлцийн учир	87

ХҮЧНИЙ ШИЛЖИЛТИЙН ОНОЛ БА АМЕРИК–ХЯТАДЫН СӨРГӨЛДӨӨН

Б.ЭРДЭНЭЧИМЭГ /БХЭШХ-ийн АББХСТ-ийн дарга, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа/
М.ХОНГОРЗУЛ /УБХИС-ийн ГХСТ-ийн дарга, докторант, дэд хурандаа/

Түлхүүр үг: Хүчний шилжилтийн онол, улс хоорондын мөргөлдөөн, ноёрхогч хүч, өрсөлдөгч, олон улсын систем

Key words: Power transition theory, interstate conflict, hegemonic power, challenger, international system

Хүчний шилжилтийн онол. А.Ф.К Органский 1958 онд "Дэлхийн улс төр" бүтээлдээ хүчний шилжилтийн онолыг дэвшүүлснээр өдгөө нэг жарны нүүрийг үзэж, олон улсын аюулгүй байдлын орчны өөрчлөлттэй уялдан тус онол шинэчлэгдэн улам бүр боловсронгуй болсон. Хүчний шилжилтийн онолыг тайлбарлах гол хоёр хувьсагч нь үндэстэн улсын харьцангуй хүч болон олон улсын дэг журам, статус кводоо сэтгэл дундуур байдал бөгөөд тус хоёр хувьсагчийн харилцан үйлчлэл нь дайн болон энх тайвныг тодорхойлох хүчин зүйлс болдог¹. Улс орнууд хэдий олон улсын дэг журамд сэтгэл дундуур байв ч хүчин чадавх сул тохиолдолд системд ноёрхогч их гүрнийг сөрөх бололцоогүй гэж үздэг. Хүчирхэг хэрнээ олон улсын дэг журам, систем дэх статус кводоо сэтгэл хангалуун их гүрнүүд системд ноёрхогч их гүрнийг сөрөх сэдэл багатай байдаг ажээ. Органскийгийн тайлбарласнаар олон улсын систем дэх хуваарилалтад сэтгэл дундуур хүчирхэг их гүрнүүд хамгийн их аюул учруулдаг ажээ.

Органский болон Күглэр нар 1980 оны "The War Ledger" бүтээлдээ системийг сөрөгч шинэ гүрэн, системийг хамгаалагч, ноёлогч их гүрэн хоёрын хоорондын хүчний харьцаагаар хүчний шилжилт тодорхойлогддог болохыг судалгаагаар нотолсон². Харин Таммен, Куглер, Лемке нар хүчний шилжилтийн онолыг цааш нь гүнзгийрүүлэн судалсан.

Хүчний тэнцвэрийн онол дэлхийн улс төрийг тодорхой түвшинд хоорондоо хамтарч бас өрсөлдөж байдаг шаталсан тогтолцоо бүхий үндэстэн улсуудаар төлөөлүүлэн тус шаталсан тогтолцоон дахь улс үндэстнүүдийн үүргийг тодорхойлж, хүчирхэг их гүрнүүд дэлхийн улс төрийг хэрхэн залдгийг дүрсэлсэн³.

Хүчний шилжилтийн онолоор олон улсын систем дэх улс гүрнүүдийг *харьцангуй сул дорой, дунд/жижиг улсууд, хүчирхэг их гүрнүүд, системд ноёлогч их гүрэн* гэсэн 4 давхаргад хуваадаг.



1 дүгээр зураг.

Олон улсын системийн бүлгүүд.

Системд ноёлогч их гүрэн нь улс орнуудын системээс хүртэх үр өгөөж, эрх дархыг хуваарилахад хяналтаа тогтоох үүрэг гүйцэтгэдэг тул олон улсын статус кводоо хамгийн сэтгэл хангалуун байдаг. Бусад их гүрнүүд системд ноёлогч их гүрэнтэй эвсэл холбоо, хуучны нөхөрлөл, харилцаа холбоо зэрэг олон шижмээр холбогдсон байдаг ба цаг хугацаа өнгөрөхийн хэрээр системд

¹ A.F.K Organski, World politics(New York: Alfred. A. Knopf, Inc), 1958. <https://archive.org/details/worldpolitics00orga/page/312/mode/2up/search/power+transiti on>

² Organski, A. F. K., and Jacek Kugler. The War Ledger. Chicago: University of Chicago Press, 1980.

³ Tammen, Ronald L., Jacek Kugler, and Douglas Lemke. "Power Transition Theory." Transresearch consortium Working paper, 2011; Tammen, Ronald L., Jacek Kugler, and Douglas Lemke. "Foundations of Power Transition Theory." Oxford Research Encyclopedia of Politics, 2017.

бүрэлдэн тогтсон дэг журамд өөрсдийн гэсэн тухлаг орон зайгаа эзэлж харьцангуй сэтгэл хангалуун байдаг. Харин шинээр их гүрний статусыг хүртэж олон улсын системд түрэн орж ирж буй улс гүрнүүдийн хувьд системээс хүртвэл зохих хувиа чамлалттай гэж үзэж, хуваарилалттай төдийлөн санал нийлэхгүй байх нь бий. Хэдийгээр тэдгээр шинэ залуу их гүрнүүд хангалттай хүчин чадавхтай боловч хуучуул буюу байгаа системдээ удсан их гүрнүүд өөрсдийн хүртэх ёстой ашгаасаа илүүчлэх, эрх ямбаа хуваалцах сонирхолгүй байдаг. Тиймээс шинэ их гүрнүүд ийм уян хатан бус буюу систем дэх хүчний хуваарилалтын өөрчлөлтийг дагаж хувирдаггүй статус квотой байгаадаа дургүйцэж эхэлдэг.

Энэ нөхцөлд байгаа системдээ сэтгэл ханамжтай **хүчирхэг их гүрнүүд**, шинээр гарч ирсэн хүчирхэг гэхдээ сэтгэл ханамжтай бус их гүрнүүдээс хүчин чадавхын хувьд давуу байгаа тохиолдолд энх тайван тогтоно. Харин эсрэг тохиолдолд буюу байгаа системдээ сэтгэл ханамжтай бус шинэ залуу их гүрнүүдийн хүчний харьцаа сэтгэл ханамжтай хүчирхэг их гүрнүүдтэй эн зэрэгцэж ирэх үед системийн дайн гарах магадлал ихэсдэг⁴.

Системийн хуваарилалттай сэтгэл хангалуун бус хөгжиж буй их гүрний хувьд системд ноёлогч статустай хэдий ч хүч нь харьцангуй буурч буй их гүрэнтэй хүчин чадавхын хувьд эн тэнцүү болох эсвэл бүр даван гарах үед дайны аюул ихэсдэг. Ийнхүү хүчний шилжилт явагдах мөчийг залуу их гүрэн хуучин ноёлогч их гүрнийг ялж, шинэ дэг журам бий болгох боломж гэж хардаг. Үр дүнд нь системийн ноёрхлын төлөөх их гүрнүүдийн дайн гардаг⁵. Тухайлбал, 1894-1895 оны Хятад-Японы дайн нь Хятад давамгайл статустай Зүүн Азийн тогтолцоонд Япон сэтгэл ханамжгүй байсантай зарим нэг талаараа холбогддог. Япон өсөн гарч ирж буй их гүрний хувьд

бүс нутагтаа хүлээн зөвшөөрөгдөх улмаар хүчний шилжилтийг даган өөрчлөлт явагдах нь гарцаагүй гэж үзсэн. Сэтгэл ханамжгүй байлаа гээд дайн гарах цор ганц шалтаг болохгүй. Хүчний шилжилт явагдаж буй нөхцөлд хүчний харьцаа дайн гарах эсэхийг тодорхойлох нөхцөл болдог. Японы хувьд хүчний харьцаа Хятадтай дүйцэх хэмжээнд очсоныхоо дараа л дайн гаргах шийдвэрт хүрсэн байдаг⁶.

Шинээр их гүрний статустай болж төрөн гарч ирж буй улс болгон олон улсын дэг журмын өөрчлөхийг хүсээд байдаггүй. Хүчний шилжилт явагдаж буй нөхцөлд оршин буй олон улсын дэг журамд хэр сэтгэл ханамжтай байна вэ гэдэг гол түлхүүр болж байна. Тэгвэл улс гүрний олон улсын дэг журамд сэтгэл ханамжтай эсэхийг хэрхэн тогтоох вэ, сэтгэл ханамжийг хэрхэн хэмжих вэ гэдэг чухал асуулт тавигдаж байна.

Америк - Хятадын хүчний шилжилт үү? БНХАУ олон улсын тавцанд улс төрийн жин нөлөө, эдийн засаг, цэргийн хүчин чадавхын хувьд хүчирхэгжиж буй нь хүчний шилжилт дагуулах уу?, Америк төвтэй олон улсын системийн ноёрхлыг эсрэг дайн гарах уу? зэрэг асуудлууд хүчний шилжилтийн онолын гол судлагдахуун болж байна.

Аластайр Жонстон Хятадын зэвсэгт мөргөлдөөнд оролцох магадлалын талаарх "China's militarized interstate dispute behaviour" судалгаандаа 1949-1992 оны хооронд Хятад улсын оролцсон улс хоорондын зэвсэгт мөргөлдөөнүүдэд дүгнэлт хийж, тус улс ямар тохиолдолд аливаа улсын эсрэг цэргийн хүч ашиглах, зэвсэгт мөргөлдөөнд оролцох магадлалыг тогтоосон байна. Энэхүү судалгаагаар "Хятад улс олон улсын статус квоодоо сэтгэл хангалуун бус байгаа үедээ газар нутгийн маргаан, зөрчлөөр цэргийн хүч ашиглах буюу зэвсэгт мөргөлдөөнд оролцдог" гэж тодорхойлсон байна⁷. Үүнээс харахад

⁴ Mitchell, Sara McLaughlin, Paul F Diehl, and James D Morrow (Guide to the Scientific Study of International Processes. Guides to International Studies. Hoboken, N.J.: Wiley), 2012.

⁵ Мөн тэнд

⁶ Greve, Andrew Q, and Levy, Jack S. "Power Transitions, Status Dissatisfaction, and War: The Sino-Japanese War of 1894-1895." Security Studies 27, no. 1 (2018): 148-78.


⁷ Johnston, Alastair Iain. 1998. "China's Militarized Interstate Dispute Behaviour 1949-1992: A First Cut at the Data". The China Quarterly 153 (March): 1-30.



Хятад улс статус кводоо сэтгэл хангалуун бус үедээ газар нутгийн маргааныг олон улсын системд статусаа дээшлүүлэх, гадаад болон аюулгүй байдлын бодлогоо хэрэгжүүлэх арга зам гэж харж болох магадлалтай гэсэн гаргалгаа харагдаж байна.

АНУ нь Хятадад найр тавьж, олон улсын системийн хуваарилалтад сэтгэл ханамжтай байх талаар анхаарал тавих нь дайнаас сэргийлэх гарц гэж үзэх нь ч бий. Тэгвэл хүчний шилжилтийн онолын дагуу Хятад улс одоогийн олон улсын дэг журамд хэр сэтгэл ханамжтай байгаа вэ гэдгийг батлан хамгаалах төсөв, цэргийн хүчин чадавхаа нэмэгдүүлж буй эсэхээр тодорхойлж болно.

Хятадын батлан хамгаалах төсвийн өсөлт: Хүчний шилжилтийн онолоор эмпирик судалгаа хийсэн Вернер, Сузанне нар улс орон цэргийн хүчин чадавхаа нэмэгдүүлж, улмаар батлан хамгаалах төсөв дунджаас дээгүүр өсөлттэй байвал тэр нь шинэ их гүрний олон улсын дэг журамд сэтгэл ханамжтай бус байдлыг илтгэдэг хэмээжээ⁸. Лемке 2002 оны судалгаандаа цэргийн хүчин чадавхын өсөлт нь шинэ их гүрний хуучин ноёлогч их гүрнийг сөрөх магадлалтай гэдгийг илтгэх шинж гэдгийг тодорхойлсон юм⁹.



2 дугаар зураг.

Хятадын батлан хамгаалах төсөв 2012-2021.
Эх сурвалж: Global Times (2021)

Сүүлийн жилүүдэд Хятадын батлан хамгаалах төсөв тасралтгүй өсөлттэй байгаа бөгөөд 2021 онд батлан хамгаалах төсвөө 1,35 их наяд юань буюу 209,2 тэрбум ам.доллар байхаар баталсан нь өмнөх оныхоос 6.8 хувиар нэмэгдсэн гэж гарсан^{10,11}. Хятадын батлан хамгаалах төсөв 2020 онд 1,27 их наяд юань буюу 179 тэрбум ам.доллар байсан нь өмнөх он буюу 2019 оныхоос 6.6 хувиар өссөн¹².

Хятад улс цэргийн хүчин чадавхиа нэмэгдүүлж буй нь: Хүчний шилжилтийн онолоор өсөж буй их гүрэн системд ноёлогч их гүрэнтэй хүчин чадавхын хувьд эн тэнцүү болох эсвэл бүр даван гарах үед дайн гарах магадлал ихэсдэг. Тиймээс БНХАУ цэргийн хүчин чадавхын хувьд АНУ-ыг даван гарах хүртэл Хятад-Америкийн хооронд олон улсын системд манлайлахын төлөөх томоохон зэвсэгт мөргөлдөөн гарах магадлал харьцангуй бага гэж үзэх үндэстэй юм.

Хятадын цэргийн хүчин чадавхын тухайд Зэвсэгт хүчний байнгын бие бүрэлдэхүүний тоо (2020 оны байдлаар) 2,035,000 байгаагаас Хуурай замын цэргийн хүчинд 975,000, Тэнгисийн цэргийн хүчинд 250,000, Агаарын цэргийн хүчинд 395,000, Стратегийн пуужингийн цэргийн хүчинд 120,000 стратегийн дэмжлэг үзүүлэх цэргийн хүчинд 145,000 тус тус байна¹³. Эдгээрээс гадна бэлтгэл хүчинд 510,000, мөн хагас цэрэгжилттэй (paramilitary) 660,000 тус тус байна¹⁴.

Хятадын цэргийн шинэчлэлийн хүрээнд зэвсэг, техникийн шинэчлэлийг хурдацтай өрнүүлж байна. Зэвсгийн системийн хөгжүүлэлт, судалгаа, боловсруулалт, туршилт, захиалга, үйлдвэрлэлийн явц тасралтгүй үргэлжилж, энэ зорилгоор иргэн-цэргийн хамтын ажиллагааг сайжруулж буй. Иргэн-

⁸ Suzanne, Werner, and Kugler, Jacek. "Power Transitions and Military Buildups". In Parity and War: Evaluations and Extensions of the War Ledger, edited by Jacek Kugler and Douglas Lemke, 187-207. Ann Arbor, MI: University of Michigan Press, 1996.

⁹ Lemke, Douglas. Regions of War and Peace (New York: Cambridge University Press), 2002.

¹⁰ 增长6.8%:2021年中国军费预算为13553.43亿元.
<https://mil.news.sina.com.cn/china/2021-03-05/doc-ikftssaq1530132.shtml>

¹¹ "Liu Xuanzan, China hikes defense budget by 6.8% in 2021, faster than 6.6% growth last year" <https://www.globaltimes.cn/page/202103/1217416.shtml>

¹² Мөн тэнд

¹³ International Institute for Strategic studies, The Military Balance-2020, 1st ed., vol. 120 (Taylor & Francis Ltd, 2020), хуудас 259.

¹⁴ Мөн тэнд



цэргийн хамтын ажиллагааг сайжруулах гэдгийн цаад учир нь Зэвсэгт хүчин иргэний салбар дахь шинжлэх ухаан, технологийн нээлтэд чөлөөтэй нэвтрэх, ашиглах болон шинэ технологи, инновацын чиглэлээр хамтран ажиллах замаар цаг тутам өөрчлөгдөн буй шинжлэх ухаан, технологийн хөгжлөөс хоцрохгүй байх бодлого баримталж байна. Хиймэл оюун ухааныг хөгжүүлэх чиглэлд ач холбогдол өгч жолоочгүй танк, хуягт техник зэрэг робот технологийг хөгжүүлэхэд анхаарч буй.

д/д	Улс орон	Цэргийн Тоо
1	Хятад	2,035,000
2	Энэтхэг	1,455,550
3	Хойд Солонгос	1,280,000
4	Пакистан	653,800
5	Өмнөд Солонгос	599,000
6	Вьетнам	482,000
77	Мьянмар	406,000
88	Индонези	395,500
99	Тайланд	360,850
110	Шри-Ланк	255,000

1 дүгээр хүснэгт. Цэргийн тоогоороо
Азид тэргүүлэгч 10 орон
Эх сурвалж: Military balance 2020

Зэвсэгт хүчний цаашдын хөгжлийн тухайд БНХАУ 2035 он гэхэд цэргийн шинэчлэлээ дуусгаж, 2049 он буюу XXI зууны дунд үе гэхэд дэлхийн жишигт хүрсэн зэвсэгт хүчинтэй болохыг зорьж буй¹⁵. Шинхуа агентлагаас толилуулсан БНХАУ-ын XIV таван жилийн төлөвлөгөөний төсөлд цэргийн шинэчлэлийн чанар, бүтээмжийг сайжруулахыг анхаарч ажиллахыг онцолсон¹⁶. Ирэх таван жилд цэргийн онолыг шинэчлэх хурдасгаж, цэргийн стратегийн удирдамж, шинэчлэх, цэргийн номлол, байлдааны ажиллагааны номлолуудыг боловсронгуй болгохыг үүрэг болгосон. Мөн стратегийн дэмжлэгийн хүчнийг бэхжүүлэх, тэр дундаа сансар, кибер зэрэг шинэ орон зайд бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах, дээд түвшний стратегийн хориглолт, төрлийн цэргүүдийн нэгдсэн

ажиллагааны систем бий болгох, төрлийн цэргүүдийн хамтарсан сургууль бэлтгэлийг сайжруулахыг анхаарч ажиллахыг үүрэг болгосон юм¹⁷.

Дүгнэлт. Хятад улс өдгөө цэрэг, зэвсгийн хувьд хүчирхэгжиж, олон улсын системд нөлөө бүхий их гүрэн болж гарч ирсэн нь Хятад-Америкийн хооронд олон улсын системийн ноёрхлын төлөөх зөрчил мөргөлдөөн үүсэх үү? гэсэн асуулт анхаарал татах болсон.

Олон улсын харилцаанд системд ноёлогч их гүрний хүч аажмаар буурч, олон улсын дэг журам, системийн хуваарилалттай сэтгэл хангалуун бус шинэ залуу их гүрний хүч аажмаар өсөж хүчний шилжилт явагддаг. Хүчний шилжилтийн онолоор хөгжиж буй их гүрний хувьд системд ноёлогч статустай хэдий ч хүч нь харьцангуй буурч буй их гүрэнтэй хүчин чадавхын хувьд эн тэнцүү болох эсвэл бүр даван гарах үед дайн гарах магадлал ихэсдэг. Учир нь залуу их гүрэн хүчний шилжилтийг хуучин ноёлогч их гүрнийг ялж, шинэ дэг журам бий болгох боломж гэж харснаар системийн ноёрхлын төлөөх их гүрнүүдийн дайн гардаг.

БНХАУ-ын хувьд цэргийн стратеги болон бусад бодлогын баримт бичгүүдээрээ Хятад улс олон улсын системд ноёрхохыг эрмэлзэхгүй гэдгийг удаа дараа илэрхийлсэн бөгөөд "энх тайванч" зарчим баримтална гэж мэдэгдэж буй. Тус улс сүүлийн жилүүдэд цэргийн хүчин чадавхаа эрчимтэй нэмэгдүүлж, Хятадын батлан хамгаалах төсөв тасралтгүй өсөлттэй байгаа нь хүчний шилжилтийн онолоор Америкийн тэргүүлсэн олон улсын системд сэтгэл ханамжтай бус байгааг илтгэх хэлбэр юм.

Системийн онолыг шүүмжлэгчид болон Хятад судлаачид соёл иргэншил, ертөнцийг үзэх үзлийн хувьд барууны орнуудаас тэс өөр Хятад улсын зан байдлыг барууны онолоор тайлбарлах нь өрөөсгөл гэж үзэж буй. Хүчний шилжилтийн онолын

¹⁵ 新时代的中国国防. 白皮书. http://www.gov.cn/zhengce/2019-07/24/content_5414325.htm

¹⁶ (两会授权发布) 规划纲要草案: 加快国防和军队现代化 实现富国和强军相统一 http://www.xinhuanet.com/politics/2021lh/2021-03/05/c_1127173236.htm

¹⁷ (两会授权发布) 规划纲要草案: 加快国防和军队现代化 实现富国和强军相统一 http://www.xinhuanet.com/politics/2021lh/2021-03/05/c_1127173236.htm



шүүмжлэл нь хоёр талтай юм. Юуны түрүүнд хүчний шилжилтийн онол нь системийн онол учраас "ганц модыг бус ойг бүхэлд нь хар" гэсэн зарчмаар том зураглалаар нь харахыг урьтал болгодог. Тиймээс хоёр улсын хоорондох нарийн зөрчилтэй асуудлууд, дотоод улс төр, эдийн засгийн байдалд гарч буй өөрчлөлт, удирдагчдын гадаад болон аюулгүй байдлын бодлого дахь нөлөөлөл зэрэг

олон хүчин зүйлсийг орхигдуулах нь бий. Тиймээс Хятад-Америкийн сөргөлдөөн, хоёр орны харилцааны ойрын болон хэтийн төлөвөөр илүү нарийн магадлал бүхий таамаглал дэвшүүлэхийн тулд хүчний шилжилтийн онолыг хоёр улс хоорондын, үндэстэн улсын болон хувь хүний түвшинд зөрчил мөргөлдөөнийг тайлбарлах зарим улс төрийн онолтой хоршуулан хэрэглэвэл илүү үр дүнтэй байх боломжтой.

Ашигласан материал:

1. A.F.K Organski, World politics(New York: Alfred. A. Knopf, Inc), 1958. <https://archive.org/details/worldpolitics00orga/page/312/mode/2up/search/power+transiti on>
2. Organski, A. F. K., and Jacek Kugler. The War Ledger. Chicago: University of Chicago Press, 1980.
3. Tammen, Ronald L., Jacek Kugler, and Douglas Lemke. "Power Transition Theory." Transresearch consortium Working paper, 2011; Tammen, Ronald L., Jacek Kugler, and Douglas Lemke. "Foundations of Power Transition Theory." Oxford Research Encyclopedia of Politics, 2017.
4. Mitchell, Sara McLaughlin, Paul F Diehl, and James D Morrow (Guide to the Scientific Study of International Processes. Guides to International Studies. Hoboken, N.J.: Wiley), 2012.
5. Greve, Andrew Q, and Levy, Jack S. "Power Transitions, Status Dissatisfaction, and War: The Sino-Japanese War of 1895-1894." Security Studies 27, no. 78-148 :(2018) 1.
6. Suzanne, Werner, and Kugler, Jacek. "Power Transitions and Military Buildups." In Parity and War: Evaluations and Extensions of the War Ledger, edited by Jacek Kugler and Douglas Lemke, 207-187. Ann Arbor, MI: University of Michigan Press, 1996.
7. Lemke, Douglas. Regions of War and Peace (New York: Cambridge University Press), 2002.
8. Johnston, Alastair Iain. 1998. "China's Militarized Interstate Dispute Behaviour 1992–1949: A First Cut at the Data." The China Quarterly 153 (March): 30–1.
9. 增长6.8% : 2021年中国军费预算为13553.43亿元. <https://mil.news.sina.com.cn/china/05-03-2021/doc-ikftssaq1530132.shtml>
10. "Liu Xuanzan, China hikes defense budget by %6.8 in 2021, faster than %6.6 growth last year" <https://www.globaltimes.cn/page/1217416/202103.shtml>
11. International Institute for Strategic studies, The Military Balance1 ,2020-st ed., vol. 120 (Taylor & Francis Ltd, 2020), хуудас 259.
12. 新时代的中国国防. 白皮书. http://www.gov.cn/zhengce/24/07-2019/content_5414325.htm
13. (两会受权发布) 规划纲要草案 : 加快国防和军队现代化 实现富国和强军相统一—http://www.xinhuanet.com/politics/2021lh/05/03-2021/c_1127173236.htm



ОХУ-ЫН ЦЭРГИЙН ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛД

Т.МӨНХ-ОРГИЛ /БХЭШХ-ийн Цэргийн урлаг судлалын төвийн ЭША,
доктор (Ph.D), дэд хурандаа/

Түлхүүр үг: Аюулгүй байдал, Уулын Карабах, энхийг сахиулах ажиллагаа

Key words: Security, Nagorno-Karabakh and peacekeeping operations

Товч агуулга. Бүс нутгийн төдийгүй олон улсын аюулгүй байдлын орчинд тодорхой хэмжээний чиг хандлага, байр суурийг тодорхойлж байдаг хойд хөршийн батлан хамгаалах үйл ажиллагааны бодлого бидний зайлшгүй анхаарал хандуулах асуудлын нэг юм. Учир нь одоо ч гэсэн зарим судлаачид Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зарим асуудалд ОХУ-ын байр суурь чухал гэж үзсээр байна. Тиймээс олон улсын тавцанд эдийн засаг гэхээсээ илүүтэйгээр батлан хамгаалах салбарын үйл ажиллагаагаараа давамгайлах байр суурийг илэрхийлдэг ОХУ-ын батлан хамгаалах бодлогыг тасралтгүй судлан шинжилгээ хийж байх нь бидний хувьд чухал юм. ОХУ-ын "Батлан хамгаалах бодлого 2021-2025" бодлогын баримт бичгийг 2020 оны 11 дүгээр сарын 13-нд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин баталсан байна. ОХУ-ын 2016-2020 оны батлан хамгаалах бодлого нь стратегийн цөмийн зэвсгийн чадавхыг нэмэгдүүлэх болон цэргийн баруун тойргийн үйл ажиллагааг сайжруулах талаар тусгаж байсан бол 2021-2025 оны шинэчилсэн бодлогын хүрээнд нилээдгүй анхаарал татсан чиглэлүүдийг тусгасны нэг нь Евразийн нутаг дахь зарим улс орнуудын сэргөлдөөнд энх тайвны зуучлагч болоход Оросын үүргийг нэмэгдүүлж олон улсын тавцанд өөрийн байр суурь, нэр хүндийг өсгөхөд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар тусгасан байна. Энэ бодлогын хүрээнд ОХУ "энхийг сахиулах ажиллагаа"-г Кавказад явуулж эхлээд байна.

Оршил. ОХУ-ын цэргийн хүчин 1973 онд Ойрх Дорнод, 1990-ээд оны үед, Балкан, Ангол, Камбожид энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байдаг. Сүүлийн жилүүдэд Голаны өндөрлөг,

Ойрх Дорнод, Молдав, Баруун Сахар, Бүгд Найрамдах Ардчилсан Конго, Кот-д'Ивуар, Либери, Сири, Судан зэрэг улсад явагдаж байгаа НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа төдийгүй НҮБ-д хамгийн олон тооны цэргийн ажиглагчтай 10 орны тоонд багтаж байна. Мөн ОХУ энхийн ажиллагаанд гэрээт буюу агаарын тээврийн үйлчилгээ үзүүлдгээрээ хоёрт орж байна. 2020 онд Уулын Карабахад болсон зэвсэгт мөргөлдөөнийг зогсооход олон улсын төдийгүй бүс нутагтаа үндсэн тоглогч байж гурван талт гал зогсоох хэлэлцээрийг зохион байгуулснаар бие даан энхийг сахиулах хүчийг ажиллагааны газар оронд илгээгээд байна. Энэ нэг талаараа ОХУ бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангахад давамгайлах байр суурьтай байгааг, нөгөө талаараа Кавказын чанад бол хэзээд Оросын стратегийн ашиг сонирхлын нэг хэсэг байх юм гэдгийг харуулж байна. Бүс нутагт болж байгаа улс орнуудын ашиг сонирхлын зөрчилдөөнд ОХУ-ын байр суурь чухал төдийгүй энэ нь бүс нутгийн төдийгүй олон улсын аюулгүй байдлын орчинд нөлөөлөх нь дамжиггүй юм.

Олон улсын хамтын ажиллагааны хамгийн том байгууллага болох НҮБ Уулын Карабахыг Азербайжаны бүрэлдэхүүн гэж үздэг ч Карабахчууд өөрсдийгөө тусгаар тогтносон улс гэж үзсээр байна. XIX зууныг хүртэл Карабах нь Армений хаант улсын бүрэлдэхүүнд байсан бөгөөд уг улс задран унасны дараа Персийн эзэнт гүрний мэдэлд орж 1813 оноос Карабахыг Оросын эзэнт гүрэн өөртөө нэгтгэсэн байдаг. 1917 оны Октябрийн хувьсгалын дараа Кавказын чанадад Гүрж, Армени, Азербайжан гэсэн гурван улс байгуулагдсанаар Карабахын район Азербайжаны бүрэлдэхүүнд оржээ. Энэ шийдвэр Карабахын хүн амын ихэнхийг бүрдүүлдэг арменичуудын



дургүйцлийг төрүүлсэн хэдий ч Азербайжаны бүрэлдэхүүнд хэвээр нь үлдээжээ. Үүний дараагаар мөн 1991 онд ЗХУ-ын улс төр, эдийн засгийн коммунист тогтолцоо задрахад түүний бүрэлдэхүүнд байсан Азербайжаны харьяа Армен үндэстнүүдээс бүрдэх Уулын Карабахын автономит муж нь Бүгд Найрамдах Уулын Карабах улс гэж тусгаар тогтнолоо зарласан байдаг. Үүнээс болж Армени болон Азербайжаны хооронд хоёр жил үргэлжилсэн дайн ОХУ-ын зуучилснаар 1994 оны тавдугаар сард талууд харилцан гал зогсоох гэрээ байгуулснаар зогссон юм. Энэ мөргөлдөөнөөр Азербайжан Уулын Карабах болон түүнтэй зах нийлсэн долоон бүсэд буюу нутаг дэвсгэрийнхээ 20 орчимд хяналтаа алдсан байна. Түүнээс хойш 2016 оны 4 дүгээр сарын 2-оос 5-ны хооронд өрнөсөн байлдааны ажиллагаа нь гал зогсоох тухай хэлэлцээрээс хойших хамгийн өргөн хүрээт тулаан болж, хоёр тал нэлээд хэмжээний гарз хохирол амссан байдаг. 2020 оны 9 дүгээр сард Азербайжаны Батлан хамгаалах яам "манай улсын Зэвсэгт хүчин фронтын нийт шугамын дагуу сөрөг довтолгоо хийж байна" гэж мэдээлсэн бол Армений Батлан хамгаалах яам "Уулын Карабах /Арцах/ ба Азербайжаны хилийн нийт шугамын дагуу байлдааны ажиллагаа явагдаж байна" гэж мэдэгдэж, хоёр тал бие биеэ гал зогсоох хэлэлцээр зөрчсөн хэмээн буруутгаснаар мөргөлдөөн эхэлсэн байна.

Үндсэн хэсэг. Уулын Карабахыг байгалийн хий болон газрын тос дамжуулах томоохон хоолой дайран өнгөрдөг. Тиймээс энэхүү бүс нутагт дан ганц Армен болон Азербайжаны хооронд үл ойлголцол байгаад зогсохгүй бүс нутгийн эдийн засаг, аюулгүй байдал талаасаа ОХУ, Турк, Иран зэрэг хөрш зэргэлдээ орнуудын хувьд чухал эрх ашигт тооцогддог. Армен болон Азербайжаны хооронд 2020 оны сүүлээр 44 хоногийн байлдааны ажиллагаа явагдаж ОХУ-ын энх тайвны зуучлалаар дуусгавар болж гал зогсоож хоёр талын зөвшөөрлийн үндсэн дээр 2020 оны 12 дугаар сараас хойш Оросын энхийг сахиулагчид Уулын Карабахад үүрэг гүйцэтгэж байна. ОХУ-ын энэхүү

энхийг сахиулах ажиллагаа нь нэг талаараа өмнө нь ОХУ-ын Тажикистан, Молдав, Гүржийн Абхаз, Өмнөд Осетед явуулсан ажиллагаануудын нэг адил олон улсын хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн эсэх тал дээр учир дутагдалтай гэж шинжээчид үзэж байна. Учир нь олон улсын эрх бүхий ямар ч байгууллагын мандатгүй цэргийн хүчин байршуулсан, мөн цэргийн хүчин нь зөвхөн нэг улсын оролцоотой байгаа зэрэг нь ОХУ ажиллагааны газар оронд явуулж байгаа энхийг сахиулах ажиллагааны үргэлжлэх хугацааг өөрийн ашиг сонирхлын үүднээс шийдвэрлэх, гэрээнд өөрчлөлт оруулах боломжтой байх зэргээр асуудлыг ганцаараа шийдэх талтай байгаа нь олон улсын холбогдох эрх зүй болон НҮБ-аас баталсан энхийг сахиулах үйл ажиллагааны эрх зүйн хэм хэмжээтэй зөрчилдөж байна.

Харин нөгөө талаас нь авч үзвэл Карабах дахь ажиллагаа нь Оросын өмнө нь явуулж байсан "энхийг сахиулах" ажиллагаанаас зарим талаар онцлог ялгаатай юм. Тухайлбал, ОХУ нь аль нэг талынх нь хууль ёсны Засгийн газрын эсрэг байгаагүй, аль нэг талыг нь дэмжиж хөндлөнгөөс оролцоогүй, улс орнуудыг барууныхны эвсэл, холбоонд элсэхийг эсэргүүцэж ажиллагаа явуулаагүй зэргийг дурдаж болно. Мөн сөргөлдөгч талуудын харилцан зөвшөөрсний үндсэн дээр ажиллагааны газар оронд энхийг сахиулах цэргийн хүчийг оруулсан төдийгүй иргэн цэргийн хамтын ажиллагаанд ач холбогдол өгч энэ чиглэлийн арга хэмжээнд илүүтэйгээр үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Сөргөлдөгч талуудын хувьд ОХУ-ын энэхүү энхийг сахиулах үйл ажиллагааг аль аль талуудын ашиг сонирхлыг хамгаалсан гэж үзэж байна. Тухайлбал Уулын Карабахын хувьд тухайн улсын Зэвсэгт хүчнийг сүйрлээс, засгийн газрыг нь уналтаас сэргийлж, нутаг дэвсгэрийг бүрэн алдахаас хамгаалж, хүн амынх нь гадагш чиглэсэн урсгалыг зогсоосон гэж үзэж байгаа бол Азербайжаны хувьд Оростой хийсэн энх тайвны хэлэлцээрийн хүрээнд Карабахын газар нутаг гэгдэж байсан газар нутгийн зарим хэсгийг бараг хохиролгүйгээр өөрийн болгож

мөн Азербайжанаас Арменаар дамжин түүний алслагдсан нутаг болох Нахчиван руу болон Азербайжанаас Турк руу гарах хуурай замын маршрутыг өөрийн эзэмшилд баталгаажуулсан байна.



1 дүгээр зураг. Уулын Карабах

Галзогсоох хэлэлцээрт ОХУ арбитрчийн байр сууринаас хандаж талуудын эвлэрлийн гэрээний нөхцөлийг боловсруулж Баку, Ереван хоёрын байгуулсан эвлэрлийн хэлэлцээрт зуучлахдаа өрнөдийнхөн байтугай Туркийг ч оролцуулаагүй. 2020 оны 11 дүгээр сарын 9-10-ны хооронд байгуулсан "Тунхаглал" нэртэй гурван талт эвлэрлийн гэрээний 9 заалтад дараах асуудлууд тусгагдсан байна. Үүнд;

- 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Москвагийн цагаар 00:00 цагаас Уулын Карабахын мөргөлдөөнд бүх дайсагнасан ажиллагааг болон галыг бүрэн зогсоох,
- Агдам дүүргийг 2020 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Бүгд Найрамдах Азербайжан улсад буцааж өгөх,
- Лачиний коридороор 1960 хүний бүрэлдэхүүнтэй, хөнгөн зэвсэг, 90 хуягт тээвэрлэгч, 380 автомашин болон бусад тусгай техник хэрэгсэлтэй ОХУ-ын энхийг сахиулах хүчнийг Уулын Карабах руу хөдөлгөөн үйлдүүлэх,
- ОХУ-ын энхийг сахиулах бүрэлдэхүүнийг Арменийн Зэвсэгт хүчнийг Уулын Карабахас гаргахтай зэрэгцүүлэн байрлуулах, ОХУ-ын энхийг сахиулах цэргийн хүчний үргэлжлэх хугацаа нь 5 жилийн хугацаатай бөгөөд шаардлагатай

гэж үзвэл дахин 5 жилээр сунгах,

- Мөргөлдөөнд оролцогч талуудын гэрээний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих зорилгоор энхийг сахиулах төвийг байрлуулах.
- Бүгд Найрамдах Армен Улс Калбажар дүүргийг Азербайжанд 2020 оны 11 дүгээр сарын 15-25-нд, Лачин дүүргийг 12 дугаар сарын 1-ний дотор буцааж өгөх, Уулын Карабахас Армен руу нэвтрэхэд Шуша хотыг тойрч гарах Лачин 5 км коридор нь ОХУ-ын энхийг сахиулагч хүчний хяналтад байх болно. Талуудын тохиролцсоны дагуу ойрын гурван жилд Лачины коридороор явах шинэ маршрутын бүтээн байгуулалтын төлөвлөгөөг тодорхойлох, Бүгд Найрамдах Азербайжан Улс Лачины коридорын дагуу хоёр чиглэлд иргэд, тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлыг баталгаажуулах,
- НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газрын хяналтан дор Уулын Карабах болон түүний зэргэлдээх нутаг дэвсгэрт дотоодын нүүлгэн шилжүүлэлт, дүрвэгсдийг буцаан нутагт нь авчрах, суурьшуулах,
- Дайны олзлогдогсод, барьцаалагдсан хүмүүс болон бусад хоригдлуудыг солилцох, амь үрэгдсэн хүмүүсийн цогцсыг солилцох,
- Бүс нутгийн эдийн засгийн үйл ажиллагааг хэвийн явуулахад дэд бүтцийг ашиглах боломжтой, нээлттэй байлгах, иргэний болон ачааны тээврийн хэрэгслийн хоёр чиглэлд саадгүй шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулах зорилгоор Бүгд Найрамдах Азербайжан улсын баруун бүс нутаг болон Нахчиванийн автономит Бүгд Найрамдах Улсын хоорондох тээврийн аюулгүй байдлыг Бүгд Найрамдах Армен Улс хариуцах, ОХУ-ын ТТГ-ын Хилийн алба тээврийн харилцаанд хяналт тавина. Талуудын тохиролцсоны



дагуу Нахчиванийн автономит Бүгд Найрамдах Улсыг Азербайжаны бүс нутгуудтай холбох шинэ дэд бүтцийг барих ажлыг гүйцэтгэх гэсэн заалтууд тусгагдсан байна.

Энэ тунхаглалын дагуу Дээд Карабахад ОХУ-ын хөнгөн зэвсэглэсэн, хуягт тээвэрлэгч бүхий 1960 орчим мотобуудлагын цэргээс гадна минэгүйжүүлэх болон тэсэрч дэлбэрэх бодис устгах бүрэлдэхүүн, цэргийн цагдаа болон хууль шүүхийн алба хаагчид үүрэг гүйцэтгэж байна. Гэрээнд нисдэг тэрэг, нисгэгчгүй нисэх төхөөрөмж зэргийг дурдаагүй байсан ч найман нисдэг тэрэг¹ (дөрвөн тээврийн хэрэгсэл, дөрвөн цохилтын нисдэг тэрэг) Орлан-10 тагнуулын нисгэгчгүй нисэх төхөөрөмж (ННТ)-ийг ашиглаж байна. Эдгээр зэвсэглэл ямар ч энхийг сахиулах ажиллагаанд ашиглагдаж болох хэдий ч 3 улсын байгуулсан хэлэлцээрт тусгагдаагүй зэвсэглэлийн төрлүүд байна гэж шинжээчид үзэж байна. Мөн Оросын энхийн сахиулагчдын хамгийн чухал эрх зүйн баримт бичгийн нэг болох ажиллагааны хүч хэрэглэх дүрмийн талаар олон нийтэд нээлттэй мэдээлэл байхгүй байна.



2 дугаар зураг. ОХУ-ын энхийн сахиулагчдын ажиллагааны газар орон

Өмнө дурдсанчлан энэхүү ажиллагааны нэг онцлог нь ОХУ-ын цэргийн алба хаагчид анх удаа ажиллагааны газар оронд иргэн цэргийн ажиллагаа явуулж байна. Ерөнхийлөгч Путины зарлигаар Батлан хамгаалах яамны дэргэд "Нагорный" Карабах дахь Хүмүүнлэгийн ажиллагааны нэгж байгуулагдан Степанакерт үндсэн

баазад болон орон нутагт үүрэг гүйцэтгүүлж байна. Хүмүүнлэгийн ажиллагааны хүрээнд Уулын Карабахад дайны дараах сэргээн босголтын ажил, дэд бүтцийн засвар үйлчилгээ, хүмүүнлэгийн тусламжийн хуваарилалт болон орон нутгийн иргэдэд эмнэлгийн тусламж зэрэг өргөн хүрээтэй хүмүүнлэгийн ажиллагаа явуулж байна.

Дайны улмаас Карабахын Армен руу дүрвэсэн Арменчүүд буцаж Армены талын газар нутагт суурьшиж байгаа бол Азербайжаны буцааж авсан газар нутагт дайны өмнөхөөс бага тооны хүн ам суурьшиж байна. 11 дүгээр сарын 10-нд гал зогсоосны дараа Ереван дахь засгийн газар болон Оросын "энхийг сахиулах" хүчин дүрвэгсдийг Карабах руу буцаахаар хамтран ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 11 дүгээр сарын 14-өөс 2021 оны 1 дүгээр сарын 21-ний хооронд Оросын цэргүүд өөрсдийн тоогоор 50,390 дүрвэгсдийг Карабах дахь Арменуудын хяналтад байсан нутаг руу буцаасан гэж мэдээлсэн байна². Ереван, Степанакерт нарын эрх баригчид Армен руу дүрвэж буй Карабахын нийт дүрвэгсдийн тоог 93300³ гэж үзсэн байна.

Карабах "Бүгд Найрамдах Улсын" хүн амыг газар нутагт нь дахин суурьшуулах нь Оросын ашиг сонирхол бөгөөд Ереван болон Степанакертийн улс төрийн нэн тэргүүний зорилт юм гэж талууд мэдэгдэж байна.

Дүгнэлт. Уулын Карабахын асуудалд олон улсын зарим байгууллагууд болон улс орнуудын байр суурь янз бүрээр тодорхойлогдож байна. Тухайлбал, НҮБ болон Европын холбоо нь Уулын Карабахын тусгаар тогтнолыг одоо ч хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд Азербайжаны нэг хэсэг гэж үздэг. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Минскийн бүлгийн хүрээнд Уулын Карабахын асуудлыг шийдвэрлэх тухай хэлэлцээг 1992 оноос хийж байгаа боловч Уулын Карабахын статусын тухай одоо болтол тохиролцож чадаагүй байна. Учир нь Азербайжаны тал уг асуудлыг тус орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг

¹ interfax, November 12, 2020

² Mil.ru

³ News.am,

хэвээр хадгалах үндсэн дээр шийдвэрлэх ёстой гэсэн зарчмыг хатуу баримталж байгаа бол Армений тал ард түмний өөртөө засах эрхийг хүндэтгэх зарчмын дагуу, Уулын Карабахын ард түмний хүсэл зоригийг харгалзан шийдвэрлэх ёстой гэсэн байр суурьтай байдаг.

Уулын Карабахын нийт хүн амын 99 хувь нь апостол шашинт Арменчууд бөгөөд үлдсэн хэсэг нь энэхүү нутагт анх амьдарч байсан исламын шийт урсгалыг шүтэгч уугуул Азербайжанчууд юм. Уулын Карабахын асуудал бол ганцхан тус нутагт амьдарч байгаа хүн ам, тэдний газар нутгийн бүрэн бүтэн байдлын тухай биш бүс нутгийн эдийн засаг, аюулгүй байдал талаасаа ОХУ, Турк, Иран зэрэг хөрш зэргэлдээ орнуудын хувьд чухал эрх ашгийг хөндөж болох эмзэг асуудал юм.

ОХУ Арменд зөвхөн зэвсэг, техник нийлүүлээд зогсохгүй, өөрийн цэргийн 102 дугаар баазыг байршуулсан байдаг нь тус улсыг болон ТУХН-ийн орон зайг гадны аюул заналаас хамгаалах баталгаа болдог гэж эх сурвалжууд үздэг.

Байлдааны ажиллагааны үеэр Оросын тал Ереван болон Бакутай харилцан төвийг сахисан байр сууринаас хандаж байсан. Харин байлдааны ажиллагааны үеэр дор дурдсан гурван тохиолдолд Арменид байрлаж буй Оросын цэрэг байлдаанд оролцож болзошгүй гэж зарим эх сурвалжууд мэдээлсэн байдаг. Үүнд;

1. Азербайжаны /эсвэл Туркийн/ цэрэг Армений нутагт цөмрөн орвол;
2. Азербайжаны /эсвэл Туркийн/ цэргийн нисэх хүчин Армени болон Оросын цэргийн онгоцнууд, нисдэг тэргүүд байрлаж буй аэродромууд руу пуужингаар харваж, бөмбөгдсөн тохиолдолд;
3. Азербайжаны /эсвэл Туркийн/ цэрэг Уулын Карабахын хэд хэдэн районыг эзлэн авсан тохиолдолд гэж үзсэн байдаг.

Туркийн хувьд стратегийн зорилго нь бүс нутагт цэрэг улс төрийн нөлөө бүхий хүчирхэг гүрний дүрд тоглохыг хичээж Баку-тай хамтарсан байлдааны сургуулилт хийснээр Азербайжанчуудыг цэргийн ажиллагаа явуулахад турхирч,

Арменыг дам байдлаар сүрдүүлсэн үйлдэл хийсэн байдаг. Энэ байдлаа ч тухайн үед олон улсад илтээр илэрхийлж Турк улс шашин нэгт болон хамтын олон талт ажиллагааны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор "хэлэлцээрийн ширээний ард ч, байлдааны талбарт ч "ах дүүгийн харилцаат" Азербайжанд туслахад бэлэн гэж мэдэгдэж байсан.

Азербайжаны хувьд Ерөнхийлөгч Ильхам Алиевын хувьд сонгуулийн үеэс эхлээд л дэвшүүлсэн мэдэгдэл болох эдийн засгаа хүчирхэгжүүлэн, авлига хээл хахуультай хатуу тэмцэх асуудал нь амжилтгүй болж, улс орных нь эдийн засаг урдын адил нефть, байгалийн хийн экспортоос хамааралтай хэвээр байсан нь цар тахлын үеэр илүүтэйгээр улсын төсөвт хүчтэй цохилт өгсөн. Эрх баригчдын зүгээс бүхий л хүчин чармайлтаа цар тахалтай хийх тэмцэлд чиглүүлснээр хүн амын худалдан авах чадвар доройтож ард түмний дунд төр засгийнхаа ажиллагаанд тун сэтгэл дундуур байсан. Арментай явуулж байсан зэвсэгт мөргөлдөөн олон нийтийн анхаарлыг эдийн засгийн хүнд байдлаас илүүтэйгээр өөр зүгт хандуулж бүрэн эрхийн хугацаагаа сунгах боломжийг Алиевт олгоно гэж үзсэн.

Ираны хувьд хилийн хот суурингууд Азербайжаны цэргийн довтолгоонд өртсөнтэй холбоотойгоос гадна зэвсэгт мөргөлдөөн цаашид өргөжсөн тохиолдолд Армений талыг дэмжих зорилготой байсан байж магадгүй гэж ажиглагчид таамаглаж байв.

Гүрж улсын тухайд төвийг сахисан байр суурьтай, учир нь Гүржид 800 мянга орчим Азербайжанчууд, 500 мянга орчим арменчууд оршин суудаг гадна Армен улс Гүржээр дамжин стратегийн түнш болох Оростой харилцаж, Гүржээр дамжуулан Оросоос хий авдаг бол Азербайжан нефть, хийгээ Гүржээр дамжуулан Туркэд нийлүүлдэг. Тиймээс Гүрж бол аль ч талтай нь хамтын ажиллагааны олон талт хэлэлцээрийн дагуу эдийн засгийн хувьд харьцангуй ойрхон харилцаатай юм. 2020 оны мөргөлдөөн Өмнөд Кавказын хийн хоолойноос 30-40 км-ийн зайд болж байсан учраас олон улс судлаачид



Азербайжаны нефтийг дэлхийн зах зээлд хүргэдэг Баку-Тбилиси-Жейханы нефть хий дамжуулах дэд бүтцэд хөнөөл учруулж болзошгүй гэж үзэж байсан. Магадгүй байлдааны ажиллагаа өргөжиж энэ таамаглал бодит болсон бол Гүржийн ашиг сонирхол хөндөгдөх байсан.

Армений хувьд ОХУ-ын байр суурийг илүүтэйгээр анхаарсан байр суурьтай байсан. Армени улс Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллагын /ХАБГБ/ гишүүн бөгөөд уг байгууллагад одоогоор Орос, Арменаас гадна хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Беларусь, Казахстан, Киргиз, Тажикистан улс багтдаг. ХАБГБ-ын аль нэг гишүүн улс гадны халдлагад өртсөн тохиолдолд бие биедээ харилцан туслалцахаар гэрээнд заасан байдаг. Харин Уулын Карабах бол Азербайжаны газар нутаг мөн гэдгийг олон улсын эрхзүйгээр үздэг, нөгөө талаас ХАБГБ-ын гишүүн орнууд уг ажиллагаанд татагдан орох нь тийм ч зөв шийдэл биш байсан бөгөөд аль нэг талын байр суурийг хамгаалж орох үндэслэлгүй байсан.

Бүс нутгийн аюулгүй байдалд Уулын Карабахын асуудал чухал байр суурь эзлэх эсэх нь их гүрнүүдийн оролцоо, ашиг сонирхлоос нэлээдгүй шалтгаалах юм. Хэдийгээр их гүрний ивээл дор байдаг ч олон улсын эрх зүйгээр тусгаар тогтнол нь хүлээн зөвшөөрөгдөөгүй,

газарзүйн хувьд алслагдсан, далайд гарцгүй дэлхийн цэрэг улс төрийн тоглогч улс орнуудад стратегийн ач холбогдол багатай жижиг "улс"-ын ирээдүй тийм ч нэн чухал асуудал биш. Ялангуяа Уулын Карабахын тусгаар тогтнол, хоёр талын мөргөлдөөнийг шийдвэрлэх асуудалд АНУ, Европ, Азийн хүчирхэг тоглогч нар болон бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагууд идэвхтэй байр суурьтай байгаагүй. Хэрэв хөрш орнууд сөргөлдөгч талуудын аль нэгийг нь талд орж нөгөөгийн эсрэг үйл ажиллагаа явуулсан тохиолдолд магадгүй олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллага, эвсэл холбоод татагдан орж ашиг сонирхлоо илэрхийлж болох юм. ОХУ-ын хувьд бүс нутгийн үндсэн нэг тоглогчийн хувьд, Уулын Карабах, Азербайжаны асуудалд түүхэн уламжлалт харилцаанд үндэслэн гал зогсоох хэлэлцээрийг байгуулж энхийг сахиулах хүчийг оруулсан. Гэхдээ энэ нь асуудлыг бүрэн шийдвэрлэж байгаа хэрэг биш учраас Уулын Карабахын хувьд олон улсын тавцанд НҮБ, олон улсын бусад хууль эрх зүйн хэм хэмжээнд өөрийн статусыг хүлээн зөвшөөрүүлэх асуудалд олон талт улс төрийн дипломат арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь энх тайван аж төрөх ирээдүйн боломж байж болох юм.

Ашигласан материал:

1. interfax, November 2020 ,12
2. Mil.ru
3. News.am,



КОРОНАВИРУС “КОВИД–19” ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭЖ БҮЙ ОЛОН УЛСЫН ЗАРИМ ТУРШЛАГА СУРГАМЖ

П.ЦЭДЭВ /БХЭШХ-ийн ЭШТА, доктор (Ph.D), профессор/
Ж.ДАМБАДАРЖАА /Магистрант, хошууч/

Түлхүүр үг: Коронавирус, цар тахал, сахилга, хариуцлага

Key words: Coronavirus, pandemic, discipline, perponsibility

Хураангуй. Коронавирус “COVID-19” цар тахалтай тэмцэх нь дан ганц Засгийн газар, УОК, Онцгой байдлын ерөнхий газар, ЭМЯ-ны ажил биш нийт төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн үүрэг хариуцлагын хамгийн чухал асуудал болох нь харагдаж байна.

Иймд цар тахалтай тэмцэж ирсэн дэлхийн зарим улс орны хууль, эрхийн баримт бичиг, түүнийгээ хэрэгжүүлж ирсэн туршлага, сургамжийн талаар авч үзнэ.

Корона “COVID-19” вирусийн тухайд...

Корона “COVID-19” вирус нь энгийн савангийн хөөсөнд үхнэ. 2 метрээс илүү тархаж чадахгүй, тэр зориулалтын маскийг нэвтэлж бас чадахгүй, гадаргуу дээр 3-72 цаг амьдрах чадвартай тийм дүр төрхтэй амьтан юм. Тийм учраас түүнээс бид хамгаалах боломж байна гэсэн үг. Ийм тохиолдолд гараа савандаж 20 секунд угаагаад, амаа өдөрт 2 удаа бидний хэрэглэж заншсан жанц давс, содын уусмал гэх мэт ариутгалын уусмалаар зайлаад, маскаа зүүж, хүмүүсээс 2 метрээс доошгүй зай бариад, гэр, ажлын байртаа агааржуулалт тогтмол хийгээд, нойтон цэвэрлэгээ хийж, олон хүнтэй газар явахгүй, битүү орчинд удаан суухгүй, халуун хоол, цайгаа хэрэглэж биеийн дархлаагаа сайн байлган, вакцинжуулалтын 2 ба 3 тунгаа хийлгэсэн тохиолдолд “COVID-19” вирусээс хамгаалж болох боломжтойг эмч нар байнга сануулж, зөвлөж байгаа билээ. Ингэж чадахгүй байгаа нь бидний өөрсдийн хэнэггүй зантай холбож үзэхээс өөр арга байхгүй. Хатуу хөл хорио тогтоохоор эдийн засаг сөнөлөө, мөнгө байхгүй, үхлээ гэх мэтээр л орилж гардаг тал ч бий. Олон нийтийг хамарсан хурал, цуглаан хийх, байгууллага, иргэд нь хорио

цээрийн дэглэмээ барихгүй байж байгаад халдварыг тархаана.

Ер нь бол хөл хорио тогтоох нь уг өвчнийг түр зуурын намжаах л арга болохоос бүрэн хамгаалах арга биш болох нь амьдралаас харагдаж байгаа нь үнэн билээ. Ийм үед дэг журмыг хатуу баримтлан ажиллах зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх цар тахлын хорио цээрийн дэглэмийн үед сахилга бат, дэг журмыг чангатгах зайлшгүй шаардлага үүсэж байгааг тэмдэглээд “Бидэнд нэг вакцин бий. Тэр нь сахилга, хариуцлагын вакцин” гэж анхааруулж байсан билээ.

“COVID-19” цар тахалтай тэмцэж буй дэлхийн зарим орны хуулийн заалт, түүнийг хэрэглэж буй туршлагаас авч үзсэн нь

Дэлхийн зарим улс орнуудын “COVID-19”-ийн үед авч буй хөл хорио, тусгаарлалтын дүрэм журам, шийтгэлийг судалсан олон туршлага, сургамжийн материал нэлээд байна.

Шинэ Зеландын шүүх нэгэн эмэгтэйг тусгаарлалтын байрнаас оргосны төлөө 14 хоногийн хорих ял оногдуулж байжээ. Шүүхээс мөн түүний 18 настай охиныг шийтгэсэн боловч энэхүү шийтгэл цуцалсан байна. Тухайн эмэгтэй “COVID-19”-ийн нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа 2020 актыг зөрчин 14 хоногийн тусгаарлалтыг дуусгалгүй хөл хорионы байрнаас зугтсан тул шийтгүүлжээ. Шинэ Зеландын “COVID-19”-ийн Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны Акт 2020-ийн ялын дээд хэмжээ нь 6 сар хорих эсвэл 4000 шинэ Зеланд доллароор торгох заасан байдаг ажээ.

2020 оны 5 сарын 13-ны өдөр “COVID-



19"-ийн Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны Акт 2020-ийг Шинэ Зеландад баталсан байна. Энэхүү акт нь "COVID-19"-ийн үед дахь бизнесүүдэд тавигдах шаардлага болон нийтийн цуглаан болон хөл хөдөлгөөний хязгаарлалт зэргийг багтаасан бөгөөд "COVID-19"-ийн үеийн хуулийн орчныг бүрдүүлж өгсөн байна. Тухайн акт тэр доороо үйлчилж улс орон дөрвөн түвшинт бэлэн байдлын системийн 2-р түвшний бэлэн байдалд шилжсэн байдаг. Үүнээс өмнө байсан хуулийн дагуу асуудлуудыг шийдвэрлэж, хуулийн орчныг бүрдүүлж байжээ.

Актын 20-25 дугаар зүйлд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдээр мэргэжилтнүүдэд хэд хэдэн боломж /хүч чадал/-ийг олгогдсон байна. Тухайлбал, тусгай зөвшөөрөлгүйгээр нэвтрэх, бусдад чиглэл өгөх, зам хааж тээврийн хэрэгслийг зогсоох, биеийн байцаалт өгөхийг шаардах болон бизнесүүдийг хаах зэрэг багтжээ. Энэхүү актын 26-32 дугаар зүйлд гэмт хэрэг болон зөрчлийн талаар дэлгэрэнгүй заажээ. Тухайн гэмт хэргүүд хамгийн дээд талдаа NZ4000\$ эсвэл 6 сар хүртэлх хорих ялаар шийтгэгдэж байна. Харин зөрчлийн хувьд 11-р зүйлд заагдсанаар 300 Шинэ Зеланд доллар буюу 186 америк доллар байгаа бөгөөд шүүх 620 америк доллар хүртэл нэмэгдүүлж ноогдуулж болох ажээ.

Энэхүү актын дагуу 10 хүртэлх хүн цуглахыг зөвшөөрсөн бөгөөд тухайн хүмүүс бүгд бие биеэ мэддэг байх, эсвэл ямар нэгэн байдлаар холбоо барих боломжтой байх ёстой ажээ. Оршуулгын ёслолд 50 хүртэлх тооны хүмүүс цуглах боломжтой. Бизнесүүдийн хувьд хүн хоорондын зайг 2 метр байлгах ёстой бөгөөд 10 хүртэлх тооны гэр бүлийн хүмүүс түүнээс илүү ойр байж болно. Ажилчид хамгийн багадаа 1 метрийн зайтай байх ёстой бөгөөд хавьтлын тохиолдлыг бүртгэж байх ёстой. 5 дугаар сарын 25-нд Засгийн газрын зарласнаар 5 дугаар сарын 29-өөс 100 хүртэлх хүний цугларалтыг зөвшөөрсөн ба бизнесийн зай барих шаардлагыг 1 метр болгож бууруулсан байна. Тухайн үед буюу 5 дугаар сарын 26-нд Шинэ Зеланд улс "COVID-19" 2-ийн идэвхтэй 22 тохиолдолтой байсан ба нийт 1504

тохиолдол бүртгэгдэж 21 хүн нас барьсан байв.

Англи Улсын хувьд офисоос бусад баар, ресторан зэрэг ажиллах нь хууль бус бөгөөд 200\$-ийн торгуультай байх ба давтсан тохиолдолд 6400\$ хүртэл торгуулийг нэмэгдүүлнэ.

Гэрийн тусгаарлалт ажиглалтыг хүндэтгэх шалтгаангүйгээр зөрчсөн хүнийг 4000\$-ээр торгож байгаа ажээ.

Шинжилгээнд орохдоо санаатайгаар бусдын нэрийг өгсөн тохиолдолд 1000\$-ийн торгууль төлнө.

Гэрээр тусгаарлаж өөрийгөө ажиглаж буй ажилтан ажил олгогчдоо хэзээ эхлэх болон хэзээ дуусахыг мэдэгдэх ёстой. Үгүй тохиолдолд 50\$-ийн торгууль төлөх болно.

Бизнес эрхлэгчид зөрчил үүсгэсэн тохиолдолд 1000\$-ийн торгууль төлнө. Дэлгүүр, нийтийн тээвэр болон таксинд суухдаа амны хаалт зүүгээгүй хүнийг 100\$-ээр торгох ба давтсан тохиолдолд 200\$ болох ажээ. 6 болон түүнээс дээш хүн нэг дор цугларахыг хориглосон ба эдгээр 6 хүн дээд тал нь хоёр гэр бүлийн хүмүүс байх боломжтой. Харин Хойд Ирландад зөвхөн нэг гэр бүлийн хүмүүс байх боломжтой.

Оросын Холбооны Улс вирусийн эсрэг хуулийг баталсан ба хүнд гэмт хэрэгт 7 жилийн хорих ял оноохоор болсон ажээ. Тухайн үед нийт 2337 тохиолдол бүртгэгдэж 17 хүн нас барьсан байсан. Хамгийн хүнд шийтгэл буюу долоон жилийн хорих ялыг корона вирустэй хэн нэгэн хөл хориог зөрчиж, түүнээс халдвар авсан хүн нас барьсан тохиолдолд өгөх ажээ. Мөн энэхүү хуульд энгийн гэрийн тусгаарлалтыг зөрчсөн тохиолдолд оногдуулах хүнд торгуулиуд багтсан ажээ. Цар тахалтай холбоотой худал мэдээ тараасан иргэний 5 хүртэлх жилээр хорих шинэ хуулийг хэлэлцүүлж байсан. Засгийн газар орон нутгийн удирдлагуудад таарах хариу арга хэмжээ шийтгэл оногдуулах эрх мэдлийг өгсөн байдаг. Орос Холбооны Улсын хувьд 4 дүгээр сарын 2-оос эхлэн хөл хорио болон гэрийн тусгаарлалтыг зөрчсөн хувь хүнийг 4000 рубль буюу 50 доллароор торгох ба давтан үйлдсэн тохиолдолд 5000 рубль буюу 63\$-аар торгох ажээ. Бизнесүүд шаардлага дүрэм,



журмыг зөрчсөн тохиолдолд 40000 рубль буюу 500\$-аар торгох ажээ. Хуулийн этгээдүүд 300000 рублиэр давтан үйлдсэн тохиолдолд 500000 рубль буюу 6300\$-оор торгуулах ажээ. Өмнөх мэдээлэлтэй ижил хуулийн талаарх мэдээллийг өөр эх сурвалжаар бататгаж байна. Хувийн ариун цэврийн дүрэм болон стандартыг зөрчсөн хувь хүнд 40000 рубль буюу 510\$-ийн торгууль оногдуулах ба албан байгууллагын тушаалтанд 150,000 рубль (1900\$) хүртэлх торгууль оногдуулна. Харин албан байгууллагад 500,00 рубль буюу 6350\$-ийн торгууль оногдуулж байгууллагын үйл ажиллагааг 90 хоног зогсоох ажээ.

Гэмт сэдлээр бус буюу санаандгүй байдлаар стандарт шаардлагуудыг зөрчин үр дүнд нь өвчлөл эсвэл нас баралт үүссэн тохиолдолд торгуулиуд нэмэгдэж компанийн ажилтанд 500,000 рубль харин компанид 1,000,000 рубль болно. Мөн адил үйл ажиллагааг 90 хоног зогсооно. Гэрийн тусгаарлалтыг зорчин машинтай зорчсон тохиолдолд 5000 рублиэр (65\$) торгож машиныг нь саатуулна.

Харин ариун цэврийн стандартыг болон хязгаарлалтыг зөрчин олон нийтийн өвчлөл үүсгэсэн тохиолдолд 2 жил хүртэл хорих ажээ. Үүнээс үүдэн нэг хүн нас баривал 5 жилийн хорих ял оноох ба хоёр болон түүнээс дээш хүн нас барсан тохиолдолд 7 жил хүртэлх хорих ялаар шийтгүүлэх ажээ.

БНХАУ-ын Нийгмийн Аюулгүй байдлын удирдлагын зөрчил буюу улсын шийдвэр болон үүргийг биелүүлээгүй тохиолдолд 5-10 хоног хорих ял оноож байгаа ажээ. Qingshan дүүргийн шуудангийн газарт нэгэн хүн маскгүй явж байсан ба хэдий гэмт хэрэг үйлдээгүй ч тухайн хуулийн дагуу цагдаагийн шаардлагыг биелүүлээгүйн улмаас 5 хоног баривчлагджээ. Мөн 1-7 жилийн хорих ялыг халдварт өвчний эмчилгээнд саад болсон гэмт хэрэгт оногдуулж байгаа ажээ. Хот хоорондын тээврийн бизнес эрхэлдэг нэгэн хүн замын хөдөлгөөн хааж, хөл хорио тогтоосон байхад 2 удаа хулгайн тээвэр хийсэн ба тун удалгүй "COVID-19"-тай болох нь тогтоогдсон ба 20 хүнтэй

хавьтал орсон байжээ. Түүнд нэг жилийн хорих ял оноосон байна.

Вьетнам Улс. Тус улсын төрийн мэдээллийн агентлагийн мэдээлснээр ковидын хорио цээрийн хатуу дүрмийг зөрчиж, бусдад вирус тараасан 28 настай Ле Ван Три иргэнд шүүх таван жилийн хорих ял оноожээ. Шүүх хурал 2021 оны 9 дүгээр сард өмнөд нутгийн Ка Мау мужид болсон байна. Ле Ван Три гэх иргэн Хо Ши Мин хотоос Ка Мау руу буцахдаа 21 хоногийн хорио цээрийн дүрмийг зөрчжээ. Улмаар найман хүнд халдвар тараасан бөгөөд тэдний нэг нь нэг сарын эмчилгээ хийлгэсний дараа вирусийн улмаас нас барсан болохыг тус улсын хэвлэлүүд мэдээлсэн байна. Вьетнам нь олон нийтийг хамарсан ковидын шинжилгээ хийж, ойрын хавьтлуудыг илрүүлж, хилийн хатуу хязгаарлалт, хорио цээрийн дэглэм тогтоосны ачаар коронавирусийг амжилттай хяналтдаа авсан ч 4 дүгээр сарын сүүлээс хойш халдварын шинэ кластерууд үүсэж энэ амжилтыг нь сүйтгэсэн байдаг. Вьетнамын өмнөд хязгаарын муж болох Ка Мауд цар тахал эхэлснээс хойш ердөө 191 тохиолдол бүртгэгдэж, хоёр хүн нас баржээ. Харин Хо Ши Мин хотод 260,000 орчим тохиолдол, 10,685 хүн нас баралт бүртгэгдээд байгаа юм. Вьетнамд нийт 536,000 гаруй хүнд халдварлаж, 13,385 хүний аминд хүрсэн ковидын дэгдэлтийн эсрэг Засгийн газар тэмцэж байгаа бөгөөд тогтоосон хязгаарлалт, дүрмүүдийг зөрчсөн хэргээр мөн хоёр хүнийг 18 сар болон хоёр жилийн тэнсэн харгалзах ялаар шийтгээд байгаа юм.

АНУ-д Коронавируст халдварт /COVID-19/ цар тахлын үе хэрэгжүүлж буй арга хэмжээ

2021 оны эхээр АНУ-ын Дэлхийн эрүүл мэндийн хүрээлэнгээс тус улсын COVID-19 цар тахлын 1 жилийн хугацааны байдал судалгаа хийж дараах дүгнэлтүүдийг гаргаж хариу арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүнд:

COVID-19 цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг зохион байгуулахад үндэсний хэмжээнд удирдлага зохион байгуулалт сул байсныг залруулахын тулд:

- муж, орон нутгийн засаг захиргаа,



- агентлагуудын харилцан ажиллагаа, үүрэг хариуцлагыг тодорхой болгов;
- Конгрессын зүгээс үндэсний эрх ашгийг, улс төрөөс дээгүүр тавьж, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хурдан шуурхай зохион байгуулахад шаардлагатай хуулийг гаргав;

Эрүүл мэндийн голлох үүрэгтэй байгууллагуудад улс төрийн оролцоог хязгаарласан.

АНУ дэлхий нийтийг хамарсан цар тахлаас дангаараа ангид байж чадахгүй нь тодорхой. Иймд хамтын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах тулд:

- АНУ дэлхийн дархлаа судлалд идэвхтэй оролцож, санхүүжүүлнэ;
- аливаа цар тахлын эсрэг дэлхий нийтээрээ бэлэн байх, сөрөг арга хэмжээ авах үйл хэрэгт идэвхтэй оролцож санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

АНУ Ковид-19 цар тахалтай тулгарсан 1 жилийн хугацааны үйл ажиллагаандаа судалгаа хийж цаашид доорх 4 үндсэн чиглэлээр ажиллахыг чухалчилсан байна. Үүнд:

1. Үр дүнтэй, манлайлалтай сайн засаглалтай байх.
2. Засгийн газрын үйл ажиллагааг ил тод, шударга, ойлгомжтой хүргэх үр дүнгээс хамаарах Төр-иргэний холбоо, итгэлцэлийг бэхүүлэх.
3. Дэлхий нийтээрээ ШҮ-д илтгэж

вакцинжуулалтад хамрагдах.

4. "Бүх улс орон аюулаас ангижиртал нэг ч улс орон аюулаас ангид байж чадахгүй" гэсэн уриан дор хамтран ажиллах зэргийг онцолцжээ.

Манай оронд коронавирус "COVID-19" цар тахалтай тэмцэх ажлыг эрчимжүүлэхийг Монгол Улсын ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ОБЕГ, УОК-ын шуурхай штабт ажиллах үедээ тодорхой үүрэг өгч байсан билээ. Тэрээр "УОК-т коронавируст цар тахалтай тэмцэх нэгдсэн төлөвлөгөөгөө шинэчлэхийг үүрэг болгоод эдийн засаг бизнесээ дэмжихийн зэрэгцээ, асуудлыг цогцоор нь хэрхэн шийдвэрлэж болохыг шинжлэх ухааны судалгаанд суурилан ул суурьтай боловсруулах нь чухал гээд Засгийн газар, УОК, УОК-ын Шуурхай штаб, ЭМЯ, Нийслэлийн онцгой комисс бүгд ажиллах арга барилаа шинэчлэх, уялдаа холбоогоо сайжруулах шаардлагатай байна. Цар тахлын эсрэг дайнд ялалт байгуулахын төлөө хамтран ажиллая. Хандлагаа өөрчилж эс чадвал хатуу хариуцлага тооцож явах болно гэдгээ ч хэлсэн билээ.

Дүгнэлт. Олон улсын туршлага, сургамж үзэхэд цар тахалтай тэмцэхдээ хууль эрх зүйн хатуу хариуцлага хүлээлгэн тооцдог байна. Энэ байдлаас үзэхэд манай оронд эрх зүйн баримт бичигтээ өөрчлөлт оруулах, гаргасан хууль эрх зүйн шийдвэрээ хэрэгжүүлдэг, хариуцлага хатуу тооцдог байх шаардлагатай юм.

Ашигласан материал:

1. Нийтлэгдсэн он сар: 2020/10/09 Эх сурвалж: <https://www.aa.com.tr/en/asia-pacific/woman-sentenced-over-covid-19-rules-violation-in-nz/2000801>
2. Эх сурвалж: <https://www.loc.gov/law/foreign-news/article/new-zealand-new-covid-19-public-health-response-legislation-enacted/>
3. Эх сурвалж: <https://www.bbc.com/news/world-europe52109892->
4. Эх сурвалж: <https://www.themoscowtimes.com/01/01/2021/coronavirus-in-russia-the-latest-news-jan-1-a69117>
5. Эх сурвалж: <https://globalcompliancenews.com/russia-increases-punishments-for-violations03042020/>
6. Эх сурвалж: <https://www.perkinscoie.com/en/news-insights/peoples-republic-of-china-legal-liability-alert-on-covid19-.html>
7. Эх сурвалж: The Guardia



ЯПОН УЛСЫН ЧӨЛӨӨТ БА НЭЭЛТТЭЙ ЭНЭТХЭГ–НОМХОН ДАЛАЙН СТРАТЕГИ /FOIP/

А.АМАРТАЙВАН /БХЭШХ-АББХСТ-ийн ЭША, магистрант/

Түлхүүр үг: Чөлөөт Нээлттэй Энэтхэг Номхон далай, Аюулгүй байдлын дөрвөн талт яриа, хэлэлцээр

Key words: FOIP- Free and Open Indo Pacific, QUAD- Quadrilateral Security Dialogue

Оршил. 2007 онд Японы ерөнхий сайд асан Шинзо Абэ Энэтхэг улсын парламентад хэлсэн үгэндээ "Чөлөөт Ба Нээлттэй Энэтхэг Номхон Далай" нэр томъёог анх дурдсан. Тэгвэл 2016 оны 8-р сард Кени улсын нийслэл Найроби хотод болсон Африкийн хөгжлийн бага хуралд Ерөнхий сайд асан Шинзо Абэ хэлсэн үгэндээ "Чөлөөт Ба Нээлттэй Энэтхэг Номхон Далай" стратегийн бодлогоо тодорхойлсон бөгөөд түүний хэлсэн үгэнд Ази, Африкийг холбодог зүйл бол далайн зам юм. Дэлхийд тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийг өгөх зүйл бол чөлөөт нээлттэй хоёр далай, хоёр тивийн эвсэл бөгөөд Номхон далай ба Энэтхэгийн далай, мөн Ази тив, Африк тивийн уулзварыг албадлагаас ангид байлгаж эрх чөлөө, хууль ёсыг дээдэлж, зах зээлийн эдийн засгийг эрхэмлэдэг бүс болгон төлөвшүүлж, хөгжил дэвшлийг авчрах нь Япон улсын үүрэг юм хэмээн мэдэгдсэн¹. Японы "Чөлөөт ба Нээлттэй Энэтхэг-Номхон далай" стратегийн бодлогыг бүс нутгийн болон дэлхийн бусад улс орнууд өөр, өөрийн түвшинд ялгаатайгаар хүлээж авдаг. Японы FOIP-ийн бодлого нь нэг талаараа БНХАУ-ын өсөн нэмэгдэж байгаа хүч, бүс нутаг дахь нөлөөллийг хумих зорилго бүхий эвсэл байгуулахыг чухалчилсан аюулгүй байдлын хүчтэй агуулгатай гэж зарим улс орнууд үздэг бөгөөд тэр дундаа БНХАУ-тай стратегийн түншлэл бүхий "Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг" (АСЕАН)-ийн улс орнуудын хувьд Японы "FOIP" стратегийн бодлогод нэгдэх болон хүлээн зөвшөөрөхөд хүндрэлтэй төдийгүй

болгоомжлох тал харагддаг. АСЕАН-ын улс орнуудыг "FOIP"-д хамруулахыг эрмэлзэж байсан Японы тал "FOIP"-ийн аюулгүй байдлын зарим нэг бүрэлдэхүүн хэсэгт анхаарал хандуулж, БНХАУ болон түүний хэрэгжүүлж байгаа "Нэг Бүс Нэг Зам" санаачилгад тэрсэлсэн бус илүү зөөлөн өнгө аястай бодлого баримтлахаа илэрхийлж, "Чөлөөт ба Нээлттэй Энэтхэг-Номхон далай" стратегийн бодлогын томъёоллоо "Чөлөөт ба Нээлттэй Энэтхэг-Номхон далайн Алсын Хараа" болгон өөрчилсөн. Энэхүү өөрчлөлт нь үр дүнгээ өгч АСЕАН-ын улс орнууд "FOIP"-ийг зарим нэг талаар хүлээн зөвшөөрч эхэлснээс гадна БНХАУ улс Японы "FOIP"-ийг албан ёсоор эсэргүүцсэн мэдэгдэл гаргаагүй байна. Харин Ерөнхийлөгч асан Барак Обамагийн үеэс гадаад бодлогын тэргүүлэх чиглэлээ Ази-Номхон далайн бүс рүү чилүүлээд байгаа АНУ нь Японы ерөнхий сайд асан Шинзо Абэгийн "FOIP"-ийн санал санаачилгыг гарсан цагаас нь дэмжсэн гэхэд буруудахгүй. АНУ-ын ерөнхийлөгч асан Доналд Трамп 2017 оны 11 дүгээр сард Вьетнам улсад болсон Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл (АРЕС)-ийн дээд хэмжээний уулзалтын үеэр хэлсэн үгэндээ Японы FOIP-ийг дэмжиж байгаагаа илэрхийлэн, олон янзын хэл, соёл бүхий тусгаар тогтносон олон улстай хамтран, Чөлөөт ба Нээлттэй Энэтхэг номхон далайн алсын хараа бодлогыг хэрэгжүүлж, хамтдаа хөгжин дэвшиж чадна хэмээн мэдэгдэж² АНУ-д FOIP-ийг стратегийн бодлогын хэмжээнд авч үзэж эхэлсэн.

Японоос ялгаатай нь АНУ-ын FOIP-

¹ "Address by Prime Minister Shinzo Abe at the Opening Session of the Sixth Tokyo International Conference on African Development (TICAD VI)," August 27, 2016, at the Kenyatta International Convention Centre (KICC), Nairobi, Kenya.

² <https://asean.usmission.gov/remarks-president-trump-asean-ceo-summit-da-nang-vietnam/>



ийн тодорхойлод БНХАУ-ын өсөн нэмэгдэж байгаа хүч, түүнээс ирэх сорилт нь олон улсын хамтын нийгэмлэгийн ашиг сонирхолд заналхийлж байна гэж үзэн БНХАУ-ын өсөн нэмэгдэж байгаа хүч, түрэмгий бодлогыг хязгаарлах гэж тодорхойлсон.

Тэгвэл АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Жое Байдены засаг, захиргааны гадаад бодлогод БНХАУ-ын эсрэг агуулга бүхий нэр томьёо хэрэглэхээс зайлсхийж "аюулгүй цэцэглэн хөгжсөн Энэтхэг-Номхон далайн бүс нутаг" гэх хэллэгийг илүүтэйгээр хэрэглэж байсан нь АНУ-ын холбоотнуудад Жое Байден БНХАУ-тай харилцах харилцаанд илүү зөөлөн бодлого явуулах хардлагыг төрүүлсэн. Гэсэн хэдий ч Ерөнхийлөгч Жое Байдены засаг захиргаанаас гаргасан Үндэсний аюулгүй байдлын стратегийн удирдамжид БНХАУ-ыг тогтвортой, нээлттэй олон улсын тогтолцоонд эдийн засаг, цэрэг, технологийн хүчээ нэгтгэх чадвартай цорын ганц өрсөлдөгч гэж тодорхойлсон нь АНУ-ын өмнөх засаг захиргаанаас илүү хатуу бодлого баримтлах дүр зураг харагдаж байгааг олон улсын судлаачид онцолж байна. Японы Ерөнхий сайд Суга Ёшихидэ 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр ерөнхий сайдаар сонгогдсоны дараа хийсэн анхны хэвлэлийн бага хурал дээр АНУ-тай тогтоосон эвслийг амжилттай байгааг илэрхийлээд цаашид Японы үндэсний ашиг сонирхлыг хамгаалахын тулд "FOIP" стратегийн бодлогыг үргэлжлүүлэн явуулахаа мэдэгдсэн. БНХАУ-ын цэрэг, эдийн засгийн хүч өсөхийн хэрээр АНУ-Японы харилцаа улам нягтаршиж байна. Японы "Чөлөөт ба Нээлттэй Энэтхэг Номхон Далай" (FOIP) стратегийн бодлого нь Энэтхэг-Номхон далайн бүс нутагт чөлөөт, нээлттэй олон улсын ашиг сонирхолд нийцсэн албадлагаас ангид олон улсын хууль, гэрээ конвенцыг дээдэлсэн тогтвортой хөгжил цэцэглэлт, энх-тайвныг цогцлоох гэсэн үндсэн тодорхойлолтоос гадна эдийн засаг, аюулгүй байдлын салбар болон засаглалын хувьд ижил

төстэй орнуудтай түншлэл бий болгон бүс нутгийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, нөгөөтэйгүүр БНХАУ-ын өсөлтийг хязгаарлах зорилготой гэж олон улсын аюулгүй байдлын судлаачид үздэг. Энэ хүрээнд 2007 онд Японы Ерөнхий сайд асан Шинзо Абэгийн санаачилгаар АНУ Австрали, Энэтхэг улсуудын дэмжлэгтэйгээр байгуулагдсан. "QUAD" буюу аюулгүй байдлын 4 талт яриа хэлэлцээр нь 2008 онд тухайн үеийн Австралийн ерөнхий сайд Кевин Рудд Австрали улсыг хэлэлцээрээс гаргаснаар зогсож байсан хэдий ч 2017 оны 11 дүгээр сар болон 2018 оны 6 дугаар сард болсон АСЕАН-ы дээд хэмжээний уулзалтаар "QUAD"-ын улсууд зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулснаар дахин сэргэсэн. Албан бусаар Япон, АНУ-ын FOIP-ийн стратегийн бодлогыг тулгуур бодлогоо болгосон дөрвөлийн уулзалт БНХАУ-ын хүчтэй эсэргүүцэлтэй тулгардаг боловч 2019 онд АНУ-ын Нью Йорк хотод дээрх 4 улсын гадаад хэргийн сайд нар анхны албан ёсны 4 талт уулзалтыг зохион байгуулсан³. 2020 оны 10 дугаар сард Япон улсын нийслэл Токио хотод 2 дахь уулзалтыг хийж, тус уулзалтаар талууд Ковид19 болон АНУ ба БНХАУ-ын харилцаа улам хурцдаж байгаа асуудлууд дээр санал солилцож, мөн БНХАУ улсын өсөж байгаа хүчний нөлөөллөөс болгоомжилж буйгаа тэмдэглээд "FOIP" стратегийн бодлогын хүрээнд бүс нутаг дахь аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааны санаачилгад илүү олон орны дэмжлэгийг авахаар санал нэгдсэнээ мэдэгдсэн.

БНХАУ-ын эсрэг "Их дөрөв", "Ази дахь НАТО" зэргээр тодорхойлогдоод байгаа аюулгүй байдлын хэлэлцээрийн дээрх 4 улсаас гадна БНСУ, Индонез, Малайз, Филиппин, Тайланд, Вьетнам зэрэг бүс нутгийн улсууд Өмнөд Хятадын тэнгисийн дийлэнх хэсгийг эзлэн явуулж буй БНХАУ-ын далайн тээврийн үйл ажиллагаа болон БНХАУ тус далайн ихэнх хэсгийг өөрсдийн эзэмшил гэж үзэх болсныг эсэргүүцэж, "FOIP" стратегийн бодлогыг хүлээн зөвшөөрөх, нэгдэх үйл явц ажиглагдаж

³ "Address by Prime Minister Shinzo Abe at the Opening Session of the Sixth Tokyo International Conference on African Development (TICAD VI)," August 27, 2016, at the Kenyatta International Convention Centre (KICC), Nairobi, Kenya.



байна.

Манай улсын хувьд 2020 оны 10 дугаар сард Япон улсын Гадаад хэргийн сайд Тошимицү Мотеги Монголд айлчилж, хоёр улсын гадаад хэргийн сайд нар КОВИД19-ийн эсрэг арга хэмжээ болон хоёр улсын агаарын хилийг үе шаттайгаар нээх зэрэг олон асуудлыг хэлэлцсэний дотор хоёр улсын гадаад хэргийн сайд нар "Чөлөөт ба Нээлттэй Энэтхэг-Номхон далай" (FOIP)-г сурталчлах чиглэлээр хамтран ажиллахаар тохирсныг олон улсын мэдээллийн хэрэгслүүд онцолсон байдаг.

Японы "FOIP"-ын санал санаачилга анхнаасаа БНХАУ-ын өсөн нэмэгдэж байгаа хүч, нөлөөллийг тогтоон барихад чиглэсэн. Тэр ч утгаараа АНУ зэрэг БНХАУ-тай хурцадмал асуудалтай байгаа улс орнууд уг санаачилгад нэгдэх болсон гэж олон судлаач, шинжээчид үздэг. Харин Японы тал үүнийг эрс үгүйсгэдэг ба аль нэг улс руу чиглэсэн стратеги, бодлого биш гэж мэдэгддэг. "FOIP" нь анхнаасаа БНХАУ-ын эсрэг чиглэгдсэн мэт боловч нөгөөтэйгүүр БНХАУ-ын явуулж буй үйл ажиллагаа стратегийн бодлого, зорилт нь Японы "FOIP"-ийн эсрэг буюу тус стратегийн бодлогыг үгүйсгэдэг байж болох талтайг

анхаарах хэрэгтэй. Өнөө үед БНХАУ-ын өсөн нэмэгдэж байгаа хүч, нөлөөлөл нэмэгдэхийн хэрээр тус улсын явуулж буй "Нэг Бүс, Нэг Зам" санаачилгад бүс нутгийн улс орнууд төдийгүй дэлхийн бусад улс орнууд идэвхтэй хамрагдаж байна. Үүнтэй зэрэгцэн Ази номхон далайн бүс нутагт АНУ-ын хамгийн том холбоотон төдийгүй бүс нутгийн хамгийн том эдийн засаг Япон улс "Чөлөөт ба Нээлттэй Энэтхэг-Номхон Далай" стратегийн бодлогыг дэвшүүлэн хэрэгжүүлж байгаа нь Ази-Номхон далайн бүс нутагт БНХАУ-ын хэт давамгайлах байдлаас сэргийлж, хүчний тэнцвэрийг хадгалахад чухал ач холбогдолтой юм. Монгол Улсын хувьд БНХАУ-ын тэргүүлдэг ШХАБ-д ажиглагчийн статусаа хадгалахын зэрэгцээ урд хөршөөсөө эдийн засгийн хувьд хэт хамааралтай байгаа хэдий ч гуравдагч хөршийн бодлогын хүрээнд стратегийн түншлэлийн харилцаа бүхий Япон улстай найрсаг хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр тус улсын явуулж буй "FOIP" стратегийн бодлогын санал санаачилгад нээлттэй хандан, хамтран ажиллахаа илэрхийлсэн нь манай улсын явуулж буй гуравдагч хөршийн бодлогод бүрэн нийцсэн гэж үзэж байна.

Ашигласан материал:

1. "Address by Prime Minister Shinzo Abe at the Opening Session of the Sixth Tokyo International Conference on African Development (TICAD VI)," August 2016 ,27, at the Kenyatta International Convention Centre (KICC), Nairobi, Kenya.
2. <https://asean.usmission.gov/remarks-president-trump-apec-ceo-summit-da-nang-vietnam/>
3. <https://thediplomat.com/11/2020/a-new-phase-for-the-free-and-open-indo-pacific/>



ЦАХИМ ХАЛДЛАГА ТҮҮНЭЭС ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ

Б.НАРАНТУЯА /УБХИС-ийн АБДС-ийн магистрант дэслэгч, НОБГ-ГХСАСТ/

Түлхүүр үг: Цахим гэмт хэрэг, цахим орчин, цахим халдлага

Key words: Cybercrime, cyberspace, cyberattacks

Хураангуй. Техник технологийн эрчимтэй хөгжиж буй цаг үед албан байгууллага, хувь хүмүүсийн технологийн хэрэгцээ өсөхийн хирээр түүнийг дагасан давуу талууд бий болсоор байгаа хэдий ч сул талууд ч байсаар байна. Энэ нь цахим орчинд олон төрлийн гэмт үйлдэл гарах үндэс болж байгаа билээ. Үүний нэгэн том жишээ нь цахим гэмт хэрэг буюу хэн нэгний хувийн мэдээлэл, цахим орон зайд халдаж үйлдэх гэмт хэрэг юм. Тиймээс Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2015 оны (Шинэчилсэн найруулга) 26 дугаар бүлэг заалтын дагуу Цахим гэмт хэргийг олон улсын цахим гэмт хэргийн эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж, Эрүүгийн хуулинд заасан цахим гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлохыг зорилгоо.

Үндсэн хэсэг. Интернет нь анх 1969 онд АНУ-ын БХЯ нь "ARPANET" нэртэйгээр цэргийн судалгаа шинжилгээ хийх зорилгоор бүтээгдсэн байдаг. Цаашлаад 1983 онд тухайн сүлжээг цэргийн болон их дээд сургуулиудад судалгааны ажилд зориулж хоёр хэсэг болгон хуваасан. 1990 он гэхэд улс орнуудын интернет сүлжээнүүд хоорондоо холбогдож нэг том бүхэл сүлжээг бий болгон ашиглаж эхэлсэн байдаг. Улмаар интернет нь дэлхийг аалзны тор адил ороож, мэдээллийн хязгааргүй өргөн уудам сүлжээг бий болгож байгаагаас гадна дэлхийн хүн амын гуравны нэг хувь нь тогтмол ашигладаг гэх тоо баримтууд гарч байжээ.

Цаашлаад интернет хэрэглэгчид нь 2000-2009 оны хооронд буюу 9 жилийн хугацаанд 394 саяас 1.8 тэрбум

болтлоо огцом нэмэгдсэн ба интернет хэрэглэгчдийн тоо өдөр ирэх тутам нэмэгдэж байна. Монгол Улсын хувьд интернет нь харьцангуй сүүлд 1994 онд нэвтэрсэн. 1996 оны 01 сарын 17 ны өдрөөс эхлэн албан ёсоор зарлаж нээлт хийж байсан байна. Тухайн үед Монгол Улсад интернет хэрэглэгчдийн тоо 500 гаруй байсан ба одоо хүн амын 70-80 хувь нь интернет сүлжээ ашиглах болсон. Үүний 70 хүртэлх хувь нь зөөврийн интернет ашиглах болсон байна¹.

Цахим халдлага гэдэг нь мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг ба олон янзын суурь ойлголтуудаас бүрддэг. Судлаач Ц.Хүрэл-Очирын томъёолсноор компьютер болон интернетийн гэмт хэргийн хосолсон байдлыг хэлж байгаа бөгөөд цахим гэмт хэрэг нь үндэстэн дамнасан гэмт хэрэг ба цахим сүлжээг ашиглан хувь хүний нууцад халдах, бусдыг тандах, мөрдөж мөшгөх, садар самуунд уруу татах, сурталчлах гэх мэт олон төрлийн салбар ойлголтыг багтаадаг. НҮБ-ын гаргасан мэдээгээр цахим гэмт хэрэг буюу кибер гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгт хамаарна гэсэн бөгөөд дэлхийн эдийн засагт жил бүр нэг тэрбум ам.долларын хохирол учруулдаг ноцтой гэмт хэрэгт тооцогддог байна².

Кибер буюу цахим халдлагын конвенц боловсруулагчдын зүгээс кибер гэмт хэргийг тодорхойлж үндсэн дөрвөн төрөлд хуваасан байна³. Үүнд:

- **Цахим компьютерын мэдээлэл, сүлжээний бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлын эсрэг гэмт хэрэг:**

Энэ ангиллын гэмт хэрэгт хууль

¹ Mogul-ganjo http://mogulg.blogspot.com/2012/04/blog-post_20.html 2018 он

² Ганбаатар Л. Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь(Анхны хэвлэл).УБ. 2010. -41х

³ Ганбаатар Л. Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь(Анхны хэвлэл).УБ. 2010. -43х



бус хандалт, хууль бусаар мэдээлэл дундаас нь олзлох, өгөгдөлд саад хийх, сүлжээнд саад хийх, тоног төхөөрөмжийг урвуулан ашиглах гэсэн хууль бус үйлдлийг хамруулдаг.

• **Компьютер ашиглаж үйлдэх гэмт хэрэг:**

Энэ ангиллын гэмт хэрэгт компьютер ашиглан хуурамч баримт үйлдэх, компьютер ашиглан залилах хууль бус үйлдлийг хамруулдаг. Сүүлийн үед эдийн засгийн нөхцөл, хүмүүсийн хэрэглээтэй холбоотой зүйлсийг хамруулдаг ба дараах төрлийн гэмт үйлдэл нэмэгдэх болсон. Үүнд:

- Зээлийн картын залилан,
- Урьдчилгаа төлбөрийн залилан,
- Интернет маркетинг болон жижиглэн худалдааны луйвар,
- Үнэ хаялцуулах дуудлага худалдааны болон хөрөнгийн зах зээлийн залилан.

• **Интернет дэх зохистой агуулгын эсрэг гэмт хэрэг:**

Энэ ангиллын гэмт хэрэгт хүүхдийн порнографтай холбоотой хууль бус үйлдлийг хамруулдаг. Үүнд:

- Бэлгийн харилцаанд бага насны хүүхэд оролцож байгаа,
- Бэлгийн харилцаанд бага насны хүүхэд шиг харагдах хүн оролцож байгаа
- Бэлгийн харилцаанд бага насны хүүхэд оролцож байгааг харуулах бодит зураг

Энд дурдсан "бага насны хүүхэд" гэдэгт 18 нас хүрээгүй бүх хүнийг ойлгоно.

• **Интернет дэх оюуны өмчийн эсрэг гэмт хэрэг:**

Энэ ангиллын гэмт хэрэгт зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчсөн хууль бус үйлдлийг хамруулдаг. Дуу хөгжим, дүрс бичлэг, номын цахим хувилбар

гарах болсноор зохиогчийн эрхийн зөрчлийн шинэ хэлбэрийг бий болгосон. Файл хуваалцах үйлчилгээ (File-sharing systems) нь хэрэглэгчдийг бусдад файл түгээх, зохиогчийн эрхээр хамгаалагдсан олон мянган файлыг хэрэглэгчдэд хялбар аргаар олж авах нөхцөлийг бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл, Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Берний конвенц болон Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд бататгасан эрхүүдийг интернетэд зөрчсөн үйлдлүүдийг интернет дэх зохиогчийн эрхийн зөрчил гэж үздэг⁴.

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан судалгаагаар Монгол Улсад 2016 оны байдлаар давхардсан тоогоор 2.512.100 интернет хэрэглэгч байгаагаас сүлжээний хэрэглэгч 90.97 хувийг эзэлж, нийт хэрэглэгчийн хамрах хүрээ 86.7 хувь нь Улаанбаатар хотод, 10.3 хувь нь аймгуудад, 2.9 хувь нь сумдад, интернет үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 59 аж ахуй нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байсан байна⁵.

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар манай улсад 2.910.778 интернет хэрэглэгч байгаагаас Мобайл дата, буюу ухаалаг гар утсаар интернет хэрэглэгч 90.21 хувийг эзэлж байна⁶. Энэ нь өрх гэр болгон интернеттэй, хүн болгон ухаалаг гар утас хэрэглэгч, интернет хэрэглэгч болсон гэхэд буруудахгүй билээ.

Дэлхийн улс орнуудаас АНУ-д цахим гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгддэг орон бөгөөд Холбооны мөрдөх товчоо жилд 300 мянга орчим, өдөрт 900 гаруй цахим гэмт хэрэгтэй холбоотой өргөдөл, гомдол хүлээн авдаг байна. Мөн АНУ-ын хууль сахиулах байгууллагын тайланд бүхий л төрлийн цахим гэмт хэрэг үйлдэгчид жилд 1.5 их наяд ам.долларын хохирол бусдад учруулдаг байна⁷.

⁴ <http://uridchilan-sergiileh.police.gov.mn/news/content/id/3634/type/201/menuid/>

⁵ Сумьяацэрэн Д. "Монгол Улс дахь кибер гэмт хэргийн нөхцөл байдал, үйлдлийн арга, урьдчилан сэргийлэх асуудал". 2017 онд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүллээс дам эшлэв.

⁶ Ган-Оч Ц., Доньжчимбуу Б. Мэдээллийн эрх зүй. УБ. 2019. -23х

⁷ Бямбажаргал Г. "Цахим гэмт хэргийн талаарх онцлох баримтууд". УБ. 2020.-8х



Цахим гэмт хэргийн хамгийн түгээмэл хэлбэрүүдэд "фишинг" буюу интернетээр залилан үйлдэх, "сошиал инженерчлэл" буюу хувь хүний сэтгэл зүйн онцлогийг харгалзан сэдэл /мөнгө хожих, тэтгэлэг авах зэрэг/ өгч, итгэл төрүүлэх замаар мэдээлэл цуглуулах, нууцад нэвтрэх болон компьютерийн сүлжээнд төрөл бүрийн вирус, хортой код тараах зэрэг аргууд багтдаг.

АНУ-ын "Accenture securtiy" байгууллагын 2019 оны "Кибер гэмт хэргээс учирсан хохирол"-ын талаарх тайланд дурдсанаар "фишинг" болон "сошиал инженеринг" хэлбэрийн халдлагад өртсөн байгууллагын тоо 2018 онтой харьцуулахад 16 хувиар өсч, нийт цахим халдлагад өртсөн байгууллагын 85 хувийг эзэлж байдаг гэсэн үзүүлэлт байдаг. Иймээс улс орнууд цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд АНУ-ын хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон шинжээчид цахим аюулгүй байдлыг хангах, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд 17.4 тэрбум ам.доллар шаардлагатай хэмээн үзсэн байна. Мөн олон улсын цахим аюулгүй байдлын зах зээлийн судалгаагаар, 2017-2021 онд цахим аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд зарцуулагдах нийт хөрөнгө 1 их наяд ам.доллараас давах бөгөөд цахим аюулгүй байдлын мэдлэг олгох сургалтын зардал л гэхэд 2027 онд 10 тэрбум ам.долларт хүрнэ гэж тооцоолжээ⁸.

Манай улсын хувьд цаг тутамд өсөн нэмэгдэж буй компьютер, ухаалаг утасны хэрэглээг дагаад цахим гэмт хэргийн тоо жил бүр нэмэгдэж, 2016 онд 97, 2017 онд 195, 2018 онд 659, 2019 оны 5 сарын байдлаар 384 буюу нийт 1,335 цахим гэмт хэрэг бүртгэгджээ. Эдгээрээс цахим гэмт хэрэгт өртсөн хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй хүүхдүүд байдаг бөгөөд энэ нь цахим гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэлбэрийн талаар мэдлэг дутмаг, бага

насны хүүхдэд тавих хараа хяналт сул зэргээс үүдэлтэй юм⁹. Цахим гэмт хэрэг нийгэмд шууд учруулж буй хор хөнөөлийг бүрэн тодорхойлоход хүндрэлтэй байдаг байна. Цагдаагийн ерөнхий газраас гаргаж буй гэмт хэргийн статистик мэдээллийг авч үзье.

2017-2021 оны эхний 3 дугаар сар хүртэлх "Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээ"-ний газар бүртгэгдсэн цахим мэдээллийн гэмт хэргийн харьцуулалт

Хүснэгт 1.
Цахим мэдээллийн гэмт хэргийн эсрэг гэмт хэрэг

№	2017	2018	2019	2020	2021 3-р сар
Эрүүгийн хуулийн 26.1-26.3 дах зүйл заалтуудад	43	42	47	119	134

Эх сурвалж: (Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан, 2021)

2017 оноос хойш буюу сүүлийн 5 жилийн хугацаанд үйлдэгдсэн цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоон үзүүлэлт бөгөөд хүснэгтээс харвал цахим халдлага тэр дундаа цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг өсөх хандлага ажиглагдаж байна. Энэ нь цахим гэмт хэрэгт өөр төрлийн гэмт хэрэг давхар зүйлчлэлийн шинжийг агуулж байгаа ба гэмт хэргийн зүй тогтлыг харгалзах нь нэн чухал зүйл болоод байна¹⁰.

Баримт: Улаанбаатар хотод оршин суух эрхэлсэн тодорхой ажилгүй М, Б нар нь цахим орчинд бусдын зургийг зөвшөөрөлгүй байршуулан хуурамч фэйсбүүк хаяг үүсгэж иргэдтэй танилцан дотносох замаар хувийн мэдээлэл видео бичлэгийг цуглуулсан байна. Эдгээр залуус хувь хүний мэдээллийг олон нийт, найз


⁸ Бямбажаргал Г. "Цахим гэмт хэргийн талаарх онцлох баримтууд". УБ. 2020.-10х

⁹ Бямбажаргал Г. "Цахим гэмт хэргийн талаарх онцлох баримтууд". УБ. 2020.-11х

¹⁰ Бямбажаргал Г. "Цахим гэмт хэргийн талаарх онцлох баримтууд". УБ. 2020.-18х

нөхдөд нь тараана хэмээн сүрдүүлж зургаан иргэнээс их хэмжээний мөнгө авсан гэмт үйлдлийг бүлэглэн үйлдэж байсныг таслан зогсоож, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэст эрүүгийн хэрэг үүсгэн тус тус шалгагдаж байна¹¹.

Монгол Улсын Шүүхийн нэгдсэн сангаас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1.1-ээр нийслэлийн хэмжээнд шийдвэрлэгдсэн анхан шат болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн түүвэр судалгааг тоон үзүүлэлтээр харуулбал:



1.1 дүгээр зураг. 26.1.1 дугаар заалтын дагуу шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Эх сурвалж: (Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан, 2021)

Зурагт 2018 оноос 2021 оны эхний 3 сарын хугацаанд шүүх хуралдаанаар шийдвэрлэгдсэн хэргийг харуулсан ба Эрүүгийн хуулийн 26.1.1 дэх зүйл заалтаар шийдвэрлэгдсэн байдал цаашид нэмэгдэх хандлагыг харж болохоор байна.

Монгол Улсын Шүүхийн нэгдсэн сангаас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1.2-оор нийслэлийн хэмжээнд шийдвэрлэгдсэн анхан шат болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн түүвэр судалгааг тоон үзүүлэлтээр харуулбал:



1.2 дугаар зураг. 26.1.2 дугаар заалтын дагуу шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Эх сурвалж: (Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан, 2021)

Зурагт 2018 оноос 2021 оны эхний 3 сарын хугацаанд шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийг харуулсан ба Эрүүгийн хуулийн 26.1.2 дэх зүйл заалтын дагуу анхан шатны болон давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн тоо 2018 оны байдлаар ердөө 2 байсан бол 2020 он гэхэд энэхүү үзүүлэлт 7 болж өссөн боловч 2021 онд 2 болж буурсан нь цаашид буурах хандлагыг тодорхойлж болохоор байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 26.1.2 дугаар зүйл заалт ерөнхий байдлаар үйлдэл, ойлголт, шийтгэл, үр дагавар зэрэг тус тусын онцлогыг нэг зүйл заалтад багтаасантай нягт холбоотой юм.

Монгол Улсын Шүүхийн нэгдсэн сангаас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1-26.3 нийслэлийн хэмжээнд шийдвэрлэгдсэн анхан шат болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн түүвэр судалгааг тоон үзүүлэлтээр харуулбал:



1.3 дугаар зураг. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг

Эх сурвалж: (Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан, 2021)

2018 оноос 2021 оны эхний 3 сарын хугацаанд Монгол Улсын хэмжээнд цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаар Монгол Улсын Дээд шатны шүүхээр шийдвэрлэгдсэн шийдвэр байхгүй. Харин Эрүүгийн хуулийн бусад зүйл заалттай хамтран шийдвэрлэгдсэн 9 хэрэг байгаа нь нийт анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэгдсэн хэргийн 27.3%-ыг эзэлж байна.

2018-2021 оны эхний гурван сарын хугацаанд шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийг харвал энэ зүйл заалт буюу Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг цаашид нэмэгдэх хандлагыг тодорхойлж болж байна¹².

¹¹ Цахим гэмт хэрэгтэй тэмцэх алба. УБ. 2016

¹² Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. УБ. 2021



Цахим гэмт хэрэг нь зөвхөн Монгол Улс гэлтгүй үндэстэн дамнасан шинжтэй асуудал бөгөөд шийдвэрлэхэд төвөгтэй учраас эрх зүйн зохицуулалтыг нэн түрүүнд боловсронгуй болгох шаардлагатай тулгарч байна. Ийм учраас Монгол Улс цахим гэмт хэрэг түүний хор хөнөөлтэй байдлын эсрэг олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох шаардлага бий болж байна. Энэхүү цахим гэмт хэргийн эсрэг олон талт хамтын ажиллагааны үндсэн эрх зүй нь цахим гэмт хэргийн тухай Будапештийн конвенц билээ. Монгол Улс нь Будапештийн конвенцоос баталсан арван зөвлөмжөөс дөрвөн зүйл заалтыг Эрүүгийн хуулийн тусгай анги (ЭХТА)-д огт тусгаагүй байдаг.

Харин гурван зүйл заалтад тусгасан боловч хариуцлага тооцохоор заасан нөхцөлүүд нь цоорхой байдаг байна. Түүнчлэн Будапештийн конвенцийн зөвлөмжийн 3-5 дугаар хэсэгт заасан гэмт үйлдлүүд нь санаа, зорилго мөн үр дагавар зэрэг нь өөрийн гэсэн онцлогтой юм. Гэвч Монгол Улс Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад эдгээр гэмт үйлдлүүдийг нэг зүйл заалтад буюу Эрүүгийн хуулийн 26.2-т багтаасан нь хуулийг хэрэглэх, тайлбарлах, нэг мөр ойлгоход хүндрэл учруулж байгаа ба үр дагаварт харгалзан ижил хариуцлага ногдуулах сөрөг үр дагавар үүсгэж байна. Эдгээрийг боловсронгуй болгоход дараах зүйлс шаардлагатай.

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн төрөл, зүйлчлэлийг тус тусад нь салган зүйлчилж олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах.
2. Олон улсын цахим гэмт хэргийн аюулгүй байдлыг хангах гол үйл ажиллагаануудыг Эрүүгийн хуулинд хуульчлах. Үүнд:
 - Онц чухал мэдээллийн дэд бүтцийн хамгаалалт - CIIP
 - Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, менежмент – ISRAAM /Information Security Risk Assessment and Management/
 - Халдлага илрүүлэх, таслан

зогсоох, хариу үйлдэл үзүүлэх – CCERT 3

3. Эрүүгийн хуульд заасан цахим гэмт хэрэг түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох гэх мэт арга замыг төрөөс анхаарч, хэрэгжүүлэх шаардлагатай.

Дүгнэлт. Монгол Улсын хувьд цахим гэмт хэргийн талаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1-26.3 дугаар зүйл заалтын хүрээнд тодорхойлсон байдгаас бусад улс орон тэр дундаа Европын улс орнууд илүү өргөн хүрээнд тодорхойлсон байдаг. Энэ зүйл заалт нь цахим гэмт хэрэг гэх ойлголтыг бүхэлд нь хангаж чадахгүй байгаа ба манай улсын хувьд мэдээллийн аюулгүй байдал буюу цахим гэмт халдлагын эсрэг суурь хууль бүрэлдэн тогтоогүй гэж үзэх шалтгаан болж байна. Монгол Улсад цахим гэмт хэрэг анх 2006 онд бүртгэгдэж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулийн 26.1- 26.3 дугаар заалтын хүрээнд 2018 онд анхны шүүхийн шийдвэр батлагдсан байдаг ба энэ тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа нь цахим гэмт хэрэг цаашид өсөх магадлал бий болж байна.

Монгол Улсын хувьд мэдээллийн техник технологийн хэрэглээний талаар заавар зөвлөмж өгдөг боловч цахим гэмт хэргийн талаар мэдлэг, урьдчилан илрүүлэх нөхцөл байдал, мөрдөн шалгах, зүйлчлэн хяналт шалгалт явуулах, хариуцлага оногдуулах талын мэдлэг боловсрол хангалтгүй түвшинд байна. Энэ талаар төрийн болон төрийн бус байгууллагууд нь өөрсдийн эрх үүргийн хүрээнд мэдлэг боловсрол олгох мэдээллийн аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулдаг ба энэ нь олон улсын туршлагаас харвал тухайн харилцааг зохицуулдаг, дагнасан үйл ажиллагаа явуулдаг байгууллага байхгүй байгаа нь Монгол Улсын хувьд том дутагдал болж байна.

Ийм учраас бид тухайн үйл ажиллагааг явуулах, хяналт тавих субъектыг бий болгож түүний эрх үүрэг болон үйл ажиллагааны чиглэлийг тодорхой заан батлах зайлшгүй шаардлагатай юм. Олон улсад цахим гэмт хэргээр дагнан мэргэшсэн боловсон хүчин бэлтгэдэг ба



цахим гэмт хэргээр мэргэшсэн цагдаагийн албан хаагчид үйл ажиллагаа явуулдаг бол Монгол Улсад Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс

ажиллаж байгаа ч олон улсын адил цахим гэмт хэргээр дагнан мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх нэн шаардлага байна.

Ашигласан материал:

1. Үндсэн хууль 1992 он
2. Эрүүгийн хууль 2002 он
3. Зөрчлийн тухай хууль 2017 он
4. Оюуны өмчийн тухай хууль 2020 он
5. Хувь хүний нууцын тухай хууль 1995 он
6. Төрийн болон албаны нууцын тухай хууль 2016 он
7. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль 2003 он
8. Бямбажаргал Б. Цахим гэмт хэргийн талаарх онцлох баримтууд. УБ. 2020
9. Ган-Оч Ц., Доньжчимбуу Б. Мэдээллийн эрх зүй. УБ. 2019
10. Ганбаатар Л. Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь. УБ. 2010
11. Ганбаатар Л. Цахим эрх зүй. УБ. 2019
12. Мэдээллийн аюулгүй байдлын газар <http://www.isd.gov.mn/?lang=mn&cat=1>
13. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл <https://www.nsc.gov.mn/mn/p/103>
14. Харилцаа холбооны зохицуулах хороо <https://crc.gov.mn/k/2lz/12>
15. Үндэсний дата төв <https://datacenter.gov.mn/about-us>
16. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан 2021-2018 онд шийдэгдсэн хэргүүд <https://shuukh.mn/cases>
17. Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж нийтлэл. УБ. 2018
18. <http://toli.gov.mn/>

ИРГЭНИЙ НИЙГЭМ БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Ж.ЦЭСЭН /УБХИС-ийн докторант/

Түлхүүр үг: Нийгэм, иргэний нийгэм, аюулгүй бадал

Key words: Society, civil society, security

Оршил: Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3 Дотоод аюулгүй байдал бүрэлдэхүүн хэсэгт "Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн" (ҮАБҮБ, 2010) гэж заасан байдаг. Эндээс үзэхэд Монгол Улсын аюулгүй байдалтай иргэний нийгэм салшгүй холбоотой болж таарч байна. Цаашлаад тус үзэл баримтлалын бүрэлдэхүүн хэсгийн дотоод аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангах зарчим гэсэн хэсэгт ч иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг оролцооны талаар хэдэнтэй дурдагдаж, тодорхой үүрэг хүлээх талаар ч тусгажээ. Үндэсний аюулгүй байдлаа хамгаалах асуудалд иргэний нийгэм нь ихээхэн чухал үүрэгтэй болохыг уг бичиг баримтаас анзаарсан тул цаашид үргэлжлүүлэн судлах нь зүйтэй хэмээн үзэж уг сэдвийг сонгож авлаа.

Иргэний нийгэм ба аюулгүй байдал гэсэн сэдэв анхаарал, сонирхол татсан өөр нэг шалтгаан нь уг сэдэв мэдээллийн аюулгүй байдалтай мөн салшгүй холбоотой байгаа юм. Учир нь, өнгөрсөн хугацаанд болж өнгөрсөн зарим үйл явдал болон одоогийн нөхцөлд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд иргэний нийгмийн зүгээс гарч байгаа үзэл бодол, байр суурь, уриалга аюулгүй байдлыг хангахад чиглэсэн, эсвэл ард иргэдийг үүний эсрэг өдөөн турхирсан хандлага ч анзаарагдаж ирсэн юм.

Мэдээллийн аюулгүй байдал нь улс орны дотоод аюулгүй байдлыг хангахад нэн тэргүүний ач холбогдолтой гэж

үзэж байгаа учраас уг асуудлыг судалж, Үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, тусгай чиг үүрэг бүхий байгууллага, хүмүүсийг судалгаанд суурилсан бодит мэдээлэл, зөвлөмжөөр хангах нь ихээхэн чухал ач холбогдолтой. Мөн иргэдийг, иргэний нийгмийн төлөөлөл, Төрийн бус байгууллагуудыг ч бодит мэдээллээр хангаж, баталгаа нотолгоогүй өдөөн турхирсан үйл явдал, баримтат бус мэдээлэлд суурилсан үзэл бодол хандлага, уриалга нь хэрхэн сөрөг үр дагаварт хүргэж болох тухайд ч мэдлэг олгох нь зүйтэй юм. Уг сэдвийг нарийвчлан судлахын практик ач холбогдлыг энэ мэтээр дурдаж болно. Онолын талаас авч үзвэл, иргэний нийгмийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож ҮАБҮБ-ыг хэрэгжүүлэхэд тэдний оролцоог мөн тусгайлан тодорхойлсон баримт бичгийн төсөл боловсруулах, түүнийг таниулан сурталчлах нь чухал ач холбогдолтой.

Уг сэдвийг гүнзгийрүүлэн судалснаар ҮАБҮБ-ыг хэрэгжүүлэх тусгай чиг үүргийн байгууллагууд, төр, орон нутгийн удирдлага албан хаагчид болон иргэний нийгэм хоорондын харилцаа уялдааг тодорхойлж үр дүнтэй хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд суурь судалгаа, санал зөвлөмжийг мэргэжлийн судлаачдын зүгээс боловсруулан танилцуулах боломжтой.

Уг сэдвийг сонгон авч ҮАБҮБ баримт бичгийн иргэний нийгэмтэй холбоотой зүйл заалтуудыг баримтын аргаар судалж, бодлогын шинжилгээ хийх, мөн олон нийтийн анхаарал татсан зарим үйл явдлыг жишээ болгон авч кэйс судалгааны аргаар судалж, эх сурвалжуудтай холбогдон ярилцлагын аргаар зарим шинэ баримтуудыг илрүүлж судалгаандаа ашиглав. Дээрх аргуудаар цуглуулсан мэдээллийг боловсруулахдаа оюун

дүгнэлтийн болон индукц, дедукцийн арга хэрэглэж, дүгнэлт гаргахыг зорьсон юм.

Үндсэн хэсэг: Иргэний нийгэм гэдэг ойлголтыг төрийн зохион байгуулалтын зэрэгцээ иргэдийн идэвхтэй амьдралын хэв маяг оршиж байдаг тухай эртний Грек, Ромын сэтгэгчид анх тэмдэглэсэн байдаг. Хамгийн өргөн утгаар нийгмийн хөгжлийн тодорхой төлөв байдал, иргэн бүрийн хувийн эрх чөлөө, сонирхлыг дээдэлсэн нээлттэй нийгмийн тогтолцоо гэж үзэж болно. Иргэний нийгэм нь өвөрмөц сонирхлоороо эдийн засгийн, угсаатны, соёлын ...г.м нэгдэж нийлсэн төрийн үйл ажиллагааны хүрээний гадна сонирхлоо хэрэгжүүлэгч социал бүлгүүдийн цогц мөн. И.Кант, Гегель. (Wikipedia, n.d.) Манай улсын олонх иргэд, хэвлэл мэдээллийнхний дунд иргэний нийгэм гэдэг үгийг ашиглахдаа Төрийн бус байгууллагуудад ихэвчлэн хамаатуулж сонин, хэвлэлд нийтэлсэн харагддаг. "Иргэни нийгэм гэгээрч соёлжих явцад үзэл бодол, шинж чанарын хувьд бие даасан, тэгш эрхт иргэд нь нийгмийн зохицуулалтад сайн дурын үндсэн дээр өргөнөөр оролцдог, тийнхүү оролцох эрхзүйн болоод ухамсрын орчин бүрдсэн нийгмийг хэлнэ" гэсэн улс төрч, нийтлэлчийн тодорхойлолт мөн анхаарал татаж байна. (М.Тулгат, 2005)

"Маш энгийнээр хэлэхэд иргэний нийгэм бол иргэд төрийг хянаж, төрд хариуцлага хүлээлгэж чаддаг тийм л хүмүүсийн нэгдлийг хэлж байгаа юм. Нөгөө нэг санаа бол иргэний нийгэм бол иргэд төр байхыг биш харин иргэн байхыг хүсдэг тийм нийгмийг хэлдэг. Дүгнэвэл иргэний нийгэм гэдэг бол жирийн иргэн сайхан амьдардаг тийм л нийгмийг хэлнэ" (Ч.Тамир) гэсэн тодорхойлолт нь уг ойлголтыг мөн өөр нэг талаас буюу ардчилсан улс оронд бодитоор үүсдэг амьдралын хэв маяг гэсэн санаагаар илэрхийлжээ.

Харин төрийн удирдлагын Доктор Г.Жаргал, Н.Сэлэнгэ нарын томъёолсноос үзвэл Төрийн бус байгууллага, холбоод, иргэд, олон нийт, сошиал бүрэлдэхүүнээр илэрхийлж болохоор байна. (Г.Жаргал, Н.Сэлэнгэ, 2020) Уг томъёоллыг бидний

хийж байгаа энэхүү бичил судалгаанд хамгийн дөхөж очих иргэний нийгмийн оролцогчид гэж үзэж байна.

Аюулгүй байдал гэдэг ойлголтын тухайд аюулаас хамгаалагдсан байдлыг хэлнэ. Мөн аюул нүүрлэхэд түүнийг гэтлэх нөөц боломж бий болсон нөхцөлд аюулгүй байдалтай байна гэж үзэж болно. (Аюулгүй байдлын онолын үндэс хичээлийн лекц)

Харин Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалын 1.1.1.-д "Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ". (ҮАБҮБ, 2010) гэсэн байна. Үндэсний аюулгүй байдлын асуудал нь аливаа улс орны тусгаар тогтнолтой салшгүй холбоотой учраас энэ чиглэлийн мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ ч тасралтгүй хийгдэж байх учиртай юм.

Аюулгүй байдлын үзэл баримтлалд дурдагдсан хэд хэдэн зүйл заалтаас харахад иргэний нийгэм аюулгүй байдалтай хэрхэн уялдаж, харилцан хамаарч, нөлөөлж байгааг судлах нь чухал юм. Уг хоёр ойлголтыг хамаатуулан судалж, болж өнгөрсөн үйл явдлуудад шинжлэх ухааны талаас нь үнэлэлт дүгнэлт өгсөн баримт бичиг тийм ч олон байдаггүй бололтой. Дотоод аюулгүй байдлын асуудлаар бичигдсэн зарим эрдэм шинжилгээний өгүүлэлд иргэний нийгмийн талаар дурдагдсанаас жишээлбэл, "Албан тушаалтан, улс төрчидтэй холбоотой олон гэмт хэрэг шийдвэрлэгдэлгүй замхрах, төрийн албан тушаалтнууд өөрсдөө хууль зөрчин байж улс үндэсний эрх ашгийн эсрэг шийдвэр гаргах, улс үндэсний эрх ашигтай холбоотой олон асуудлууд шийдвэрлэгдэхгүй цаг алдах зэрэгт иргэний нийгэм туйлын бухимдах болж, эсэргүүцлээ хурцаар илэрхийлж эхэллээ. Тухайлбал, "Онги гол хөдөлгөөн", "Монголын гол нууруудын нэгдсэн холбоо", "Даяар Монгол", "Хөх Монгол", "Хөх бүлгэм" зэргээс уул уурхайн зүй бус, хууль бус ашиглалтын эсрэг, байгаль орчноо хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь нийгмийн сэтгэл



зүйд хүчтэй нөлөөлж, түүнд тулгуурлан хүч түрэмгийлсэн зарим талаар хэт даварсан үйлдэл хийх эхний алхам, тандалт хийгдсэн гэж үзэж болно." (Д.Адьяабазар, 2011, №53) гэснээс үзэхэд иргэний нийгмийн бухимдал улс орны дотоод аюулгүй байдалд нөлөөлөхүйц үйлдэл хийхэд хүргэсэн жишээнүүд байна гэж хэлж болохоор байна. Мөн "Ийнхүү иргэний нийгэм нь тодорхой хувь хүн, нийгэмд бүхэлд нь өөр өөрөөр нөлөөлдөг байна. Өнөөгийн ертөнцөд иргэний нийгэм нь өөрийн эрх ашиг, эрэлт хэрэгцээг бүрдүүлэн, аюулгүй байдлын субъект болж, эргэн тойрондоо нийгэм, улс төрийн шинэ орон зай үүсгэдэг. Хэрэв иргэний нийгэм, төр болон иргэний нийгмийн харилцан үйлчлэл алдагдаж, нарийн зохицуулсан эрх зүйн механизм байхгүй, тэдгээрийн хоорондын зөрчлийг ардчилсан институт шийдвэрлэж чадахгүйд хүрвэл түүнээс гарах гарц нь хүчирхийллийн арга хэмжээ болдог". (Б.Нэргүй, 2016 оны №02/218) хэмээн дүгнэсэн нь ч байна. Уг дүгнэлтийг 2008 оны 7 дугаар сарын 1-нд сонгуулийн будлианыг эсэргүүцэн жагссан иргэдийн эсэргүүцэл Монгол Улс түүхэндээ анх удаа онц байдал зарлахад хүргэсэн, олон хүний амь нас эд хөрөнгө, эрх чөлөөнд хохирол учирсан үйл явдлаар батлан хэлж болох юм.

Дээрх судлаачдын дүгнэлтүүдээс харахад иргэний нийгэм нь улс орны аюулгүй байдлыг хангахад ихээхэн үүрэгтэй нэгэн субъект болох нь тодорхой байна. Сэдвийн судлагдсан байдлаас өөрийн улс орны хэмжээнд авч үзэхэд, сүүлийн үеийн буюу олон нийтийн сүлжээнд иргэний нийгмийн зүгээс гаргаж тавьж байгаа мэдээлэл, уриалга хандлага нь аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байгааг судалж, үнэлэлт дүгнэлт өгсөн нь хомс байгаа нь ажиглагдлаа.

ҮАБҮБ-д "Монгол Улсын иргэд, иргэний нийгмийн байгууллагууд үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж, энэхүү үзэл баримтлалыг чанд мөрдлөг болгож, тэдгээрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцоно". (ҮАБҮБ, 2010) гэсэн заалтын хэрэгжилтэд олон нийтийн сүлжээгээр

дамжин мэдээлэл солилцох, санал бодлоо илэрхийлэх нь нэлээд үүрэгтэй болж ирснийг сүүлийн жилүүдэд болсон зарим үйл явдлын жишээнээс харж болохоор байгаа юм. Олон нийтийн сүлжээ буюу фейсбүүк, твиттер, инстаграм болон зарим вэбсайтад нийтлэгдсэн мэдээ, сурвалжилга, төрийн бус байгууллага, холбоод, иргэдийн сайн дурын нэгдэл, иргэний байр суурь төрийн бодлого шийдвэрт нөлөөлөх, цаашлаад ард түмний үзэл бодол, үйл ажиллагаанд ч нөлөөлөх тохиолдол ажиглагдсаар ирсэн байна. Энэ тухайд хэд хэдэн жишээ буюу кэйсийг дурдаж болно. "Даяар Монгол" хөдөлгөөнийхний гадаадын иргэдэд, ялангуяа БНХАУ-ын иргэдийг гадуурхах, түүнийгээ олон нийтийн сүлжээнд уриалах, Өвөрмонголд болсон үндэсний бичиг соёлоо хамгаалахтай холбоотой үүссэн асуудлыг манай иргэний нийгмийн төлөөллүүд дэмжиж уриалга хөдөлгөөн өрнүүлэх гэх мэт сүүлийн үеийн жишээнүүд байна. Эдгээр үйл явдлууд нь олон нийтийн сүлжээнд суурилан мэдээлэл солилцож тодорхой хэсэг бүлгийг уриалахаас эхлэлтэй байгаа юм. Үүнээс өмнөх үйл явдлууд буюу олон нийтийн сүлжээ хэрэглэгчид одоогийнх шиг хүчтэй болж амжаагүй байсан үед улс орны аюулгүй байдлын эсрэг олны анхааралд өртсөн зарим үйл явдлыг жишээлэн дурдвал, Онги гол хөдөлгөөний тэргүүн Ц.Мөнхбаяр Төрийн ордон руу буудсан, 2008 оны 7 дугаар сарын 1-ний жагсаал цуглаан, эмх замбараагүй байдал гэх мэт.

Харин одоогийн буюу ойрын жилүүдийн үйл явдлуудаас харахад утааны эсрэг "Боож үхлээ" цуврал акцуудыг зохион байгуулсан "Утааны эсрэг ээж аавууд" Фейсбүүкийн групп гэх мэт иргэний нийгмийн төлөөллүүдийн дуу хоолойгоо эрх баригчдад хүргэх гэсэн олон үйл явдлууд нь олон нийтийн сүлжээнд суурилдаг болж байна. Олон нийтийн сүлжээгээр нэгдсэн нэгдлүүдийг тухайлан анхаарч үзэх нь аюулгүй байдлаа хамгаалахад анхаарах ёстой нэгэн субъект болжээ гэж хэлж болох юм. Фейсбүүк, твиттерийн хаалттай

группүүдэд элдэв уриалга, өдөөн турхиралт, зохион байгуулалттай үйл ажиллагаа явагдаж байгааг үгүйсгэх аргагүй гэсэн үг юм. "Утааны эсрэг ээж аавууд" ТББ гэхэд фейсбүүкийн групп дээр суурилсан нэгдэл бөгөөд тус хаалттай группэд хэрхэн жагсаал цуглаан зохион байгуулах болон Ерөнхийлөгчид, Ерөнхий сайдад хэрхэн хандах хийгээд олон нийтийн санаа бодолд хэрхэн нөлөөлөх сценариуд төлөвлөгдөж байна. Гэхдээ үүнийг ҮАБҮБ-д харшилна гэж хэлж бас болохгүй. Учир нь, утааг арилгахын тулд тэд шаардлага тавьж байгаа нь нэг талаас аюулгүй байдлыг хангахад чиглэж байгаа юм. Нөгөө талаас жагсаал цуглаан нь даамжирч Д.Сүхбаатарын талбайд дүн өвлийн хүйтнээр хэвтэх, гэр майхан барих, өлсгөлөн зарлах, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын даргын хувийн гар утасны дугаарыг олон нийтэд тарааж мессэж бичихэд уриалах зэрэг нь эргээд, хувь хүний нууц, эрх чөлөө, аюулгүй байдалд сөрөг асуудал дагуулж болзошгүй хоёр талтай байгаа юм.

Дээр дурдагдсан зарим жишээнээс үзэхэд олон нийтийн сүлжээнд суурилсан иргэний нийгмийн төлөөллийн асуудлыг аюулгүй байдалтай холбон судалснаар тодорхой дүрэм журам тогтоож, улс орны болон иргэдийн аюулгүй байдлыг хамгаалахад анхаарах нь зүйтэй болов уу. Аюулгүй байдлыг хамгаалах үндсэн чиг үүргийн байгууллагууд иргэний нийгмийн энэ мэт шинэ нөхцөл байдалтай хэрхэн уялдаж, зохицон ажиллах тухайд, технологийн өөрчлөлт шинэчлэлт, мэдээллийн хурдыг мэдэрч, угтсан арга хэмжээ авах хийгээд ашиглах боломжийг санал болгох нь судлаачдын бас нэг анхаарах өнцөг гэж ойлгож байна. Цаашид энэ чиглэлээр гүнзгийрүүлэн судалж, боломжит арга замуудыг бусад улс орны туршлагатай хослуулах авч үзэх сонирхолтой байна.

Дүгнэлт: ҮАБҮБ-д заасанчлан "Төрийн бодлого боловсруулах, төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг

дэмжинэ. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг хөгжүүлнэ." (ҮАБҮБ, 2010) Гэсэн заалтыг цаашид хэрэгжүүлэх чиглэлд мэдээлэлд, ялангуяа асар хурдтай хөгжиж буй олон нийтийн сүлжээний мэдээлэлд анализ дүгнэлт хийж үйл ажиллагаандаа тусгахад цэргийн болон бусад тусгай мэргэжлийн байгууллагууд анхаарах нь цаг хугацаа, төсөв хөрөнгө хэмнэсэн чухал үйл явдал гэж үзэж болох юм. Иргэний нийгэмтэй зөв хамтарч, хоршиж ажиллахад олон нийтийн сүлжээн дэх эх сурвалжууд болон хурдтай түгж байгаа бодит болон бодит бус мэдээлэл, уриалга хандлагыг анхаарах нь олон талын ач холбогдолтой.

1. Цаашид уг асуудлыг анхааралдаа авч, олон нийтийн сүлжээн дэх зарим нэгдэл болон нөлөө бүхий төлөөллүүдтэй хамтран ажиллаж мэдээлэл солилцох, чиглүүлэх, хууль зөрчих болон үндэсний аюулгүй байдалд харшилсан элдэв үг үйлдлийг олон нийтийн сүлжээнд гаргахаас нь урьдчилсан сэргийлэх, цаашлаад ард иргэдийн санаа бодлыг тогтвортой байлгахын тулд аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтнуудын зүгээс нээлттэй мэдээллээр хангахад анхаарвал зохино.

2. Улс орны аюулгүй байдалд харшлах элдэв уриалга, хандлагад иргэд эх оронч үзэл гаргаж байна хэмээн андуурах тохиолдол олонтаа байдаг учраас энэ чиглэлийн боловсрол мэдлэг олгоход холбогдох байгууллагууд анхаарлаа хандуулах нь зүйтэй юм.

3. "Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх, оролцоог урамшуулж, хамтын ажиллагааны тодорхой арга, хэлбэрийг бэхжүүлж, үр дүнг дээшлүүлнэ". (ҮАБҮБ, 2010) гэсэн заалтыг хангахад дээрх дүгнэлтүүд нь ихээхэн ач холбогдолтой, хэрэгжүүлэх нь гарцаагүй нь харагдаж байна.

**Ашигласан материал:**

1. Б.Нэргүй., Иргэний нийгэм Үндэсний аюулгүй байдлыг хангах субъект мөн: ОХУ, АНУ-ын туршлага [Journal]. -[s.l.] : Шинжлэх Ухааны Академийн Мэдээ, 2016 оны N°02 (218).
2. Г.Жаргал.,Н.Сэлэнгэ., Судалгааны арга зүйд суралцах нь [Book]. - [s.l.] : Шинэчилсэн 2-р хэвлэл, 2020.
3. Д.Адъяабазар., "Монгол Улсын дотоод аюулгүй байдлын эрсдэл бүхий зарим асуудал" [-Journal]. -[s.l.] :Стратеги судлал сэтгүүл, 2011, N°53.
4. М.Тулгат., Бусгаар тогтносон Монгол [Book]. - [s.l.] : Эдмон , 2005.
5. Н.Нямдаваа., Аюулгүй байдлын онолын үндэс хичээлийн лекц [Sound Recording] // Лекц.
6. УАБҮБ <http://www.nsc.gov.mn> [Online] // <http://www.nsc.gov.mn/?q=ns-concept>. - 07 10, 2010.
7. Ч.Тамир., Иргэний нийгэм ба төр [Journal]. - [s.l.] : Шинэ толь 2007 N°58



ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Н.НОРОВСҮРЭН /ҮБХИС-ийн АБДС-ийн ММТТ-ийн багш, докторант/
М.ЭРДЭНЭЖАРГАЛ /Хууль зүйн магистр/

Түлхүүр үг: Мэдээлэл, хувийн мэдээлэл, хувь хүний мэдээлэл

Key words: Information, personal information

Хураангуй: Хүн хувийн мэдээллээ тодорхой зорилгын хүрээнд хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллагад өгснөөс үүсэх үр дагаврыг тухайн байгууллага шууд хариуцах зохицуулалт нь "Байгууллагын нууцын тухай", "Төрийн болон албаны нууцын тухай" хуулиудаар тус тус зохицуулж байгаа хэдий ч түүний хэрэгжилт сул байна. Хүний хувийн мэдээллийг уг байгууллагад ямар ч зорилгоор ашиглаж болох төдийгүй түүнд хяналт тавих эрх зүйн болоод бусад эрх, боломж иргэнд олгогдоогүй байна.

Монгол Улсад хүний хувийн мэдээлэл цуглуулах түүнтэй холбоотой харилцааг "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хууль болон "Хувь хүний нууцын тухай" хуулиар зохицуулж байна. Өнөөгийн байдлаар хүний хувийн мэдээллийг цуглуулахдаа дээрх хоёр хуулийн зохицуулалтад тулгуурлан хэрэгжүүлж байгаа нь учир дутагдалтай төдийгүй бусад хууль тогтоомжуудыг хэрэглэхгүй байна.

Учир нь "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хуулийн зохицуулалтад тулгуурлан хэрэгжүүлж байгаа нь зөвхөн төрийн байгууллага хувь хүнээс мэдээлэл цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулж байна. Мөн бусад салбарын хуулиудаар хүний хувийн мэдээллийг цуглуулж буй харилцааны хувьд "Хувь хүний нууцын тухай" хуульд заасан нууцаас бусад мэдээллийг цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулахгүй байгаа юм.

Иймд хүний хувийн мэдээлэл цуглуулж байгаа байдал нь эрх зүйн зохицуулалт


дутмаг хүрээнд хэрэгжиж байна.

Нийгэмд үйлчилгээний байгууллагууд хүний хувийн мэдээллийг цуглуулах эрх бүхий зөвшөөрөлгүйгээр дур мэдэн мэдээлэл цуглуулж буй гэж ойлгож болохоор байгаа юм.

Жишээ нь дэлгүүр, сүлжээ супермаркет, үзвэр үйлчилгээний байгууллагууд урамшууллын оноо цуглуулах байдлаар хүний хувийн мэдээллийг цуглуулахдаа цахимаар болон цаасан хэлбэрээр зарим тохиолдолд утсан харилцаагаар цуглуулж буй байдал ажиглагдаж байна. Хэрэглэгчээс хувийн мэдээллийг нь авахдаа ямар зорилгоор, хэрхэн яаж ашиглах талаар мэдээлэл өгөхгүй, мөн анх авсан зорилгоос өөр зорилгоор ашиглахад мэдэгдэхгүй зэрэг үйлдэл гарч байна¹.

Энэ байдлаар хүний хувийн мэдээллийг цуглуулж байгаа нь мэдээллийн төрөлжүүлэлттэй, эрх бүхий зөвшөөрөлгүй этгээд мэдээлэл цуглуулж буй, хүний хувийн мэдээллийн ашиглалт, хэрэглээ тодорхойгүй байна. Цуглуулсан хүний хувийн мэдээллийг олон нийтийн сүлжээнд задруулах, бусдад дамжуулах зэрэг хүний нэр төр, алдар хүндэд халдсан үйлдлүүд маш ихээр гарч байгаа нь даамжирсаар байна².

Хүний хувийн мэдээлэл цуглуулж буй өнөөгийн байдлыг схемчилбэл:



1 дүгээр зураг

¹ Хууль зүй, дотоод хэргийн яам, "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай" хуулийн төсөл <https://mojha.gov.mn/newmojha/?topic=%d1%85%d2%af%d0%bd%d0%b8%d0%b9-%d1%85%d1%83%d0%b2%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%bc%d1%8d%d0%b4%d1%8d%d1%8d%d0%bb-%d1%8d%d0%bb-%d1%85%d0%b0%d0%bc%d0%b3%d0%b0%d0%b0%d0%bb%d0%b0%d1%85-%d1%82%d1%83%d1%85%d0%b0>

² Мөн тэнд



Зураг №1-д үзүүлснийг тайлбарлавал хүний хувийн мэдээлэл "Хувь хүний нууцын тухай" хуулиар хамгаалагдаж, "Иргэний хууль", "Салбарын хууль", "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хуулиудаар мэдээллээ өгнө. Харин хүний хувийн мэдээллийг хүлээн авсан хувь хүн хуулийн этгээд нь "Байгууллагын нууцын тухай" хуулиар, төрийн байгууллагын хувьд "Төрийн болон албаны нууцын тухай" хуулиар тус тус хамгаалах үүрэг хүлээнэ.

Хувь хүний мэдээлэл цуглуулах өнөөгийн эрх зүйн орчныг схемчилбэл:



2 дугаар зураг

Хүний хувийн мэдээлэл цуглуулахад тулгамдаж буй асуудал.

Монгол Улсад хүний хувийн мэдээлэл цуглуулах түүнтэй холбоотой харилцааг нарийвчилсан зохицуулалт тодорхой бус байгаагаас хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллагууд нь эрхлэх үйл ажиллагаанд хамаарал бус мэдээллийг цуглуулж байна. Энэ нь хүний хувийн мэдээллийг бусдад дамжуулах, хувийн сонирхлоор ашиглах, олон нийтийн сүлжээгээр тараах зэрэг үйлдлүүдийг бий болгож байна.

Нийгэмд үүсэж, тулгамдаад байгаа асуудал бол хүний хувийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр, олон нийтийн сүлжээнд тараах зэргээр хувь хүний нууц, хүний нэр төр, алдар хүндэд халдсан үйлдэл олноор гарч буй явдал юм. Дээрх байдал хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, хамгаалахтай холбоотой харилцааг хуулиар зохицуулаагүй байгаа ч өнөөгийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхгүй байгаатай ч мөн холбоотой.

Хүний хувийн мэдээлэл цуглуулж буй хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллагууд нь зөвхөн хувь хүний нууцын тухай хуульд зааснаас бусад

мэдээллийг задруулахад хууль зөрчихгүй гэсэн ойлголтоор хууль хэрэгжүүлж байгаа нь харамсалтай юм. Энэ байдал нь эрхлэх үйл ажиллагаанд хамаарал бус мэдээллийг цуглуулах, түүнийг боловсруулах, бусдад дамжуулах, анхны зорилгоос өөр зорилгоор ашиглаж байгаа нь хүний хувийн мэдээллийг дур зоргоороо ашиглаж буй явдал юм.

Хүний нэр төр, алдар хүндэд халдаж болзошгүй маш олон мэдээллийг эрх зүйн хамгаалалтгүйгээр эрхгүй этгээдэд өгч байна. Жишээ нь зөвхөн зээл авахтай холбоотой банк болон банк бус санхүүгийн байгууллагын цуглуулж буй доорх мэдээллүүд байна. Үүнд:

1. Гэр бүлийн мэдээлэл, хамаатан садны мэдээлэл.
2. Банк болон банк бусаас авсан төлөгдсөн болоод төлөгдөөгүй зээлийн мэдээлэл.
3. Ажил эрхлэлтийн, боловсролын гэх мэт мэдээллүүд байна.

Энэ мэтчилэн маш олон байгууллагууд өөрсдийн үзэмжээр мэдээлэл цуглуулж байгаа нь эргээд хариуцлагын тогтолцоо тодорхойгүй байгаа нь цаашлаад маш олон эрсдэл учирч болзошгүй байна. Хүний хувийн мэдээлэл цуглуулахтай холбоотой ажил үүрэг, чиглэлтэй холбогдуулан мэдээлэл цуглуулах зайлшгүй шаардлага урган гарч байна. Хүний хувийн мэдээлэл цуглуулах эрх бүхий субъектийн эрхийг баталгаажуулах түүнээс үүсэх эрх зүйн хариуцлагыг тодорхой болгож мэдээлэл цуглуулах хязгаарлалтыг тодорхой болгох шаардлагатай юм.

Сошиал орчинд хүний нэр төр, алдар хүндэд ноцтойгоор халдаж буй бичлэг, мэдээллүүд маш их гарч байгаа зөрчлийг НҮБ-ын "Хүний эрхийн түгээмэл тунхаглал", Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжууд зохицуулж чадахгүй байна. Ялангуяа энэ байдал сонгуулийн үеэр маш их гардаг бөгөөд өрсөлдөгчөө сонгуульд ялагдаулах үндсэн арга хэрэгсэл болгож байна. Улмаар энэ байдал үргэлжилбэл хүний нэр төр, алдар хүндэд халдсанаас үүдэж амиа хорлолт, ялгаварлан гадуурхалт явагдаж Үндсэн хуулиар



олгогдсон хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй дархан байдалд аюул учирч болзошгүй нөхцөл байдал үүснэ.

Зөвхөн амиа хорлолтой холбоотой судалгааг харахад 2012-2016 онуудад нийт 2055 хүн, жилд дунджаар 411 хүн амиа хорлосон байна. Үүнээс 2012 онд 484, 2013 онд 397, 2014 онд 441, 2015 онд 388, 2016 онд 333 хүн амиа хорлосон байна³. Дээрх судалгаанаас хохирогчийг гарцаагүй байдалд хүргэсэн ноцтой шалтгаан, амиа хорлоход хүргэсэн субъектыг ч бүрэн тогтоож чадсан эсэх нь эргэлзээтэй. Энэ мэт олон гэмт хэрэг, зөрчил хүний нэр төр, алдар хүндэд халдсанаас үүсэж бий болсон байхыг үгүйсгэхгүй юм.

Хүнийг үндэслэлгүйгээр гүтгэх, доромжилсон талаарх хэрэг маргааныг Зөрчлийн хуулиар шийдвэрлэж байсныг Эрүүгийн хуулиар шийдвэрлэдэг болгон өөрчилсөн. Энэхүү зохицуулалт нь үндэслэлгүйгээр худал мэдээллээр хүнийг гүтгэх, доромжилсон талаарх маргааныг шийдвэрлэж байгаа.

Харин хүнийг үндэслэлгүйгээр бус мэдээлэл цуглуулсан эрхийн хүрээнд үндэслэлтэй, хувь хүний өөрийнх нь зөвшөөрлөөр хүлээн авсан бодитой үнэн мэдээллээр хүний нэр төрд халдах хандлага ажиглагдаж байна. Амьдрал дээр хүний хувийн мэдээллийг өөрийнх нь зөвшөөрлөөр хүлээн авсан хувь хүн, хуулийн этгээд нь ямар нэг ашиг сонирхлын үүднээс өөрт нь мэдэгдэлгүйгээр ашиглах, хэрэглэх, түгээж буй үйлдэлд хариуцлага үүрдэггүй жишээ олон байна. Магадгүй эрүүгийн хуульд шинэ төрлийн гэмт хэргээр бүртгэгдэж болохыг ч үгүйсгэхгүй бөгөөд эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгохоор цаашид судлах шаардлагатай юм.

Уг асуудал хүний хувийн мэдээллийг цуглуулсан хувь хүн, байгууллагын хувьд үүрэг хүлээж, хариуцлага тооцох зохицуулалтыг нэн яаралтай чухал байгаа гэдэг нь өнөөгийн үүсэж байгаа байдлаас харж болно. Хүний хувийн мэдээлэл цуглуулахад мэдээллийг

төрөлжүүлэн ангилах тэр тусмаа нууцын зэрэглэлийг тогтоон тус мэдээлэл цуглуулсан байгууллагын хүлээх үүргийг тодорхойлж өгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл цуглуулсан мэдээллийн аль хэсгийг байгууллага хариуцах, учрах үр дагаврыг яаж хариуцах зэрэгт хариулсан эрх зүйн зохицуулалт хийх хэрэгтэй. Хэрвээ ингэж зохицуулалт хийж чадвал хүний хувийн мэдээлэл цуглуулагч байгууллага нь тодорхой хүлээх хариуцлагын хүрээнд мэдээллийг цуглуулж, шаардлагагүй мэдээллийг иргэнээс цуглуулахгүй болно. Ингэж хязгаарлалт тогтоох нь хүний хувийн мэдээлэл алдагдахаас сэргийлэх, алдагдсан хариуцлага хүлээх субъект тодорхой болох зэрэг давуу талтай юм.

Хүний хувийн зарим мэдээллийг төрийн болоод нууцын мэдээлэлтэй харилцах эрхийн хүрээнд ашиглах нь нээлттэй байгаа. Үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллээ төрийн байгууллагаас авах эрхийн хүрээнд олж авсан мэдээллээ хувийн ашиг сонирхлоор ашигласан нь тогтоогдвол эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг болгох нь зөв юм. Хуулиар хүний хувийн мэдээлэл цуглуулахтай холбоотой хариуцлагыг тодорхой болгосноор хязгаарлалт хийх, түүний ашиглалтыг төр хяналт тавих боломж бүрдэнэ.

Үндсэндээ бол хүн хувийн мэдээллээ эрх зүйн баталгаагүй орчинд эрхгүй этгээдэд өгч байгаа нь өөрийнх нь нэр төр, алдар хүндэд халдсан үйлдэл, эс үйлдэхүй бий болгох болзошгүй эрсдэлтэй юм. Монгол Улсын хууль тогтоомжид тухайлан тодорхойлсон зохицуулалт байхгүй бөгөөд зөвхөн хувь хүний нууцын тухай, байгууллагын нууцын тухай, төрийн нууцын тухай хуулиудаар зохицуулж байгаа нь хүний нэр төр, алдар хүндэд халдаж буй үйлдэл, эс үйлдэхүй зохицуулаагүй юм.

"Үндсэн хууль"-даа заасан тусгаар тогтносон бүрэн эрхт Бүгд Найрамдах Улсын хувьд "Хүний нэр төр, алдар хүнд"-ийг хамгаалах үүрэгтэй. Иймд хүний нэр төр, алдар хүндийг хамгаалсан эрх зүйн

³ Б.Өнөрмаа, "Амиа хорлох тохиолдол нэмэгдэх хандлагатай байна" <https://vip76.mn/content/48174>



зохицуулалтыг боловсронгуй болгох нэн чухал байна.

Дүгнэлт: Хүний хувийн мэдээлэл цуглуулах, түүний эрх зүйн орчин сэдвээр судалгааны ажлыг хийж байхад Монгол Улсад хүний хувийн мэдээлэл цуглуулахтай холбоотой эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бий болсон байна гэж үзлээ.

Энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн гаргасан "Хувь хүний нууцын тухай", "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хуулиудаар тус тус зохицуулагдаж иржээ. Харин хүний хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой хууль хэрэгжүүлэлтийн хувьд нэлээд учир дутагдалтай төдийгүй өнөөгийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэглээ сул байгаа нь ажиглагдлаа.

Өнөөгийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд хүний хувийн мэдээллийг цуглуулах, хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулалт хийж болох төдийгүй хариуцлагыг ногдуулах боломжтой юм.

Хүний хувийн мэдээллийг Монгол Улсад мөрдөгдөж нууцын тухай хуульд нийцүүлэн дараах нууцын зэрэглэлээр төрөлжүүлэн цуглуулж авах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндсэн суурь нөхцөл болно. Үүнд:

1. Хүний хувийн мэдээллийг хүлээн авснаар "Хувь хүний нууцын тухай" хуулиар хамгаалах;
2. Хүний хувийн мэдээллийг ашиглах, хэрэглэх нь тухайн байгууллагын хувьд "Байгууллагын нууцын тухай" хуулиар хамгаалах;
3. Хүний хувийн мэдээллийг боловсруулж үйл ажиллагаандаа хэрэглэх нь "Төрийн нууцийн тухай" хуулиар хамгаалахаар зохицуулсан зохицуулалтыг хийх.

Дээр дурдсан хуулиудын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр үр дүнтэй ажлыг зохион байгуулж чадвал хүний хувийн мэдээллийг ашиглах, бусдад дамжуулах, олон нийтийн сүлжээгээр тарааж буй үйлдэлд хязгаарлалт тогтоож чадна. Улмаар цаашид хүний хувийн мэдээллийг

цуглуулах, хамгаалах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой бие даасан хуулийн хэрэгцээ шаардлага бий болсон байна.

Уг шинээр гарах хуульд дор дурдсан зохицуулалтыг оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Мэдээллийг төрөлжүүлэн ангилах;
2. Мэдээлэл хүлээн авах субъектыг тогтоож өгөх;
3. Мэдээллийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах;
4. Мэдээллийг задруулсан, зориулалтаас өөр зорилгоор ашигласан этгээдэд хариуцлага ноогдуулах;
5. Хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах тухай зохицуулалтыг тус тус тусгах нь зүйтэй юм.

Өөрөөр хэлбэл хүний хувийн мэдээллийг цуглуулахдаа эрх бүхий субъектын хүрээнд хүлээн авах шаардлагатай юм. Эрх бүхий субъектын хүний хувийн мэдээлэл хүлээн авснаас хойш хүлээх хариуцлагатай нь уялдуулан дараах байдлаар ангилах. Үүнд:

1. Хувь хүний нууцыг хадгалах;
2. Байгууллагын нууцыг хадгалах;
3. Төрийн нууцыг хадгалах;

Дээрх 3 ангиллаас хамаарч мэдээлэл цуглуулах эрх үүсэх бөгөөд хүлээх хариуцлагын хувьд ялгаатай байх тухай зохицуулалт хийх. Энэхүү зохицуулалттай нь уялдуулан мэдээлэл цуглуулах хүрээ, хамаарал мэдээллийн агуулгыг тодорхой болгох юм. Үүнтэй уялдуулан мэдээлэл цуглуулах хэлбэр ч 3 ангилагдах бөгөөд эрх бүхий субъектын баталгаажсан эрхээс хамаарч доорх хэлбэрүүдийг хэрэглэх эрх үүснэ. Үүнд:

1. Утсан харилцаагаар
2. Цахим хэлбэрээр
3. Цаасан хэлбэрээр

Дээрх хэлбэрээр мэдээлэл цуглуулахад эрх бүхий субъектыг тодорхой болгож эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл мэдээлэл цуглуулах арга, хэлбэрээс хамаарч уг мэдээллийн эрх зүйн чадамжийн асуудлыг тогтоох шаардлагатай. Энэ нь цуглуулсан мэдээлэлтэй холбоотой үүсэж болох үр дагаврыг тооцоход эрх зүйн чадамжтай байхтай холбоотой юм.



Энэхүү зохицуулалтыг хийснээрээ хүндийг хэрхэн яаж хамгаалах тухай эрх Монгол Улсад хүний нэр төр, алдар зүйн хамгаалалт бий болно.

Ашигласан материал:

Нэг. Судалгааны материалууд

1. Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт 2018 он. Харьцуулсан судалгаа. Хууль зүйн үндэсний хүрээлэн;
2. Хэвлэл мэдээллийн эрх зүй. Нэр төр гутаах, онлайнаар үзэл бодлоо илэрхийлэх ба өөрийн зохицуулалт. Сургалтын гарын авлага 2015 он. Тоби Мендел;
3. Хүний заяагдмал эрхийн салшгүй хэсэг болох нэр нэр төр, алдар хүндийн тухай ойлголт. Ш.Сүхбаатар. Шинжлэх ухааны академийн мэдээ. 2010 оны №03(197);
4. "Мэдээллийн эрх чөлөө" эрх зүйн харьцуулсан судалгаа. 2008 он Юнеско. Парис. Тоби Мендел. <http://www.unesco.org/>
5. Ханнс Зайделын сангийн вэб сайт <https://www.mongolia.hss.de/>mn, фэйсбүүк хаяг: <https://www.facebook.com/HFSFMongolia/>;

Хоёр. Ном сурах бичиг, гарын авлага

6. Ж.Амарсанаа. Хууль зүйн тайлбар толь.
7. Н.Лүндээжанцан, Ч.Энхбаяр., "МУ-ын Үндсэн хуулийн эрх зүй" 2000 он.
8. Б.Чимид. "Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл"., 2004 он.

Гурав. Гадаад хэл дээрх эх сурвалж

9. Уважайте репутацию бизнеса и их защиту. Защита чести, достоинства и деловой репутации. Когда нужно обращаться в суд, чтобы защитить свою честь, репутацию и репутацию? <https://ok-krossovki.ru/>
10. Атака на честь и честь. порядок защиты чести, достоинства и достоинства. <https://choos-evoice.ru/>
11. Personal data policy. <https://www.rsbp-mn.org/en/personal-data.html>
12. Privacy policy. <https://www.thiess.com/en/privacy-policy>

ЦЭРГИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ БОЛОМЖ

С.ДЭНСМАА /ҮБХИС-ийн Дотоод аудитын албаны боловсролын чанарын үнэлгээний мэргэжилтэн, доктор (Ph.D)/

Түлхүүр үг: Магадлан итгэмжлэл, сургалтын хөтөлбөрийн чанар, цахим технологи, багшийн хөгжил.

Key words: accreditation, curriculum quality, online technology, teacher development.

Оршил. Үндэсний батлан хамгаалахын их сургууль /ҮБХИС/ нь *"Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах нийтлэг эрх ашигт нийцсэн цэргийн болон иргэний боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний тэргүүлэх менежменттэй судалгааны их сургууль болох"* гэж эрхэм зорилгоо тодорхойлж, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах чиглэлээр нэлээдгүй арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна.

Тус сургуулийн сургалтын зарим хөтөлбөрийг магадлан итгэмжлэлд оруулсан байдал, түүний үр дүнд чанарын удирдлагын менежментийн нөлөөлөл, багшийн хөгжилд цахим технологийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийн чанарын баримт бичиг судлах, мэдээллийг ярилцлага, асуумжаар цуглуулах, харьцуулах, задлан шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх зэрэг тоон болон чанарын стандарт болон стандарт бус холимог судалгааны аргуудыг хэрэглэхийн ач холбогдол улам бүр нэмэгдсээр байна.

Үндсэн хэсэг. Боловсролын байгууллагын хөгжлийн чиг хандлага нь дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий, өндөр бүтээмжтэй мэргэжилтэн бэлтгэхэд чиглэгдэж, дээд боловсролын үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэхийн тулд сургуулиуд хөтөлбөрийн чанараар өрсөлдөх хандлагатай боллоо.

Үүний нэг тод жишээ болсон ҮБХИС нь "судалгаа-сургалтын их сургууль" болох хөгжлийн чиглэлийг сонгож, "Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого судлалаар бүс нутагтаа тэргүүлэх их сургууль болох" алсын хараатайгаар бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтэд

чанарын удирдлагын тогтолцоог өргөн нэвтрүүлэх зорилго, чиглэлтэй байна.

Сургалтын чанарыг тодорхойлогч хүчин зүйлсэд: Менежмент ба манлайлал, багшийн хөгжил, сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, үнэлгээ зэрэг багтдаг¹. Тиймээс тус сургуулийн 300 гаруй сонсогч, оюутны дунд сэтгэл ханамжийн судалгаа явуулахад багш нарын мэргэжлийн ур чадвар сайн, оюутанд өгөөжтэй, суралцаж буй хөтөлбөртөө сэтгэл хангалуун байдаг, хичээлүүд үр өгөөжтэй гэж 80 хувь нь хариулжээ. Мөн БМИҮЗ-ийн шинжээчдийн тайланд 8 үзүүлэлтээр 23 зөвлөмж өгсний дагуу тухайн ажлуудыг сайжруулж, зөвлөмжийг үндсэнд нь хэрэгжүүлсэн. Дээд боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн комисс "Төлөвлөлт, чанарын баталгаажилт" шалгуурыг Үндэсний батлан хамгаалахын их сургууль "Бүрэн хангасан²" гэж дүгнэжээ.

Мөн түүнчлэн ҮБХИС нь 2020-2021 онд магадлан итгэмжлэгдсэн цэргийн бакалаврын 4 хөтөлбөртэй болсон нь хөтөлбөрийн чанарын баталгаажилтад эерэг нөлөөлөл үзүүлэх хүчин зүйлс болсон, сургуулийн үйл ажиллагааг боловсролын шинэчлэл, сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд мэдлэг, ур чадвар, чадамжтай, зөв хандлагатай, өөрийгөө байнга хөгжүүлдэг хүний нөөцийг чанарын удирдлагын тогтолцооны нэг элемент болгон өөрчилж ажилласан, ажлын гүйцэтгэлийн байдалд чанарын ахиц дэвшил гарсан гэсэн дүгнэлт хийхээр байна.

ҮБХИС-д хэрэгжиж байгаа боловсролын хөтөлбөрүүд нь "Ерөнхий суурь", (General

¹ "Боловсролын чанар, үр дүн" Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ 2018 он. Т-535.

² ДБМИҮЗ-ийн тайлан



education), "Мэргэжлийн суурь" (Core), "Мэргэжлийн" (Major), болон "Чөлөөт сонголт" (Free elective) гэсэн бүтэцтэйгээр, сургалтын үйл явцыг төлөвлөх, зохион байгуулах болон багш суралцагчдын хамтын үйл ажиллагааны зохист горим буюу сургалтын үйл явцыг төлөвлөн шинэчлэхдээ суралцагчийн бүтээлч ажиллагаанд нийцүүлэн боловсруулагдсан юм. Суралцагчийн хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, чадамж, хандлагыг тухайн хөтөлбөрийн зорилго, зорилтуудтай уялдуулж, ямар мэдлэг, ур чадвар, чадамж, хандлагыг сургалтын аль хэсэгт эзэмшихийг матрицад оруулж, төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь шинэ хөтөлбөрийн шинэчлэлийн уламжлалт хөтөлбөрөөс ялгагдах гол онцлог болсон.

Хүснэгт 1.

Хөтөлбөрийн шинэчлэлийн хамаарал

Уламжлалт хөтөлбөр	Шинэ хөтөлбөр
<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн агуулга мэдлэгт тулгуурласан; • Багш төвтэй сургалт зонхилсон; • Мэдлэг дамжуулах технологид түлхүү суурилсан; • Практик ур чадвар эзэмшүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн агуулга, зорилго, зорилтууд нь үр дүнд чиглэсэн; • Суралцагч төвтэй сургалт зонхилсон; • Мэдлэг бүтээлгэх, хэрэглэх, туршин хэрэгжүүлэх технологид суурилсан; • Ур чадвар, чадамжийг байнга нэмэгдүүлэхэд чиглэгдсэн.

QMP 1 – Customer focus³

QMP 2 – Leadership

QMP 3 – Engagement of people

QMP 4 – Process approach

QMP 5 – Improvement

QMP 6 – Evidence-based decision making

QMP 7 – Relationship management

Их сургууль хөтөлбөр чанартай хэрэгжүүлэхэд нөлөөлөхүйц дараах хэд хэдэн хүчин зүйлс байна гэж үзсэн. Үүнд:

- ҮБХИС нь хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөлтийг сургалтын явцын график, төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж хичээлийн жилээр хэрэгжүүлэхээр тооцоолсон. Хөтөлбөрийн дэд хороод хөтөлбөрт орсон агуулгын сайжруулалтыг нарийвчлан

хэлэлцэж, Хөтөлбөрийн нэгдсэн хороонд танилцуулан баталгаажуулж, материаллаг болон материаллаг бус орчинд адил тэгш ач холбогдол өгдөг.

- ҮБХИС нь хэрэгжүүлж буй хөтөлбөрүүддээ чанарын дотоод баталгаажуулалт хийх үйл ажиллагааг орц, үйл явц, гарц-үр дүн, үр нөлөөний цогц байдлаар үнэлгээ хийхэд чиглүүлдэг.
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд чанарын баталгаажуулалтыг их сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, зорилтууд болон дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд хийгдсэн боловсрол олгох мэргэжлийн чиглэлийн нийтлэг шаардлага, хүрэх үр дүнтэй уялдуулан сайжруулдаг.
- Багш, суралцагчийн практик чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, их сургуулийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй уялдуулан илтгэх, мэтгэлцэх ур чадварыг дээшлүүлэх, хувь хүний хөгжил төлөвшлийн сургалтыг тогтмол зохион байгуулдаг.
- ҮБХИС сургалт, судалгааны ажил үйлчилгээг улам чанаржуулах, мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг байнга дээшлүүлэхийн тулд мэргэжлийн бусад байгууллагуудад суралцагчдыг дадлагажуулах, хамтарсан судалгаа явуулахад анхааран ажилладаг зэрэг болно.

Хөтөлбөрийн шинэчлэлийг багшийн хөгжилтэй шууд харилцан хамааруулан "SWOT" шинжилгээ хийж байх нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлт, чанарын баталгаажилтыг хангахад нөлөөлж буй үндсэн хүчин зүйл гэж тодорхойлсон.

Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах үндэс нь багшийг хөгжүүлэх, ялангуяа тэдний судалгааны арга зүйг дээшлүүлэхэд анхаарч байна. Судлаач-багш нарыг уламжлалт онолын чиг хандлагаар

³ International Organization for Standardization. "Quality management principles". ISO Central Secretariat Chemin de Blandonnet 8 Case Postale 401 CH – 1214 Vernier, Geneva. Switzerland. P-1.



2 дугаар хүснэгт. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, багшийн хөгжлийн харилцан хамааралд хийсэн SWOT шинжилгээ

Давуу тал (S)	Сул тал (S)
<ul style="list-style-type: none"> • Цэргийн сургалтын 4 хөтөлбөр үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн. • Сургалтын хөтөлбөрийн төрөлжсөн чиглэлд хамаарах цэрэг, батлан хамгаалах, нарийвчилсан хөтөлбөрөөр дагнасан сургалт явуулдаг. • Сургалтын хөтөлбөрийн үр дүнтэй хэрэгжүүлж ирсэн туршлагатай. • Сургалтын хөтөлбөрүүдэд дотоод чанарын баталгаажуулалт хийж тогтвортой байдалд шилжүүлсэн. • Хөтөлбөрийн нэгдсэн болон дэд хороод байгуулагдаж үйл ажиллагаа нь жигдэрч байна. • Сургалтын хөтөлбөрүүдийн зорилго, зорилтууд нь үр дүнд бүрэн чиглэгдсэн. • Хөтөлбөрийг хэрэгжүүлэх материаллаг болон материаллаг бус орчин бүрдсэн. • Цэргийн мэргэжлийн хөтөлбөрөөр сургууль төгсөгчид салбартаа төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн. • Хөтөлбөрүүд нь суралцагчийн ёс зүй, иргэний төлөвшил, эх оронч үзэл, бие даан тасралтгүй хөгжихөд чиглэгдсэн. • Цэргийн боловсрол олгох хөтөлбөрийг ур чадвар, чадамжид чиглүүлэн хэрэгжүүлэх хээрийн сургалтын иж бүрэн төвтэй. 	<ul style="list-style-type: none"> • Цахим, зайн болон виртуал сургалтын орчин бүрдүүлэлт удаашралтай. • Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй /харьяаллын сургууль, тэнхим, багш/. • Интернетийн хурд хангалттай бус, Wi Fi орчны хамрах хүрээ дутмаг. • Интернетийн мэргэжлийн сургалт явуулах нарийн мэргэжлийн лаборатори дутмаг, техникийн шинэчлэл удаашралтай. • Зарим хөтөлбөрт шаардагдах үндсэн сурах бичиг, ном гарын авлагын фонд бүрдүүлэлт дутмаг. • Багш нарын зарим хэсэг нь сурган боловсруулах үйлчилгээндээ орчин цагийн арга, эв дүй, технологи нэвтрүүлэлт орчин цагийн шаардлагын түвшинд зарим талаар хүрэхгүй байна. • Сургалтын орчин, технологийн хоцрогдолтой байдал; • Багш нарын цалин, урамшуулал бага байгаа нь тогтвор суурьшилтай ажиллахад нөлөөлдөг; • Эрдэм шинжилгээ, инновацийн дорвитой бүтээлүүд гарах нөхцөл бүрдээгүй; • Доктор зэрэгтэй багшийн тоо маш цөөн; • Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг урамшуулах механизм хангалттай бүрдээгүй;
Боломж (O)	Эрсдэл (T)
<ul style="list-style-type: none"> • Өрсөлдөх чадварын үзүүлэлт тогтвортой • Цэргийн хөтөлбөрөөр суралцуулах тогтмол захиалгатай, суралцагчийн эрэлт өндөр. • Цэргийн мэргэжлийн шинэ хөтөлбөр нээх хэрэгцээ, шаардлага нэмэгдэж байгаа. • Нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу инженерийн хөтөлбөр шинээр нээх, өргөтгөх, хөрвөх чадамж эзэмшүүлэх боломжтой. • Үндсэн хөтөлбөрөөр зохион байгуулах танхимаас гадуурх сургалтын төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх боломжтой. 	<ul style="list-style-type: none"> • Цэргийн мэргэжлийн хөтөлбөрөөр суралцагчдын захиалга жил бүр хэлбэлзэж, тоо цөөрсөн. • Сургалтын орчин техник, технологийн чиглэлээр хоцрогдох; • Төсвийн хүрэлцээ бага байгаагаас төгсөгчдийн чанарт нөлөөлөх; • Судалгаа, инновацыг санхүүжүүлээгүйгээс эрдэм шинжилгээ, инновацийн бүтээлийн тоо багасах.

нэг талаас "Судалгааны ажил явуулахгүйгээр чанартай багш байх боломжгүй"⁴, нөгөө талаас "Хичээл заахгүйгээр чанартай судлаач байх боломжгүй" гэж үзэж ирсэн байна. Харин орчин үед эдгээр ойлголтын харилцан хамаарлын асуудлыг судлах чиглэлтэй⁵ болсон байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн албан тушаалын орон тоонд тавих нийтлэг шаардлага"⁶ -ыг тодорхойлж өгсөн ба ерөнхий шаардлагаас гадна, бүтээлч чадвар, мэргэжлийн болон судалгаа шинжилгээний гэсэн тусгай

чадваруудыг ангилсан байдаг. Энэхүү шаардлагын хүрээнд шинжлэх ухааны олон салбарын өргөн хүрээтэй мэдлэг, ур чадвартай байх тусгай шаардлага тавигддаг. ҮБХИС-ийн үндсэн үүрэг нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлал батлан аюулгүй хамгаалах бодлого, төрөөс боловсрол, шинжлэх ухааны талаар баримтлах бодлого зорилтод нийцүүлэн иргэний нийгэм, батлан хамгаалах салбар, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагын хүний нөөцийг бэлтгэхэд оршдог.

⁴ Research and Teaching: Conditions for a positive link. Teaching in Higher Education, 6 (2001), pp 47.

⁵ Paul R. Carlile. The Cycles of Theory Building in Management Research. School of Management Boston University Boston, MA 02215. p-10. <http://www.hbs.edu/faculty/publication%20files/05-057.pdf>

⁶ БСШУ-ны сайдын 2003 оны 139 дугаар тушаал. "Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн албан тушаалын орон тоонд тавих нийтлэг шаардлага". www.legalinfo.mn/law/details/8416



Сүүлийн жилүүдэд ҮБХИС-ийн багш нарын 58 хувь нь 15-17кр, 19 хувь нь 21-25кр, 12 хувь 26-30кр, 11 хувь нь 31кр⁷ түүнээс дээш цагийн хичээл заажээ. Судалгааны үр дүнгээс дүгнэж үзвэл ҮБХИС-ийн нийт багшлах бүрэлдэхүүн жилд дунджаар 30-40 орчим хувь илүү цагийн сургалтын ажил үйлчилгээ үзүүлжээ.


ҮБХИС-ийн цэргийн мэргэжилтэй багш нараас докторын зэрэг хамгаалсан хүний тоог насны хувьд харьцуулбал бусад их, дээд сургуулиас харьцангуй бага байна. ҮБХИС-ийн 232 багш оролцсон бидний асуулгын аргаар явуулсан судалгаагаар **“Та судлаач багш болоход сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг нэрлэнэ үү?”** гэсэн асуултад оролцогчдын 28 хувь нь судалгааны арга зүй дутагдаж байна, 25 хувь нь судалгаа хийх орчин нөхцөлийн хангалттай бус, 23 хувь нь багшийн цагийн ачаалал их байна, үлдсэн 24 хувь нь бусад хүчин зүйлсийг нэрлэсэн юм.

Уг судалгаанаас үзэхэд судлаач-багшийн хөгжлийн чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн хувьд **нэгдүгээрт**, багш нарт эрдэм шинжилгээ, судалгааны арга зүй дутагдаж буй байдал; **хоёрдугаарт**, сургалт, эрдэм шинжилгээний ажлын орчин нөхцөлийн хангалтгүй байдал; **гуравдугаарт**, багшийн цагийн ачаалал их байгаа зэрэг асуудал орж байна.

Судалгааны үр дүнгээс дүгнэж үзвэл сургуулийн багшлах бүрэлдэхүүний дунд боловсролын докторын зэрэгтэй, эрдэм шинжилгээний ажлыг удирдах, гүйцэтгэх чадвартай багшийн эзлэх хувь 6-7 хувьтай байгаа нь үндэсний бусад их сургуулиудтай харьцуулахад 25-40 хувиар доогуур үзүүлэлт гарчээ.

Багшийн хөгжил гэдэг нь: хувь багш өөрийгөө өөрчлөх бүхий л боломжийг ашиглан мэргэжил, мэргэшил боловсролоо байнга дээшлүүлж, цаг ямагт өсөж хөгжиж байдаг идэвхтэй хандлага үйл явц юм⁸. Судалгааны үр дүнгээс үзэхэд цэргийн сургалтын хөтөлбөрийг сайжруулахад **нэгдүгээрт**, цахим технологийн инновацыг нэвтрүүлэх,

■ 5-10 кредит ■ 11-15 кредит цаг ■ 11-15 кредит цаг
■ 21-25 кредит цаг ■ 26-30 кредит цаг ■ 31-ээс дээш кредит цаг



1 дүгээр зураг. Та сүүлийн жилүүдэд жилд дунджаар хэдэн кредит цагийн хичээл заасан бэ? гэсэн асуултад хариулсан байдал.

хоёрдугаарт, багшийг хөгжүүлэх гэсэн үндсэн 2 арга зам байж болохоор байна.

ҮБХИС-ийн багш нарт цахим техник хэрэгслийн туршилт, судалгаа хийх хэрэгцээ шаардлага улам их нэмэгдэх хандлагатай байна. Тиимээс ҮБХИС-д сургалтын инновацыг нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, сургалтын цахим технологийг нэвтрүүлбэл илүү үр дүн, ач холбогдолтой гэж үзэж байна. Зарим хичээлийг багш цахим хэлбэрээр оюутан, сонсогч нарт хүргэж, тухайн хичээлийн цагт багш өөрийгөө хөгжүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажлын арга зүйгээ дээшлүүлэх, судалгаа хийх, бүтээл туурвих замаар багш нарын цагийн ачааллыг багасгах боломж бий болно.

Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын орчин, нөхцөлийг дээшлүүлэхийн тулд ҮБХИС нь төрийн өмчийн их сургуулийн хувьд бодлогын дэмжлэг үзүүлэх замаар өөрийн харьяа хүрээлэн, сургуулиудыг цэрэг-иргэний зориулалттай орчин үеийн хичээлийн байр, лаборатори, зэвсэглэл техник, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр хангах арга хэмжээ авах шаардлагатай байна. Ялангуяа цэргийн шинжлэх ухааны тусгай аргуудыг судалгаанд хэрэглэхэд зориулагдсан лаборатори дадлагын төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авах

⁷ "ҮБХИС-ийн социологийн судалгааны тайлан". БХЭШХ. 2018 он.

⁸ Оюун Ц, Түмэндэмбэрэл Д, "Багшийн хөгжил" УБ.,2005. т-9.



чиглэл барьж ажиллах нь үр дүнтэй гэж ойлгож байна.

Дээрх хүчин зүйлүүдээс хамаарч, багш, судлаач нь эрдэм шинжилгээ, сургалтын ажлыг хослуулан явуулахад тэднийг тусгайлан бэлтгэж, нэн тулгамдсан асуудлуудыг бидний санал болгож буй арга замаар шийдвэрлэвэл судлаач-багшийн хөгжлийн чанарт тодорхой ахиц дэвшил, эерэг өөрчлөлт гарна гэж бид үзэж байна.

Судалгааны үр дүнгээс харахад багшийн дараах чадварыг хөгжүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлэн судлаач-багшийг бэлтгэхийг санал болгож байна. Үүнд:

1. Мэдээллийг шинжлэх, боловсруулах, ашиглах, түгээх чадвар;
2. Мэргэжлийн чиглэлээр судалгаа хийх чадвар;
3. Судалгаа хийх, судалгааны үр дүнг амьдрал практикт хэрэглэх чадвар;
4. Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, өөрийгөө хөгжүүлэх чадвар;
5. Өөрчлөлт шинэчлэлийг мэдрэх, хүлээн авах, бүтээлчээр хэрэгжүүлэх чадвар;
6. Эрдэм шинжилгээ, судалгааны арга зүй эзэмших чадвар;
7. Багшийн өөрийн мэдлэг, оюунаа бие даан хөгжүүлэх чадвар;
8. Их сургуулийн хөгжлийн динамик өөрчлөлттэй уян хатан, шуурхай зохих чадвар;
9. Оюутан, сонсогчтой хамтран мэдлэг бүтээх, инновац бүтээх чадвар;
10. Асуудлыг бодитой, логиктой, шударга, зарчимч, оновчтой

тодорхойлон шийдвэрлэдэг чадвар зэрэг орно.

Дүгнэлт

1. ҮБХИС-ийн сургалтад инновацыг нэвтрүүлэх замаар цэргийн хөтөлбөрийг сайжруулах боломж бүрэн байна. Цахим сургалтын инновацыг нэвтрүүлснээр багшийн цагийн ачааллыг 25-30 хувь бууруулах боломжтой болохыг туршлага харуулж байна.
2. Багш нарын хөгжил, хөтөлбөрийн чанар 2 шууд хамааралтай. Судлаач-багшийн хөгжлийн чанарт сөргөөр нөлөөлж буй голлох хүчин зүйлс нь багш нарт эрдэм шинжилгээ, судалгааны арга зүй дутагдаж буй байдал; сургалт, эрдэм шинжилгээний ажлын орчин нөхцөлийн хангалтгүй байдал; багшийн цагийн ачаалал их байгаа зэрэг асуудал орж байна.
3. Цахим технологийг нэвтрүүлснээр сургалтын хөтөлбөр сайжрах, багш хөгжих, нөгөө талаар энэхүү технологийг нэвтрүүлэхэд багш өөрөө оролцож хөгжих боломжтой.
4. Өөрийн харьяа хүрээлэн, сургуулиудыг цэрэг-иргэний зориулалттай орчин үеийн хичээлийн байр, лаборатори, зэвсэглэл техник, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр хангагдсан сургалтын материаллаг орчныг бүрдүүлж, багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын орчин, нөхцөлийг сайжруулах шаардлага тавигдаж байна.

Ашигласан материал:

1. "Боловсролын чанар, үр дүн" Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. ҮБ 2018 он. Т-535.
2. ДБМИҮЗ-ийн тайлан.
3. International Organization for Standardization. "Quality management principles". ISO Central Secretariat Chemin de Blandonnet 8 Case Postale 401 CH – 1214 Vernier, Geneva. Switzerland. P-1.
4. Research and Teaching: Conditions for a positive link. Teaching in Higher Education, 6 (2001), pp 47.
5. Paul R. Carlile. The Cycles of Theory Building in Management Research. School of Management Boston University Boston, MA 02215. p-10. <http://www.hbs.edu/faculty/publication%20files/05-057.pdf>
6. БСШУ-ны сайдын 2003 оны 139 дугаар тушаал. "Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн албан тушаалын орон тоонд тавих нийтлэг шаардлага". www.legalinfo.mn/law/details/8416
7. "ҮБХИС-ийн социологийн судалгааны тайлан". БХЭШХ. 2018 он.
8. Оюун Ц, Түмэндэмбэрэл Д, "Багшийн хөгжил" ҮБ.,2005. т-9.



БАГШ ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, ТҮҮНД ХИЙСЭН СУДАЛГАА

Б.МАНДАХБАЯР /Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн дарга, доктор (Ph.D), дэд хурандаа/

Түлхүүр үг: ҮБХИС-ийн багш, багшийн хөгжил, ажлын байр, өөрийгөө хөгжүүлэх, хөгжих арга зам.

Key words: MNDU-teacher, teacher development, workplace, self-development, ways of develop

Хураангуй: Даяарчлал, мэдээлэл технологийн зуунд ажиллаж, амьдарч буй өнөө үед дэлхийн түвшний боловсрол эзэмшсэн төгсөгчдийг бэлтгэхэд багш бидний үүрэг, хариуцлага асар их юм. Хөгжсөн багшаас хөгжсөн шавь төрөх учир хөгжсөн багш нь сургуулийн болон боловсролын салбарын өөрчлөлт, шинэчлэлийн үндэс болоод зогсохгүй улс орны хөгжлийн суурь, үнэт эрдэнэ, баялаг юм.

Өнөөгийн боловсролын хөгжлийн шинэ үзэл баримтлалаар багш судлаачийн хөгжлийг ерөнхийд нь тодорхойлбол:

- судлаач, оюун ухааны дасгалжуулагч;
- суралцах үйл явцыг оновчтой зохион байгуулагч;
- хөгжил дэвшлийн хөтөч нь болж байна.

Оршил хэсэг. Өнөө үеийн боловсролын харилцаанд оролцогч талуудын хамрах хүрээ, үйл ажиллагааны чиглэл, хандлагад дэлхийн даяаршил, технологийн хөгжлийн нөлөөгөөр өөрчлөлт гарч боловсролын үнэлэмж нь нийгмийн эрх ашиг, эрэлт, хэрэгцээнд илүүтэй чиглэх болсон учир боловсролын шинэчлэл бүхий л харилцаанд нөлөөлж сургах, суралцах үйл явц нь зөвхөн тухайн сургуулийн асуудал биш болсон.

Аливаа хөгжлийн гол хөдөлгөгч хүчин зүйл нь хүний хөгжил гэдгийг эрдэмтэн, судлаачид аль хэдийн тогтоож энэ талаар онол, загвар боловсруулан туршилт, судалгааны үр дүнгээр баяжуулан хэрэглээнд нэвтрүүлж байна.

Хүний хөгжлийн гол хүчин зүйл бол насан туршдаа тасралтгүй суралцаж нийгэм, соёлын шинэ чиг хандлагыг эзэмших, түүний шаардлагад тохируулан орших бөгөөд энэ үйл явцын алхам

бүрд бэрхшээл урган гарч тэр нь хөгжих нөхцөлийг бүрдүүлж байдаг.

Багшийн хөгжил ихэвчлэн гадаад орчны хүчин зүйлээс хамааралтай болж, зайлшгүй хөгжих орчин нөхцөл бүрддэггүй, эсвэл тэрхүү нөхцөлийг мэдрэхгүй байх, нөгөө талаар үүссэн нөхцөл ба бодит боломжийг ашиглахгүй байгаа нь "Та сургалтад оролц", "Та унших хэрэгтэй", "Та хөгжихгүй бол болохгүй нь" гэсэн хөндлөнгийн шахалт, албадлага аяндаа тавигдахад хүрч байна.

ҮБХИС-ийн хувьд багшийн хөгжил, чанартай боловсрол олгоход ач холбогдол өгч багш судлаачдыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч гадаад, дотоодын их дээд сургууль, байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж урт, богино хугацааны сургалт, дамжаанд багш судлаачдыг оролцуулан, сурган зааварлах үйл ажиллагааг явуулж байгаа хэдий ч үр дүн төдийлөн сайн гарахгүй байна. Иймд ҮБХИС-ийн багшийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг судлан саад бэрхшээлийг даван туулах арга, зам, гарцыг эрэлхийлэхийн тулд энэ сэдвийг судлав.

1. Багшийн хөгжлийн тухай ойлголт.

Монгол Улсын мэргэжлийн боловсролын ууган сургуулийн нэг, тухайн үеийн Богд хаант Монгол Улсын баатар, бүх цэргийн жанжин Дамдины Сүхбаатараар овоглосон, алдар гавьяаны 2 одонтой Үндэсний батлан хамгаалахын их сургууль нь үүсэн байгуулагдаад 100 жилийг ардаа орхижээ.

Энэ түүхэн хугацаанд эх орноо батлан хамгаалах үйлсэд нийтдээ 70.000 орчим боловсон хүчнийг бэлтгэсэн гаргаснаас БНМАУ-ын баатар, УИХ-ын гишүүд, төр,



цэрэг, нийгмийн зүтгэлтэн, гавьяатнууд, олон арван генералууд төрөн гарсныг бид бүхэн сайн мэддэг бөгөөд тэднээр үргэлж бахархаж байдаг билээ.

Энэ нэр хүндтэй сургуульд багшлан гэдэг нэг талаар бахархмаар нөгөө талаас маш өндөр үүрэг, хариуцлага хүлээж байдаг учир багшлах бүрэлдэхүүн өндөр мэдлэг боловсролтой, багшлах ур чадвар, сургах арга зүйтэй, чадварлаг хүмүүс байх ёстой. Чадварлаг байхын тулд багш тасралтгүй хөгжиж байх хэрэгтэй. Тэгвэл багшийн хөгжил гэж юу вэ? гэсэн асуулт гарч ирнэ.

Багшийн хөгжил гэдэг нь: багш хэрэгцээ, шаардлага хангахгүй болсон мэдлэг, арга барил, хандлагаа өөрөө ухамсартайгаар татгалзаж, хэрэгцээтэй шинэ мэдлэг, арга барил, ур чадварыг ухамсартайгаар эзэмшиж авах бүтээлч үйл явц юм гэж тодорхойлж болох юм.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын их дээд сургуулиуд боловсролын шинэчлэл, багшийн хөгжлийн тухай их ярьж, бичиж, арга хэмжээ авч байна. ҮБХИС-ийн хувьд энэ арга хэмжээний хүрээнд тодорхой ажлуудыг хэрэгжүүлж үр дүнд хүрч байна. Тухайлбал:

- НАТО-гийн "Энхийн төлөө шинжлэх ухаан" консорциумаас "Батлан хамгаалах боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг 3 жилийн хугацаатай хэрэгжүүлж "Багшийн хөгжил, заах арга зүйн сургалт"-ыг 5 үе шаттайгаар зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 170 гаруй багш оролцож 10 сургагч багшийг бэлтгэсэн;
- "Үр дүнд суурилсан сургалтыг зохион байгуулах арга, зүй - Менежментийн үндсэн ойлголт" зэрэг сургалтуудад бүрэлдэхүүн сургуулиудын захирал, тэнхимийн дарга нар хамрагдсан;
- НАТО-гийн Олон улсын хэлний зохицуулах хороотой хамтарсан сургалтад ГХСТ-ийн багш нар оролцсон;
- ХБНГУ, Украин, Серб, Бельгийн Вант Улс, Румын болон Словак Улс зэрэг орнуудад зохион

байгуулагдсан богино хугацааны сургалт, семинарт давхардсан тоогоор 30 орчим багш оролцсон;

- Их, дээд сургууль, багшийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан арга зүйн зөвлөгөөнд тодорхой тооны багш нарыг хамруулж байгаа зэрэг болно.

Мөн бусад их дээд сургууль болон ШУТИС-тай хамтран инженерийн боловсролын CDIO-үр дүнд суурилсан сургалтад инженерийн мэргэжлийн багш нар хамрагдаж тодорхой үр дүнд хүрсэн. Мөн багшийн хөгжлийн төвийг байгуулан үйл ажиллагаа нь жигдрээд явж байгаа.

Багшийн хөгжлийг дараах 3 төрөлд ангилж болно. Үүнд:

- Хөгжих бололцоотой багш;
- Хөгжиж буй багш;
- Хөгжсөн багш;

Хөгжсөн багшийн загварыг дараах байдлаар томъёолж, багш бүр энэхүү загварт хүрэхийг зорих нь чухал юм.

1. Төлөвшил хувь хүний шинжээр;
2. Арга зүй, эв дүйн хувьд;
3. Бүтээлч хандлагын хувьд;
4. Дидактик чадварын хувьд гэхчлэн

эдгээр чадвараар томъёолон өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй.

Багш тасралтгүй хөгжих үйл явцын үр дүнд боловсролын салбарт шинэ мэдлэг, шинэ хандлага, шинэ итгэл үнэмшил, соёлын үнэт зүйл үйлдвэрлэгдэн тооны болон чанарын өөрчлөлт гарна. Багшийг хөгжүүлэх сургалтын тогтолцоо нь дараах байдлаар зохион байгуулагддаг.

- Бие даан суралцах;
- Сертификатын сургалт;
- Докторын сургалт;
- Магистрын сургалт;
- Богино хугацааны мэргэшүүлэх сургалт;
- Урт хугацааны сургалт;
- Зайны сургалт;
- Онлайн буюу цахим сургалт;

Багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтод багшийн хөгжлийг хангах талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Эрдэм шинжилгээ, судалгааны



- ажил хийх;
- Илтгэл, ном, гарын авлага, зөвлөмж боловсруулах;
- Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах, бусад багш нарт зориулан сургалт семинар зохион байгуулах;
- Мэргэжил арга зүйгээ ажлын байран дээрээ тасралтгүй сайжруулах гэж заажээ.

Багшийн хөгжлийг менежмент талаас нь авч үзвэл:

1. Багш өөрийгөө хөгжүүлэх хариуцлага, санаачилга, идэвх зүтгэл, зөв хандлага, сахилга баттай байх;
2. Багшийг хөгжүүлэх нэгдмэл бодлого, чиглүүлэх менежерийн туслалцаа, дэмжлэг;
3. Багш бүрийн өөрийгөө хөгжүүлэх хүсэл, сонирхол, зорилго, зорилтдоо захирагдах ёс зүй;
4. Багшийн хөгжлийг байгууллагаас дэмжих тогтолцоо /цалин хөлсийг нэмэгдүүлэх, ур чадварын урамшууллын тогтолцоо, мэргэжил, мэргэшлийг нь дээшлүүлэх болзол г.м/
5. Багшийн хөгжлийн тууштай цогц бодлого;
6. Багшийн ажлын байран дахь мэргэжлийн онол, заах ур чадвар, хамтын бүтээлч ажиллагааны өсөлт, хөгжил гэх мэт. "Хүн өөртөө үнэлгээ өгч чаддаггүй цорын ганц хөдөлмөр бол сурах хөдөлмөр байдаг" гэж Францийн философич Декарт хэлсэн байдаг. Багшийг хөгжүүлэхийн тулд сургалт, зохион байгуулалтын ажлаа өнөөдрөөр хязгаарлах бус алс ирээдүйгээ харсан, олон талын мэдлэг чадвараа тасралтгүй хөгжүүлж байх шаардлагатай.

Өнөө үеийн нийгмийн амьдрал эрчимтэй өөрчлөгдөн хөгжихийн хэрээр суралцагчийн хандлага, эрэлт хэрэгцээ, сонирхолд ч өөрчлөлт гарч байна.

Багш өнөө үед юуг өөрчлөх хэрэгтэй вэ? гэсэн асуулт тун чухал юм. Мэдээж хэрэг бэрхшээл учирч, тулгамдаж байгаа асуудлуудыг нэн түрүүнд өөрчлөх

хэрэгтэй. Тухайлбал багшийн харилцаа хандлага, сэтгэлгээ, арга барил, зан байдал гэх зэрэг олон зүйлийг нэрлэж болно.

Шинэчлэлийн явц нь багшийг тэр тусмаа багш өөрөө өөрийгөө хөгжүүлэн шинэчлэх асуудлыг шууд дэвшүүлэн тавьж байна. Өнөө үед "Багшийн хөгжил" гэсэн ухагдахуун нь багшийн хөгжилд багш бие хүн өөрөө голлох үүрэгтэйг илэрхийлдэг. Ийнхүү шинэ ухагдахууныг дагаад багшийн ажлын утга агуулга өөрчлөгдөж байна.

Монгол Улсын хэмжээнд багш нарыг хөгжүүлэх талаар дараах ажлууд хийгдсэн байна.Тухайлбал:

1. Шаталсан сургалт. Богино хугацаанд багш танхимд суралцан кредит цуглуулна. Мөн бие даан боловсролын зэрэгтэй болох түүнийгээ ахиулах боломжтой болно.
2. Эрхийн бичгийн сургалт. Багш бэлтгэдэг их дээд сургуулиуд тодорхой чиглэл, сэдэв, асуудлаар хөтөлбөр боловсруулж, тэдгээрээс багш нар сонгон суралцана.
3. Богино хугацааны сертификатын сургалт. Уг сургалтаар хөрвөх чадвартай багш бэлтгэдэг.
4. Багш өөрөө бие дааж суралцах, өөрийгөө хөгжүүлэх ажил багшийн хөгжлийн асуудал орчин үед уян хатан, чанартай, багш нарын эрэлт хэрэгцээнд нийцсэн, эрчимтэй, нээлттэй, сонголт хийх боломжтой байх хэрэгтэй.

Багшийн өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа бол багш мэргэжлийн болон сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэг, арга барил, ур чадвар, үзэл бодол, харилцаа, хандлага, сэтгэлгээгээ бие дааж ухамсартайгаар өөрчлөн сайжруулахад чиглэсэн үйлдлүүд юм.

Багшийн өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа нь олон чиглэлтэй. Үүнд:

- Юуны түрүүнд багш өөрийнхөө суурь мэдрэмжээ хөгжүүлэх шаардлагатай;
- Цаг үе нийгэмд гарч буй өөрчлөлтүүдийг соргоогоор мэдрэх мэдрэмжээ хөгжүүлэх нь чухал



- ач холбогдолтой /Цар тахлын үед хэрхэх вэ?/;
- Багш хүн өөрөөсөө байнга нийгэм надад ямар нөлөө үзүүлж байна вэ? ямар шаардлага шинээр тавьж байна гэдгийг хамгийн түрүүнд мэдэрч ухаарч ажилдаа тусгах нь чухал;
 - Сэтгэл судлал болон боловсрол судлалд ямар шинэ өөрчлөлт гарч байгааг мэдэрч дүн шинжилгээ хийн, шинжлэх ухааны шинэ нээлт ололтоос өөрт хэрэгтэйг нь ажилдаа ашиглах нь нэн чухал;
 - Сургалтад баримталж буй үзэл баримтлал зарчим агуулга арга технологид шинээр гарч байгаа өөрчлөлтийг цаг тухайд нь ойлгон мэдэж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь багшийн хөгжлийн хөшүүрэг болно.

2. Багш ажлын байран дээр өөрийгөө хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал

Багшийн хөгжил ажлын байр дээр өөрийгөө хөгжүүлэх асуудалд багшийн өөрийн идэвх санаачилга, сонирхол, хүсэл тэмүүлэл, тууштай үйл ажиллагаа чухал үүрэгтэй байдаг. Багш өөрийгөө хөгжүүлэх нь багш мэргэжлийн болон сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэг, арга барил, ур чадвар, үзэл бодол, харилцаа хандлага, сэтгэлгээ, өөрөө бие дааж ухамсартайгаар өөрчлөн сайжруулах үйлдэл юм.

Юуны түрүүнд тэмдэглэх нэг гол зүйл бол ихэнх хүмүүс, багш өөрийгөө хөгжүүлэхийн тулд заавал ажлаас чөлөөлүүлж, сургалтад хамрагдах, маш их зардал гаргах ёстой гэж үздэг нь явцуу ойлголт одоо болтол оршсоор байна.

Мөн манай зарим багш нар "Өмнөх хичээлээ яая гэж байхад юун өөрийгөө хөгжүүлэх вэ?", "Цаг, зав алга", "Орчин бүрдээгүй байна" гэх мэт маш олон шалтгаануудыг тоочдог.

Багшийн үйл ажиллагаа нь элдэв бичиг баримт бүрдүүлэн дээрээс ирэх шалгалтад үзүүлэх, удирдлагадаа ажлын цагаа бүртгүүлэх, сургалтаас бусад

олон нийтийн ажилд анхаарах зэрэгт илүүтэй чиглэх болж суралцах үйлэнд хандсан бүтээлч, өөриймсөг хандлага багасаж байгаа тал ажиглагдах болсон нь харамсалтай байна.

Багш хүн өөрийн үйл ажиллагаандаа өөрөө дүн шинжилгээ хийж, суралцах үйлийг хамтран явуулж чадвал алдаа, оноо, амжилт бүтээлийнхээ мөн чанарыг ухааран мэдэх боломж бүрдэж энэ нь өөрийгөө хөгжүүлэх гол хүчин зүйл болох юм.

Суралцах үйлийн гол утга нь сургахад бус харин сурах үйлийг суралцагчидтайгаа хамтран бүтээж "Багш, суралцагч хоёр хичээл рүү хамтдаа" гэсэн зарчмыг хэрэгжүүлэхэд оршиж байгаа бөгөөд ингэсэн нөхцөлд багшийн тасралтгүй хөгжих, суралцах хэрэгцээ үүснэ.

Багшийг ажлын байран дээр өөрийгөө хөгжүүлэх боломж, санал

Орчин үед багш өөрийгөө хөгжүүлэх арга ажиллагаа нь ажлын байр дээрээ, ажлаа хийх явцдаа өөрийгөө хөгжүүлэх нь зүйтэй гэсэн үзэл санаа нийтлэг болсон.

Багш өөрийгөө хөгжүүлэхийн тулд яах хэрэгтэй вэ? Түүнд ямар боломж байгааг авч үзье.

Багш өөрийгөө хөгжүүлэхэд дараах зарчмыг баримтлах хэрэгтэй.

1. Багш хүн өөрийнхөө мэдрэмжийг хөгжүүлэх;

А. Цаг үеэ мэдрэх мэдрэмж: багшийн амьдарч буй цаг үе, нийгэмд асар их өөрчлөлт гарч байгааг мэдрэх /цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан сургалтын орчны өөрчлөлт гэх мэт/;

Б. Шинэ зүйлийг мэдрэх түүнийг хүлээн авах мэдрэмж: мэргэжлийн хичээл, сэтгэл судлал, ямар шинэ үзэл санаа, өөрчлөлт гарч байгааг мэдэрч, эдгээрт дүн шинжилгээ хийх, шинэ мэдээллийг хүлээн авахад нээлттэй байх, өөрийнхөө мэргэжлийн үйл ажиллагаанд тусган ажилдаг байх /шинэ үеийн суралцагчтай ажиллах арга барил гэх мэт/;



В. Багшийн зүгээс суралцагчийг мэдрэх мэдрэмж: энэ нь суралцагчийг хүсэл сонирхол, хэрэгцээ, түүний ертөнцийг үзэх үзэл, сэтгэл санаа, бие бялдар, ёс суртахуун зан үйлд гарч буй их, бага бүхий л өөрчлөлтийг мэдрэх;

Г. Багш ажлынхаа үр дагаврыг мэдрэх мэдрэмж: багш хүн өөрийнхөө хэлсэн үг, хийж буй үйлдлийн нөлөө, үр дагавар, үр дүнг мэдрэх мэдрэмж;

2. Харилцаа, ажилдаа хандах хандлагаа өөрчлөх;

3. Багш өөрийнхөө ёс зүйн харилцааны соёлоо төгөлдөржүүлэх;

4. Сургалтын хөтөлбөр хийх: орчин үед дэлхийн олон оронд багшийн найдвартай хөгжих нэг арга зам бол багш өөрөө сургалтын хөтөлбөр хийж, түүнийгээ байнга сайжруулах хэрэгжүүлэх явдал гэж үзэх болсон;

5. Багш хүн судлаач байх;

6. Багш ажлын байранд хамтран сурах: багш нар ажлын байрандаа өөрийгөө хөгжүүлэх ямар арга зүй баримталдаг талаар болон багш ажлын байрандаа хөгжих ямар боломж, бололцоо байгааг цааш нь тодруулан авч үзье.

1. Багш нар хамтран багаар ажиллах арга;

2. Багш сурагчидтайгаа хамтран багаар ажиллах арга;

Орчин үед багш нар багаар ажиллах туршлага ихээхэн дэлгэрч байна.

Жишээ нь: шинээр ирсэн залуу багшийн хувьд ажлын туршлага дутмаг байгаа ч, олон жилээр ажилласан ахмад багшаас компьютер болон гадаад хэлний мэдлэг арай илүү сайн байдаг. Энэ тохиолдолд залуу багшийн хувьд ахмад багш нараасаа ажлын туршлага, мэдлэг, ур чадвараас нь суралцах, залуу багшийн хувьд гадаад хэл болон компьютерын тал дээр нь тусалж, шаардлагатай гэж үзвэл зааж сургаж багш, шавийн барилдлагаар эргэх холбоо /ахмад багш сургагч, залуу багш сурагч / байдлаар хамран ажиллаж болно.

Сайн дурын холбоог байгуулснаар багш нар цаашдаа байнгын тогтвор-

тойгоор хөгжих боломж нээгдэнэ.

Холбооны УРИА нь багш, багшаа дэмжиж, тусалж, хамтдаа хөгжье гэсэн үзэл санааг агуулсан байх хэрэгтэй бөгөөд сайн дурын зарчмаар байгуулагдаж, цаашдын ажиллах зарчмыг маш тодорхой сайн гаргаж өгөх ёстой.

Багш суралцагсадтайгаа хамтран ажиллах арга зүй: багш өөрийн үйл ажиллагаандаа өөрөө дүн шинжилгээ хийж суралцах үйлийг хамтран явуулж чадвал алдаа оноо, амжилт бүтээлийнхээ мөн чанарыг ухааран мэдэх боломж бүрдэж энэ нь өөрийгөө хөгжүүлэх гол хүчин зүйл болно.

3. Багш ажлын байранд суралцах хэлбэр;

4. Ажлын байран дээр суралцах нь багшийг хөгжүүлэх сургалтын тасралтгүй байх нөхцөлийг хангадаг. Ажлын байран дээр суралцах нь өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг болсон нөхцөлд багшийн хөгжил тасралтгүй явагдана.

Багшийг хөгжүүлэхийн тулд сургууль, тэнхимээс дараах ажлыг зохион байгуулах. Үүнд:

- Өдөр тутмын болон албан бус уулзалт /цай, кофе уух зуур ярилцах, заавал ширээний ард уулзах биш/;

- Шавилан суралцах;

- Суралцагчийн хөтөлбөр;

- Мэргэжлийн хичээлүүдийг сэлгүүлэн заалгах;

- Төслийн ажил боловсруулах;

Багшийг хөгжүүлэхийн тулд тухайн салбар сургууль болон их сургуулийн зүгээс тодорхой ажиллаж, амьдрах, хөгжих орчин нөхцөлийг маш, сайн бүрдүүлэх, нийгмийн халамжийн дэмжлэг үзүүлэх, оновчтой зөв тасралтгүй бодлогоор хангах.

Монголын Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050" хөтөлбөрт: хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе, чанартай боловсрол олгох, насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх үе, насан туршдаа суралцахуйг дэмжсэн нээлттэй боловсролын тогтолцоог бэхжүүлэх гэсэн үе шатуудаар



чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэхээр тусгасан нь бүх багш нарыг мэргэшүүлэх бодлогыг боловсронгуй болгож дэлхийн хөгжингүй орнуудын нийтлэг жишигт хүргэх, хүний эзэмшсэн боловсрол нь эргээд өөрт нь цаашид тасралтгүй суралцах, улмаар өрсөлдөх чадвар бүхий хүний нөөцийн чадавхыг бий болгох бодлого, стратегийн шийдлийг тусгасан.

Дүгнэлт

ҮБХИС-ийн хэмжээнд багш ажлын байранд дээр өөрийгөө хөгжүүлэх ажлыг бодлогын удирдамжаар ханган, анхаарч авч үзсэнээр суралцагчдын боловсролын чанар, дээшилж, сургалтын шинэчлэл үр дүнд хүрч, улс болон бүс нутагт өрсөлдөх чадвартай, хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий шинэ дүр төрхтэй Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн шинэ дүр төрх бий болно. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэхэд сургуулийн удирдлагууд, бүрэлдэхүүн сургуулиуд, төв /тэнхим/ гэхээсээ илүүтэйгээр багш нэг бүрээс оруулах хувь нэмэр асар их бөгөөд хувь хүний ухамсар, нийгмийн идэвх, сургуулийн төлөө гэсэн чинь хүсэл, зөв хандлага, оюун ухаан, цаг хугацаа, хөрөнгө мөнгө шаардагдах нь гарцаагүй.

Энэ бүхнийг оновчтой төлөвлөж, зөв зохион байгуулснаар багш бид бүхний ирээдүй, ҮБХИС-ийн оршин тогтнох үндэс баталгаажуулах зогсохгүй улс орныхоо батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр болох юм.

Багш мэргэжлийн мэдлэг, ур чадварыг баяжуулах, насан туршийн суралцах үйл нь дараах 2 төрлийн арга байж болох юм.

1. Их сургуулиас багшийг хөгжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

- Сургуулийн нийт багш нарын сургалт;

- Бусад сургуульд айлчлах, туршлага судлах;
- Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт;
- Шинэ багшийн туршилтын сургалт;
- Мэргэжлийн ном зохиол, бүтээл судлах;
- Хурал зөвлөгөөнд оролцох;
- Бусад сургуультай хамтран сургалт, туршилт зохион байгуулах;
- Багшийн өөрийгөө хөгжүүлэх орчныг өөрөө бий болгох;

Багшийн өөрийгөө хөгжүүлэх орчныг сургууль, тэнхимээс бүрдүүлэх;

(WIFI орчин бүхий кофе шоп, тохилог өрөөтэй болох)

- Багшийг хөгжүүлэх, чадваржуулахын тулд тогтвортой боловсон хүчний бодлогоор хангах;
- Багшийг сонгон шалгаруулахдаа мэргэжил, ур чадварыг шалгаад зогсохгүй тууштай ажиллах гэсэн чинь хүсэл эрмэлзэл байгаа эсэхийг нь харгалзан үзэх.

2. Багш өөрөө ажлын байран дээр бие даан хөгжих арга;

- Дагалдан сурах;
- Заадаг хичээлээрээ нэгдэх;
- Онлайн сургалтад хамрагдах;
- Солилцооны хөтөлбөрт хамрагдах;
- Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх;
- Идэвх санаачилгатай, бүтээлч, шинийг эрэлхийлэгч байх;
- Зорилготой, алсын хараатай, өөрийгөө бүрэн дайчилж чаддаг байх зэрэг болно.

Багш бид хөгжиж, бид хөгжсөнөөр суралцагчид маань хөгжин боловсролтой иргэн төлөвшүүлснээр, их сургууль хөгжин нийгэм хөгжих бүрэн боломж байна гэдгийг гүнээ ухамсарлан ажиллахыг нийт багш нартаа уриалж байна.

"Хүүхэд шуугисан их өргөө нь инээд баяслаар дүүрэн байж, хүсэл татсан хүнлэг сэтгэл маань хүмүүний хорвоог баясгаж байг" гэж ерөөе.



Ашигласан материал:

1. Л.Оюунчимэг, Мөнхцэцэг.Т, "Багшийн лавлах" УБ, 2000.
2. Ичинхорлоо. Ш, "Багшийн ном" УБ., 2011.
3. Б.Наранцэцэг. "Багшийн гарын авлага" УБ, 2006.
4. Ш.Паламдорж. "Судалгааны арга зүй" УБ. 2014 он
5. urchadvar.itpd.mn
6. itpd.mn
7. teacher.sur.mn
8. esurgalt.itpd.mn

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛИЙГ ЗОГСООХОД БИДНИЙ ОРОЛЦОО

Б.БААТАРСҮРЭН /ҮБХИС-ийн БХЭШХ-ийн ЭША, доктор (Ph.D)/

Түлхүүр үг: Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрх, эцэг эхийн оролцоо, урьдчилан сэргийлэлт, хүүхэд хамгаалал.

Key words: Domestic violence, violence against children, children's rights, parent participation, prevention, child protection

Хураангуй. Энэхүү судалгаагаар бие бялдар, сэтгэл санаа, оюуны хөгжил нь ид хурдацтай явагдаж буй насандаа гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болдог хүүхдүүдийг бид хэрхэн хамгаалж чадах вэ, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох боломж хүн бүхэнд бий юу гэсэн асуултуудын хүрээнд эцэг эх, насанд хүрэгчдийн хуулийн мэдлэг, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголтыг тандан судлах, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар оновчтой санал дэвшүүлэх зорилго дэвшүүлэн ажиллав. Судалгаанд нийт 230 оролцогчийн асуулгын дүн, 16 багш, нийгмийн ажилтан, хуулийн байгууллагын ажилтны ярилцлагын дүнг ашиглалаа.

Судалгааны үр дүнгээс үзэхэд эцэг эх, насанд хүрэгчдийн хуулийн мэдлэг хангалтгүй байна. Тэдний хуулийн мэдлэг нь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд туслах байдалтай хамаарах эсэхийг хи квадрат тест ашиглан шалгахад шинжүүрийн "0" таамаглал няцаагдаж (Φ Value=000<0.01) байна. Энэ нь хуулийн мэдлэг нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх байдалтай хамааралтай буюу коэффициент 0,7 байгаа нь эдгээр хувьсагчдын хооронд хамаарлын хүчтэй зэрэг байгааг илэрхийлж байна. Хувь хүний хуулийн мэдлэг нь хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, туслан зөвлөхөд нөлөөтэй байж болох юм гэсэн таамаглал дэвшүүлэн нэг хүчин зүйлийн вариацийн шинжилгээ хийж үзэхэд (Φ Value=0.7. Sig.000) хүчтэй хамааралтай байгаа нь статистик шинжилгээний үр дүнгээр илэрсэн.

Судалгааны зорилго. Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс

өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатайг хүүхдийн эрхийн түгээмэл тунхаглалд заасныг үзэл баримтлал болгон эцэг эх, насанд хүрэгчдийн хуулийн мэдлэг, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголтыг тандан судлах, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар оновчтой санал дэвшүүлэх.

Судалгааны арга зүй. Хүүхдийн Эрхийн Конвенци (ХЭК)-д тодорхойлсны дагуу хүүхэд нь хүчирхийллээс ангид гэр бүлд өсөн бойжих, хоол тэжээлээр хангагдах, боловсрол эзэмших, амьдрах, хамгаалуулах, мэдээлэл авах, нийгмийн амьдралд оролцох эрх зэрэг сайн сайхан аж байдлаа хангуулах хамгийн наад захын үндсэн эрхтэй гэдэг зарчим, Дэлхийн Тогтвортой Хөгжлийн Зорилго (Sustainable Development Goals-2030), ДЭМБ-аас гаргасан ёс зүй, аюулгүй ажиллагааны зөвлөмжүүд (WHO, Putting women first: Ethical and safety recommendations, 2001), АНУ-ын судлаачдын гаргасан "Хүүхдийг хүчирхийлэх, үл тоомсорлохоос урьдчилан сэргийлэх стратеги" (Prevention Strategies for Child Abuse and Neglect) зэргийг судалгааны арга зүй болгон ашигласан. Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Зорилго (УИХ-ын 19-р тогтоол)-ын шалгуур үзүүлэлтийн хүний хөгжлийн мөн орлогын тэгш бус байдлын шалгуур үзүүлэлтүүдийг аргачлал болгон асуулгын аргаар судалгаа авсан. Асуулга судалгааны мэдээллийг боловсруулахдаа SPSS 25.0 программ ашиглан дан болон харьцуулсан тоололт, Хи квадрат (Chi-square), Анова (One-way ANOVA)-ын шинжилгээ хийсэн. Мөн чанарын судалгаагаар 16 багш, нийгмийн ажилтан, хуулийн байгууллагын

ажилтантай ярилцлага зохион байгуулж, асуулга судалгааны үр дүнг бататган дүгнэлээ.

Удиртгал. Хүчирхийлэл нь зовоох эсвэл хянах зорилготой үл тоомсорлох, зальхай аргаар удирдах, хэл амаар шүүмжлэх, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл зэрэг төрөл бүрийн зан үйлээс бүрддэг. Харамсалтай нь хүчирхийлэл үйлдэх нь хэвийн үзэгдэл болсон бөгөөд зарим эрдэмтэн дэлхий дээрх хүүхдүүдийн дөрөвний нэг нь бие махбодын болон бэлгийн мөн сэтгэл санааны хувьд зүй бус харьцах хүчирхийлэлд өртдөг хэмээн тооцоолжээ. Түүнчлэн насанд хүрэгчдийн дунд хохирогчдын хувь хэмжээ өндөр байгаа ба ойролцоогоор 4 эмэгтэй тутмын 1 нь, 10 эрэгтэй тутмын 1 нь эхнэр, нөхрийнхөө бие махбодын хүчирхийлэлд өртдөг байна. (Maryam Ajilian Abbasi, Masumeh Saeidi, Gholamreza Khademi, Bibi Leila Hoseini, Zahra Emami Moghadam, 2014)

Хүчирхийлэл ямар ч харилцаан дээр гарч болох бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь хүчирхийлэгч байж болно. Гэхдээ эрчүүд эрхшээлдээ байлгах, бие махбодын болон бэлгийн ноцтой хүчирхийлэл учруулах магадлал өндөр байхад, эмэгтэйчүүд нөхрөө айлган сүрдүүлж, дарангуйлж эсвэл маш олиггүй муухайгаар доромжлон гутаах магадлал өндөр байдаг байна.

Монгол Улс ардчилал, хуулийн засаглал, хүний эрх, эрх чөлөө, үнэт зүйлсийг дээдэлсэн нийгмийг бүтээснээр олон чухал шинэчлэлийг хийсэн билээ. Тиймээс ч Үндсэн хуулиндаа "Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн" (Монгол Улсын Үндсэн хууль, 1992) хэмээн тунхаглажээ.

Мөн Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендерийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн

боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ. (Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баоимтлал-2030., 2016) гэсэн байна.

Аливаа улс орны төр засаг нь нэн тэргүүнд эмзэг бүлэг, хүчирхийлэлд өртөгчдийн эрхийг хамгаалах үүрэгтэй. Тэгвэл гэр бүлийн, ялангуяа хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийлэл нь хүний амьд явах эрх, бие махбодын халдашгүй дархан байдал, хамгаалуулах, эрүүл байх, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байгаа үйлдэл юм. Хүчирхийллийг ямар ч нөхцөлд соёл, ёс заншил, шашин шүтлэгээр зөвтгөж, хамгаалж, хүлээн зөвшөөрөх ёсгүй. Үе дамжсан хүчирхийллийг таслан зогсоохын тулд хүүхдийг ялангуяа хүчирхийлэлд өртөж байж болзошгүй хүүхдүүдийг хамгаалах шаардлагатай. Олон улсын судалгааны дүнгээс үзэхэд хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийг татан оруулах нь чухал, Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид, багш нар, хууль сахиулах ажилтнууд, шашны зүтгэлтнүүд зэрэг үйлчилгээ үзүүлэгчдийн хүчирхийлэлд өртсөн тохиолдлыг илрүүлэх, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх чадавхыг дээшлүүлэх нь жендерийн тэгш байдлыг хангах зорилтыг биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэхийг онцолсон байна. (Hamby, 2018)

Монгол Улсын хувьд хүчирхийлэлтэй тэмцэхэд хууль эрх зүйн зохицуулалтыг маш сайн гэж үнэлж болохоор байна. Тухайлбал, "Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй гэж үзвэл төрийн, төрийн бус байгууллагын ажилтан, хуулийн этгээд, бусад этгээд цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, багийн Засаг даргад болон хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх утасны үйлчилгээнд мэдээлэх үүрэгтэй" (Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011) "Хүүхэд гэмт хэрэг,



зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй" (Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016). "Эх, эцэг хүүхдэдээ нийгмийн үүрэг, хариуцлага, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хамтын эрх тэгш оролцоо болон жендерийн эрх тэгш байдлын тухай ойлголт, хүнийг хүйсийн шинжээр үл ялгаварлах үзэл, зан үйлийг өөрсдийн үлгэр дуурайл, гэр бүлийн хүмүүжлээр олгох үүрэгтэй" (Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011) зэрэг заалтуудыг дурдаж болно.

Харин эцэг эх, насанд хүрэгчид энэхүү үүрэг хариуцлагаа хэрхэн ухамсарлаж байна, тэдний хуулийн мэдлэг ямар түвшинд байна вэ? гэдэг асуултад хариу олохыг энэ судалгааны үр дүнгээр харахыг зорилоо. Яагаад хүчирхийллийн тоо баримт өссөөр, арга нь улам нарийссаар, зүрх шимшрэм үйлдлүүд, гэмт хэргүүд гарсаар байгааг бид зогсоож, урьдчилан сэргийлж чадахгүй байна, үүнд хүн бүрийн оролцоо, хүчин чармайлт дутагдаж байна.

Учир нь хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, мэдээлэх үйл явцад олон нийтийн оролцоо хангалтгүй байгаагаас хүүхэд амь насаа алдах, биедээ хүнд, хүндэвтэр бэртэл гэмтэл авах тохиолдол нэлээдгүй байна. Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах хэлбэрүүд хэвийн үзэгдэл мэт оршиж, хүүхэд хамгааллын ээлтэй орчин бүрэлдэн, төлөвшиж чадаагүй байгаагаас хүүхэд гэрээсээ дайжих, хараа хяналтгүй болох, сургууль завсардах, хөдөлмөр эрхлэх, гэмт хэрэгт холбогдох, мансууруулах бодист донтох, амиа хорлох, хүн худалдах гэмт хэргийн золиос болох зэрэг сөрөг үр дагавар илэрч байна. (ҮСГ, 2020)

Судалгааны хэсэг. Монгол Улс 1990 онд элсэн орсон Хүүхдийн эрхийн тухай конвенцод "Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох,

сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна" (The United Nations Convention on the Rights of the Child, 1989) хэмээн заасан байна. Энэхүү конвенцид элсэн орсноор хүүхдүүдийг сонсох, тэдний хамгийн дээд эрх ашгийг эрхэмлэх, аливаа шалтгаанаар хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байхыг амлаж, хүүхэд бүр амьд явах, хөгжих эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрчээ. Үүний зэрэгцээ, хүүхдүүдийг хүчирхийллээс хамгаалах, хүүхдийн хөдөлмөрийг таслан зогсоохыг амлаж, хүүхэд бүр эрүүл байх, боловсрол эзэмших ёстой гэдгийг ч мөн хүлээн зөвшөөрсөн.

"Хүүхдийн эсрэг хүчирхийлэл" гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг" (Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016) хэлнэ. "Энэ хуулийн үйлчлэлд хамаарах этгээд хүүхэдтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, ялгаварлан гадуурхах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, заналхийлэх, хүч хэрэглэх, зодож шийтгэх, тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, үл хайхрах, хүүхдийн дэргэд архи дан согтуурах, мансуурах, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно" (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2017) гэж хуульд заасан байна.

Дэлхий дахинд COVID-19-ийн халдвараас үүдэн хөл хорио тогтоод байгаа энэ цаг үед иргэдийн сэтгэл зүйн энэ хямралын дунд хүүхэд багачууд хохирсоор байгаа нь хамгийн том аюул юм. Хөл хорионы үед хүүхдээ үл хайхарч байгаа нь маш том хүчирхийлэл гэж мэргэжилтнүүд дүгнэжээ. "Хүүхдүүд сэтгэл санааны хувьд хэн ч намайг тоодоггүй, хайхардаггүй гэдгээс болоод сэтгэл гутралд автаад амиа хорлох талаар бодож эхэлдэг. Хүүхдээ үл хайхрах нь тухайн хүүхдийг сэтгэл гутралд орох номер нэг хүчин зүйл байдаг" гэдгийг анхааруулж



байна.

Монгол Улсад COVID-19-ийн халдварыг тогтоон барих зорилготой хатуу арга хэмжээний дүнд жендерт суурилсан хүчирхийлэл огцом нэмэгдэж байна. 2020 оны эхний улирал буюу Монгол Улс анхны халдвар хамгааллын арга хэмжээнүүдийг авч эхэлсэн үед Нэг цэгийн үйлчилгээний төвүүд (НЦҮТ)-ээр үйлчилүүлэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс даруй 87 хувь өссөн. Түүнчлэн 11 дүгээр сарын 11-ний өдөр дотоодын халдвар гарсантай холбоотой хатуу хөл хорионы дэглэм эхэлсэн өдрөөс хойш 10 өдрийн дотор Монголд үйл ажиллагаа явуулж буй НЦҮТ, түр хамгаалах байрууд болон яаралтай тусламжийн утаснаас нийт 1,500 гаруй эмэгтэйчүүд, хүүхдүүд тусламж хүссэн байна.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх "... Хөл хорионы үе жендерт суурилсан хүчирхийлэл нэмэгдсэн талаарх тоо мэдээлэл байна. Нэг ч хүүхэд, эмэгтэй, эрэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хэн нэгэн хайрлаж хамгаалах үүрэг бүхий хүмүүсийнхээ гарт амь насаа алдах учиргүй, ийм эмгэнэлт явдал давтагдах ёсгүй, үүнийг бид таслан зогсоох ёстой" хэмээн онцлов. (Хүрэлсүх, 2020)

Энэ оны эхний хагаст цар тахлын үед жендерт суурилсан хүчирхийлэл нэмэгдэхэд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Үүнд, эдийн засгийн болон сэтгэл зүйн дарамт, стресс, гэр бүлийн гишүүд нэг дор өнгөрүүлэх хугацаа огцом нэмэгдсэн байдал, гэр бүлийн гишүүдийн амьд харилцаа алдагдсан, харилцааны ур чадвар дутагдсан, хохирогчдод шаардлагатай тусламж, дэмжлэг дутмаг байдал болон хөл хорионы үед хүчирхийллээс дүрвэж зугтах боломж хомс зэрэг шалтгаанууд орж байна. (сан, 2020)

Гэр бүлийн хүчирхийлэл нь хүүхдүүд болон гэр бүлийн бусад гишүүдэд нөлөөлдөг. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэгт 273 иргэн, үүнээс 238 (87.2%) эмэгтэйчүүд, 30 (11.0%) хүүхэд өртөж, хохирсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 43 (18.7%)-аар, үүнээс хүүхэд 16 (2.1

дахин)-аар, эмэгтэй хүн 25 (11.7%)-аар тус тус өсжээ. (ҮСГ, 2020) Учир нь гэр бүлийн хүчирхийлэл нь далд явагдахын зэрэгцээ, давтагддаг, давтагдах бүрдээ шинж чанарын хувьд улам ноцтой болдог өвөрмөц шинж бүхий үйл явц юм.

Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил, нийгмийн эрүүл мэндийн асуудал байхын зэрэгцээ хувь хүн, олон нийт төдийгүй цаашлаад өргөн хүрээнд нийгмийн амьдралд, улс орны эдийн засагт томоохон нөлөө үзүүлдэг байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүс хувиасаа ихээхэн хэмжээний зардлуудыг гаргадаг ба асаргаа халамжийн ажил болон алдагдсан орлого гэх мэт хохирлууд учирдаг бөгөөд хөдөлмөрийн бүтээмжийн алдагдал нь зөвхөн эмэгтэйчүүд болон тэдний гэр бүлд нөлөөлөөд зогсохгүй улс орны эдийн засгийн өсөлтөд мөн саад учруулдаг байна. Ялангуяа ядуурлын асуудлыг шийдвэрлэх, тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, охидод нэн шаардлагатай үйлчилгээг хэрэгжүүлэхийг зорьж буй улс орны хувьд энэ нь ноцтой асуудал болж байна. (НҮБ-ын Эмэгтэйчүүд) Эдгээр тоо баримтууд зөвхөн мэдэгдэж байгаа тохиолдлууд дээр үндэслэгдэн гарч байгаа бол мэдээгүй хэчнээн тохиолдлууд байгааг бид мэдэхгүй, хаалттай хаалганы цаана хүчирхийлэл явагдсаар байна. Бие махбодын хүчирхийлэл зэрэг зарим төрлийн хүчирхийллийг танихад амар байдаг ч сэтгэл санааны хүчирхийллийг таних нь хамаагүй хэцүү. Хор уршиг нь төөрөгдөл, айдас, ичгүүр, мухардал, өөрийгөө дутуу үнэлэх зэрэгт хүргэж болно. Ялангуяа хүүхдэд айдастай байх, ганцаардах, аюулгүй байдалдаа сэтгэл зовниж эхлэх, урт хугацааны сэтгэцийн гэмтэл үүсэх, бие махбод болон оюун ухааны хөгжилд сөргөөр нөлөөлөх, сэтгэл зүй, оюун ухааны хөгжил удаашрах, зогсох, сэтгэцийн гэмтэл авах, эрүүл бие хүн болж төлөвшихөд сөргөөр нөлөөлөх, гэрээсээ дайжих, тамхи татах, архи уух, эрт бэлгийн харилцаанд орох зэрэг сөрөг зан үйлтэй болоход нөлөөлдөг байна. (Child Abuse Education & Prevention Resources (childhelp.org))



Монгол Улсад гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байгаа хүүхдүүдийн 22 хувь нь гэр бүлийн хүчирхийллээс, 42 хувь нь үе тэнгийнхний дарамтаас, 10 хувь нь сургууль дээрх таагүй харилцаанаас үүдэн гэмт хэрэг үйлдсэн гэж үзсэн байна. (ҮСГ, 2020)

Монгол Улсын хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх салбарт гарсан нэг ололт бол нийгмийн ажилтан бусад салбарын мэргэжилтнүүдтэй хамтран багаар ажиллах санаачилга гарч, энэ санаачилгыг хууль эрх зүй болон нийгмийн үйлчилгээний хүрээнд хүлээн зөвшөөрсөн явдал юм. Хамтарсан багаар ажиллах нь хүүхэдтэй зүй бус харьцах явдалтай тэмцэхэд салбар дундын мэргэжилтнүүдийг оролцуулан, хүүхэд хамгааллын асуудлыг илүү өргөн хүрээтэй хэлэлцэж, нөхцөл байдлын үнэлгээг нарийвчлан хийх, нийгмийн үйлчилгээг чанартай хүргэх, байгууллагуудын болон мэргэжилтнүүдийн уялдаа холбоог хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна. Гэсэн хэдий ч шинэ тулгар хөгжиж буй "хамтарсан багийн үйл ажиллагаа нь өнөөгийн байдлаар орон нутгийн түвшинд нутгийн өөрийн удирдлагын болон захиргааны шийдвэрээр байгуулагдаж, эргээд тэдгээр байгууллагын өмнө ажлаа тайлагнах жишгээр явж байна. (Түмэннаст.Г, Бүрэнжаргал.Т, Болдмаа.Н, 2015)

Судалгаануудын үр дүнгээс үзэхэд манай улсын хувьд хүүхдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан, хүчин зүйлүүдийг доорх байдлаар тайлбарласан байна. Үүнд:


1. Хүний эрх, хүүхдийн эрхийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг хангалтгүй байна. Нийгмийн сэтгэл зүйд хүүхдээ зодох, загнах, дорд үзэх явдлыг хүмүүжлийн арга хэмээн үзэх хандлага түгээмэл байна. Эцэг эхчүүд хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргуудыг мэдэхгүй, мэдсэн ч хэрэглэдэггүй, хүүхэдтэйгээ харилцах ур чадвар дутмаг байна.
2. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт нь нийгэм дэх хүмүүсийн хоорондын тэгш бус байдал

болон хүүхэд, насанд хүрэгчдийн хоорондын эрх мэдлийн тэнцвэртэй бус байдалтай холбоотой гэж мэргэжилтнүүд үздэг. Ихэнх тохиолдолд хүүхэд хүчирхийлэл үйлдэгчээс хараат буюу эсхүл түүнтэй харьцуулахад бага эрх мэдэлтэй байдаг байна.

3. Ядуурал, ажилгүйдэл, нийгмээс тусгаарлагдмал байдал, дасал болоогүй нөхцөлд амьдрах, шилжилт хөдөлгөөн зэрэг нийгмийн олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Жишээлбэл: Халамжийн төвд өсөж буй хүүхдүүд хүчирхийлэлд өртдөг тухай мэдээлэл их байдаг. Эдгээр хүүхдүүд гол төлөв нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүд байдаг бөгөөд тэдний дотор нэн ядуу айлын, хөгжлийн бэрхшээлтэй, сургууль завсардсан гэх мэт хүүхдүүд байна.
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээний хоорондын уялдаа холбоо сул, тогтвортой байдал хангалттай биш байгаа нь эрсдэлд байгаа хүүхдэд хангалттай үйлчилгээ үзүүлж чадахгүй байна. (ҮСГ, 2020)

Иймээс хүн бүр Үндсэн хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу үр хүүхдээ эрүүл аюулгүй орчинд өсгөн хүмүүжүүлэхийн тулд хүчирхийлэлгүй нийгмийг цогцлооход гар бие оролцох ёстой. Учир нь бидний хүүхэд бүгд хамтдаа нийгмийн амьдралд зэрэгцэн оролцох болно. Энэхүү судалгааны хүрээнд зорилго болгосны дагуу эцэг эх, насанд хүрэгчдийн хуулийн мэдлэг, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголтыг тандан судлах, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар оновчтой санал дэвшүүлэхээр доорх судалгааг хийв. Судалгаанд нийт 230 оролцогч, чанарын судалгаанд 16 багш, нийгмийн ажилтан, хуулийн байгууллагын ажилтан оролцов.

Насны байдлыг харахад залуу, идэр насны бүлгийн оролцогчид илүү хувьтай байна. Харин хүйсийн байдлаас харахад эрэгтэйчүүдийн оролцоо эмэгтэйчүүдийн оролцооноос даруй 2 дахин бага түвшинд байна.



Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн байдал (хувиар)

Ажил мэргэжлийн хувьд боловсролын байгууллагын албан хаагчид (26%) илүү давуу оролцсон сайн тал ажиглагдлаа.

Эцэг эх, насанд хүрэгчдийн хуулийн мэдлэг, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголтыг тандан судлах асуултуудын нийцтэй байдал, найдвартай зэргийн Кронбахийн альфа коэффициент 0.896 гарч байгаа нь 0.7-оос дээш байвал асуулт нь үнэлэх боломжтойг илэрхийлдэг учир тус судалгааны асуулт найдвартай хэмээн үзэж байна.

Reliability Statisti	
Cronbach's Alpha	N of Items
0.896	15

1 дүгээр хүснэгт. Тестийн найдвартай зэргийн шинжилгээний үр дүн (Reliability Statistics)



2 дугаар зураг.

Хүчирхийлэлд нөлөөлж буй зүйлс

Таны бодлоор хүүхдийн хүчирхийлэлд доорх зүйлс хэр нөлөөлнө гэж үзэж байна вэ? /1-5-аар үнэлнэ/ гэсэн асуултад бүх хүчин зүйлсийн хувьд нөлөөлнө гэсэн сонголт давуу хувьтай, үүнээс шилжилт хөдөлгөөн 47 хувь байгаа бол гэр бүл салалт 46 хувь, архидалт 64 хувь, хүчирхийлэгчид оногдуулж буй хариуцлага сул 39 хувь маш их нөлөөлнө гэж үзсэн байна.



1 дүгээр зураг. Хуулийн мэдлэг

Таны доорх хуулиудын талаарх өөрийн мэдлэгээ үнэлнэ үү? /1-5-аар үнэлнэ/ гэсэн асуултад бүх төрлийн хуулийн мэдлэгийн талаар муу гэсэн үнэлгээг давуу сонгосон бол Үндсэн хууль, Гэр бүлийн тухай, Жендерийн тухай хуулийн мэдлэг дунд гэсэн үнэлгээг илүүтэй сонгосон байна. Харамсалтай нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн мэдлэгээ муу гэж үнэлсэн нь хамгийн өндөр буюу 39.2 хувийг эзэлж байна.



3 дугаар зураг.

Хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй уулзсан бол

Та хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй уулзсан бол ямар арга хэмжээ авч байсан бэ? гэсэн асуултад уулзаж байгаагүй гэж 50.9 хувь нь хариулжээ. Хүчирхийллийн талаарх тоо баримт байнга өссөөр байхад уулзаж байгаагүй гэсэн хариулт өндөр хувьтай байгаа нь аминч үзэлтэй холбоотой байж болох талтай. Харин 18.1



хувь нь хуулийн байгууллагад мэдээлсэн, 17.2 хувь нь ярилцсан, 6.9 хувь нь сэтгэл зүйчтэй холбосон гэж хариулсан байгаа нь тодорхой хэмжээгээр анхаарал хандуулж байгаа эерэг хандлага харагдаж байна.



4 дүгээр зураг.

Хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй уулзвал

Та хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй уулзвал ямар арга хэмжээ авах вэ? гэсэн асуултад хариулсан байдлаас харахад 45.3 хувь нь хуулийн байгууллагад мэдээлнэ, 24.2 хувь нь ярилцана гэсэн сайн үр дүн харагдаж байна.

2 дугаар хүснэгт. Group Statistic

Knowledge of the Law & Assistance		Value	Approximate Significance
Scale by Scale	Phi	.677	.000
	Cramer's V	.458	.000
N of Valid Cases		2230	

Судалгаанд оролцогчдын хуулийн талаарх мэдлэг нь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд туслах байдалтай хамаарах эсхийг хи квадрат тест ашиглан шалгахад шинжүүрийн "0" таамаглал няцаагдаж (Phi Value=.000<0.01) байна. (SPSS программын Chi-Square Tests, Phi and Cramer's V-ээр, шалгасан) Өөрөөр хэлбэл хуулийн мэдлэг нь тэдний хүүхдэд үзүүлэх тусламжтай хамааралтай. Тодруулбал коэффициент 0,7 байгаа нь эдгээр хувьсагчдын хоорондын хамаарлын хүчтэй зэрэг байгааг илэрхийлнэ. Тэгвэл хуулийн мэдлэг дээшилснээр хүчирхийллээс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэнэ гэж дүгнэж болохоор байна.

Тэгвэл хуулийн тухай мэдлэг дээшилснээр хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, зөвлөн туслахад нөлөөтэй байж болох юм гэсэн таамаглал дэвшүүлэн нэг

хүчин зүйлийн вариацийн шинжилгээний (One-Way ANOVA)-аар судалж үзлээ.

3 дугаар хүснэгт.

Хуулийн мэдлэг ба хүүхдэд туслах байдлын нөлөөллийн One-way ANOVA үр дүн (Knowledge of the Law & Assistance)

	Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Between Groups	64.262	4	16.065	23.745	0.000***
Within Groups	131.933	2225	.628		
Total	196.195	2229			

- *** 0.01 ач холбогдлын түвшинд тэг таамаглал няцаагдсан
- ** 0.05 ач холбогдлын түвшинд тэг таамаглал няцаагдсан
- * 0.1 ач холбогдлын түвшинд тэг таамаглал няцаагдсан

Дээрх хүснэгтийн үр дүнгээс дэд бүлгүүдийн хувьд факторын оноо ижил гэсэн тэг таамаглал 0.01 ач холбогдлын түвшинд няцаагдсан байна. Өөрөөр хэлбэл, хувь хүний хуулийн мэдлэг нь хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, туслан зөвлөхөд нөлөөлж байна гэж дүгнэхээр байна.

Дүгнэлт.

Мэргэжлийн байгууллагуудын хийсэн судалгаануудын үр дүнгээс үзэхэд эцэг эхчүүд хүүхдэдээ хэлж зөвлөхөөс илүү загнах, зодох аргыг хэрэглэдэг учраас хүүхдийн хүчирхийллийн төрөл бүрийн хэлбэрийг үл тоож байна. Иймд тэдэнд зориулсан хууль, сэтгэл зүй, хүүхдийн хүмүүжлийн эерэг арга барил болон сайн туршлагын талаарх сургалтуудыг зохион байгуулж байх шаардлага, хэрэгцээ байна.

Мөн гадаад, дотоод шилжих хөдөлгөөнд орсон иргэд үр хүүхдээ хамаатан садан, ах дүүдээ найдаж үлдээх, малчны хүүхэд сургуульд суралцахаар сумын төвд айлд байх, эсвэл ээж, аавын нэг нь хамт сумын төвд байж ар гэрийн тэнцвэр алдагддаг байна. Эдгээр хүүхдүүдийг өндөр хөгжилтэй зарим орнуудын туршлагаар асран хүмүүжүүлэгч эцэг эх (foster parents)-тэй болгох хууль, эрхзүйн зохицуулалт хийж болох юм.

Судалгааны үр дүнгээс үзэхэд эцэг эх, насанд хүрэгчдийн хуулийн мэдлэг хангалтгүй байна. Тэдний хуулийн мэдлэг нь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд туслах

байдалтай хамаарах эсэхийг хи квадрат тест ашиглан шалгахад шинжүүрийн "0" таамаглал няцаагдаж (Phi Value=0.000<0.01) байна. Энэ нь хуулийн мэдлэг нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх байдалтай хамааралтай буюу коэффициент 0,7 байгаа нь эдгээр хувьсагчдын хоорондын хамаарлын хүчтэй зэрэг байгааг илэрхийлж байна.

Хувь хүний хуулийн мэдлэг нь хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, туслан зөвлөхөд нөлөөтэй байж болох юм гэсэн таамаглал дэвшүүлэн нэг хүчин зүйлийн вариацийн шинжилгээ хийж үзэхэд (Phi Value=0.7. Sig.000) хүчтэй нөлөөтэй байгаа нь статистик шинжилгээний үр дүнгээр илэрсэн.

Сургууль бол хүүхдийн 2 дахь гэр, тэдний найз нөхөдтэйгөө аз жаргалтай байх гэгээн орчин билээ. Тиймээс хүүхдийн ар гэрийн байдлыг багш, нийгмийн ажилтан, эмч нар анхаарч байх нь тэднийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалж дуугарахад том хувь нэмэр болно. Иймд сургуулийн удирдах ажилтан, багш болон бусад ажилтнуудын хүүхдийн эрхийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх сургалтууд зохион байгуулах, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх удирдамжаар хангах шаардлага байна.

Сургуулийн орчинд хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлж мөрдөх, үе тэнгийнхний буруу харилцаа, дээрэлхэх байдал, дарамтаас урьдчилан сэргийлэх бодлого, журамтай болгох чиглэлээр

Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах. Жишээ нь: Танхайрах, дээрэлхэх биш найз байх (Don't bully Be a friend) хөдөлгөөн өрнүүлэх гэх мэт.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан өрх гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, харилцааг дэмжих, стресс бууруулах арга замуудыг сурталчлах, эерэг хандлага нэмэгдүүлэх ажлыг сайжруулах боломжтой.

Гэр бүлийн хүрээнд эцэг эхчүүд хүүхдээ сонсож, тэдний сайн найз байхын зэрэгцээ хүүхдийнхээ зан байдал, хандлагад гарсан өөрчлөлтийг мэдэж, түүнийг нь лавлаж, харилцан ярилцаж асуудлыг хамт шийдэж байх нь хамгийн чухал юм. Эцэг эхчүүд, багш нарын зүгээс хүүхдүүдэд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх стратегийг заах нь хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангахад тусалдаг байна. Мөн хүүхдийнхээ телевиз, видео, интернэтийн хэрэглээ, ашиглалтыг хянах, учир нь хүчирхийлэлтэй кино, телевизийн нэвтрүүлэг, видео бичлэгийг хэт их үзэх нь бага насны хүүхдүүдэд хор хөнөөл учруулдаг.

Эцэст нь дүгнэхэд хүчирхийллийн эсрэг бие биеэ дэмжин тусалж, хүн бүр хариуцлагатай, оролцоотой байснаар хүчирхийлэл үйлдэгдэхээс, давтагдахаас урьдчилан сэргийлж чадна. Илтгэлийн төгсгөлд "Бусдын төлөө гэсэн таны багахан тус тэдний ирээдүйн амьдралд төсөөлшгүй өөрчлөлт авчирч чадна" гэсэн хохирогч эмэгтэйн үгтэй санал нийлж байна.

**Ашигласан материал:**

1. (n.d.). Retrieved from Child Abuse Education & Prevention Resources (childhelp.org) .
2. Child Abuse Education & Prevention Resources (childhelp.org) . (n.d.).
3. Hamby, S. (2018). Current controversies: Are women really as violent as men? The "gender symmetry" controversy. Sourcebook on Violence Against Women.
4. Maryam Ajilian Abbasi, Masumeh Saeidi, Gholamreza Khademi, Bibi Leila Hoseini, Zahra Emami Moghadam. (2014). Maryam Ajilian Abbasi, Masumeh Saeidi, Gholamreza Khademi, Bibi Leila Hoseini, ZahraChild Maltreatment in the World. International Journal of Pediatrics, vol. 3, no.1.
5. (1989). The United Nations Convention on the Rights of the Child.
6. Wikipedia. (n.d.). www.wikipedia.com.
7. Аюулгүй байдлын онолын үндэс хичээлийн лекц. (n.d.). Он Лекц.
8. Б.Нэргүй. (2016 оны №02 (218)). Иргэний нийгэм Үндэсний аюулгүй байдлыг хангах субъект мөн: ОХУ, АНУ-ын туршлага.
9. Г.Жаргал, Н.Сэлэнгэ. (2020). Судалгааны арга зүйд суралцах нь. Шинэчилсэн 2-р хэвлэл.
10. (2017). Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль.
11. (2017). Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль.
12. Д.Адьяабазар. (2011, №53). "Монгол Улсын дотоод аюулгүй байдлын эрсдэл бүхий зарим асуудал" .
13. (2011). Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль.
14. (2011). Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль.
15. М.Тулгат. (2005). Бусгаар тогтносон Монгол. Эдмон .
16. (2016). Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн үзэл баримтлал-2030.
17. (2021). Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан.
18. (1992). МУ-ын Үндсэн хууль.
19. НҮБ-ын Эмэгтэйчүүд, Н.-ы. Х. (n.d.). 2015.
20. сан, Н.-ы. Х. (2020). ЖСХ, ГБХ-ийн нөхцөл байдал болон хохирогчдод зориулсан үйлчилгээнд COVID-19-ийн үзүүлж буй нөлөөний түргэвчилсэн үнэлгээ.
21. Түмэннаст.Г, Бүрэнжаргал.Т, Болдмаа.Н. (2015). Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал судалгаа. УБ: ХИС.
22. ҮАБҮБ. (2010, 07 10). <http://www.nsc.gov.mn>. Retrieved from <http://www.nsc.gov.mn/?q=ns-concept>.
23. ҮСГ, Ц. (2020). Статистикийн тойм: Гэр бүлийн хүчирхийлэл.
24. Хүрэлсүх, У. (2020). "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ыг нээж хэлсэн үг. (ЖҮХ, Interviewer)
25. (2016). Хүүхдийн эрхийн тухай хууль.
26. (2016). Хүүхэд хамгааллын тухай хууль.
27. Ч.Тамир. (n.d.). Иргэний нийгэм ба төр .
28. Prevention Strategies|Child Abuse and Neglect|Violence Prevention|Injury Center|CDC
29. Ten Ways to Help Prevent Child Abuse | Prevent Child Abuse America



ШИНЭ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕИЙН ЦАХИМ СУРГАЛТ БА CDIO ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ

Д.АНХБАЯР /ҮБХИС-ийн АБДС-ийн ММТТ-ийн ахлах багш, магистр/
О.ЦОГЗОЛБОО /ҮБХИС-ийн АБДС-ийн ММТТ-ийн багш, докторант/

Түлхүүр үг: Цахим сургалт, дижитал оюутан - Z үеийнхэн, чанартай контент, багш, хандлага, CDIO, үр дүнд суурилсан сургалт, үнэлгээ, бүтээлч сэтгэлгээ.

Key words: E-learning, digital student, Z generation, quality content, teacher, attitude, CDIO, results-based training, evaluation, Creative thinking

Хураангуй. Өнөөдөр дэлхий нийтээр цар тахлаас шалтгаалан хүн төрөлхтний ажиллах, амьдрах, суралцах хэв маягийг маш хурдтай өөрчилж, үүнийг дагасан хувьсал, өөрчлөлт, технологийн дэвшил хүмүүсийн амьдралд нэвтэрч байна. Манай орны хувьд ч бусад улсуудын нэгэн адил бүх шатны сургалтыг цахим сургалтын хэлбэрт шилжүүлээд нэлээдгүй хугацааг өнгөрүүлээд байна. Шинэ тулгараад буй нөхцөл байдалд цахим сургалтыг яаж хэрхэн үр дүнтэй явуулах вэ гэдэг асуудал бидний өмнө тулгарсан. Ингээд бид сургалтын арга барилыг хэрхэн өөрчлөх, мөн бид хэнд, чухам ямар суралцахуйн онцлогтой хүүхдүүдэд хичээл зааж байгаагаа судлах, тэгснээр тэдэнд тохирсон сургалтын арга зүйгээр хичээлийг явуулах нь чухал гэдгийг олж тогтоох зорилготой туршилт сургалтыг явуулсан юм. Уг хичээлийг явуулж судалгааг авахдаа тонгоруу сургалтын аргыг сонгон ашиглаж асуумж, санал асуулгын хэлбэрээр судалгааг авч нэгтгэн дүгнэсэн. Энэ нь богино хугацаа ч гэсэн уламжлалт сургалт, судалгааны хэлбэрүүдээ өөрчлөх, шинэ нөхцөл байдалд сургалтыг хэрхэн үр дүнтэй явуулах, ололт амжилтыг дүгнэж цэгнэхэд бидэнд тодорхой хэмжээний туршлага хуримтлагдаж сургалтын үр дүнгүүд гарсан гэж үзэж байна.

Удиртгал.

Судалгааны ажлын үндэслэл: Дэлхий нийтээр цар тахалтай тэмцэж, бүхий л шатны боловсролын байгууллагууд цахим сургалтыг явуулж байгаа өнөө үед боловсролын чанар, хүртээмжийг бууруулахгүйгээр сургалтыг үр өгөөжтэй зохион байгуулах шаардлага бидний

өмнө тулж ирээд байна. Цахим сургалтыг үр дүнтэй явуулахын тулд бид бүгд орчин үеийн суралцагч, оюутнуудынхаа шинэ орчин, нөхцөл байдалд суралцах хэв маягийг нь тодорхойлох, түүнд нь зориулсан сургалтын дизайныг бий болгох, мөн тохирсон үнэлгээний стандартаар үнэлэх, чанартай контент бүтээх ажлуудыг үр дүнтэйгээр удирдан чиглүүлэх шаардлага байсаар байна.

Судалгааны ажлын зорилго: Бусад их дээд сургуулиуд болон Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуульд цахим сургалт явуулж буй туршлага, үр дүнд үндэслэн цаашид сайжруулах боломжийг судлахад оршино.

Судалгааны ажлын зорилт:

- ✓ Уламжлалт сургалт, судалгааны хэлбэрүүдээ өөрчлөх, шинэ нөхцөл байдалд сургалтыг хэрхэн үр дүнтэй явуулах, ололт амжилтыг дүгнэж цэгнэх
- ✓ Өмнөх туршлага, үр дүнд үндэслэн үнэлгээний аргуудыг турших илүү сайжруулах боломжуудыг судалж, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох

Үндсэн хэсэг. Цахим сургалтыг илүү хүртээмжтэй чанартай зохион байгуулахад бүхий л сургалтын байгууллагууд анхааран ажиллаж байна. Оюутны сурах үйл ажиллагааны явцад болон тухайн хичээлийг судалсны дараа эзэмшсэн цогц чадамжуудыг ямар үр дүнд хүрснийг тодорхойлохын тулд хийгдэж буй мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа бол үнэлгээ юм. Сургалтын үйл ажиллагааны үр дүнг ерөнхийд нь шууд ба шууд бус үнэлгээний аргаар үнэлдэг. Сургалтын байгууллага, их дээд сургуулиуд сургалтын явцад тухайн



хичээлийн агуулгад заасан үр дүн болон оюутнуудын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж дүгнэхэд ихэвчлэн шууд үнэлгээний арга, харин тухайн сургалтын чанар, үйл ажиллагаа, явцыг үнэлэхэд шууд бус аргыг өргөн хэрэглэж байна. Үүнд:

- Шууд үнэлгээний арга нь оюутнуудын хийсэн бүтээл, тэдгээрийн гүйцэтгэсэн ажлаас бүрдсэн нотлох баримтад үндэслэдэг ба оюутан юу сурснаа батлан харуулах шаардлагатай болдог тул энэ аргаар сургалтын явцын үйл ажиллагааг үнэлдэг.
- Харин шууд бус үнэлгээний арга нь сургалтын тухай эсвэл оюутнуудын мэдлэг, ур чадвар эзэмшсэн байдлыг илэрхийлэхүйц дагалдах нотолгоонд суурилдаг ба оюутан юу сурснаа нотлон харуулах шаардлагагүй харин сурсан мэдлэг, чадвар, хандлага нь ажил амьдралд нь хэрхэн тусаж байгааг дүгнэдэг онцлогтой.

Манай улсын 23 их, дээд сургуулиудын 65 эрдэмтэн багш нарын оролцсон хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн үзэхэд дараах 4 чиглэлд /Зураг 1/ анхаарч ажилласнаар цахим сургалтыг илүү үр дүнтэй зохион байгуулах боломж харагдаж байна.



1 дүгээр зураг. Цахим сургалтын дизайн

Өнөөгийн оюутнууд бага наснаасаа эхлэн өнгө, дүрслэлийн төгс зохицол, нээлттэй мэдээлэл, цахим орчинд өсөж торнин, аливаа зүйлийг хүлээн авах мэдрэхүй, төсөөлөл, бодол, сэтгэлгээ нь өргөн цар хүрээтэй болж байгаа нь тэдэнд зориулсан илүү сонирхолтой сурч, төлөвших шинэ хандлага, арга технологийг хөгжүүлэх шаардлагыг

бий болгож байна. Үүнтэй холбоотой дэлхийн олон улс орон, манай улс ч боловсролын салбартаа шинжлэх ухаан, технологийн хөгжлийн шинэ дэвшилтэт арга, хэлбэрүүдийг туршин нэвтрүүлэх, онлайн сургалтыг үр дүнтэй болгох чиглэлд анхааран, үр өгөөжтэй болох нь батлагдсан арга технологиудыг их, дээд сургуулиуд сургалтдаа нэвтрүүлэх тал дээр онцгой анхааран ажиллаж байна.

“Шинэ мянганыхан” буюу Z үеийнхний тухай. “Z” үеийнхэн бол 1995-2015 оны хооронд төрсөн хүүхэд, залуус юм. Одоо тэд 25-06 настай. Хүний нэг үеийг ойролцоогоор 15-20 орчим жилийн давтамжтайгаар нэрлэдэг уламжлал манай дэлхий ертөнцөд тогтоод бүтэн зууныг элээх гэж байна. Энэ нь шинжлэх ухаан, нийгэм, хүн судлалын түүхэнд нэгэнт тогтсон нэршил, хэвшил, ухагдахуун юм. “Z” үеийнхэн буюу “Linksters” (төрснөөсөө хойш технологитой салшгүй холбоотой байсан учраас энэ нэрийг авчээ) хэмээн нэрлэгдээд байгаа хүмүүс тун удахгүй нас биед хүрэх гэж байна.

“Z” үеийнхэн гэж яг хэнийг хэлж байна вэ? АНУ-ын хүн амын тооллогын агентлагийн мэдээлснээр “Z” үеийнхэн одоогийн байдлаар тус улсын хүн амын 26% эзэлж, эдийн засагт 44 тэрбум долларын хувь нэмэр оруулж байна. Тиймээс бид “Z” үеийнхэн амьдралаас яг юу хүсдэг мөн өмнөх үеийнхнээсээ юугаараа ялгаатай болохыг одоогоос эргэцүүлж эхлэх хэрэгтэй юм.

“Z” үеийнхний суралцах арга барил

- ✓ **Hands on learning:** Z үеийнхэн гараараа хийж үзэх боломжтой сургалтын үйл ажиллагаанд илүү дуртай бөгөөд сурсан зүйлээ тэр дор нь бодит амьдрал дээр туршихыг хүсдэг.
- ✓ **Z үеийнхэн бол ажиглагчид:** ямар нэг даалгавар биелүүлэхээс өмнө бусдын хийхийг хажуугаас нь харыхыг илүүд үздэг. Тиймээс Youtube video хандалт хамгийн өндөр.
- ✓ **Концепц:** Тэд дан ганц практик зүйл сурахаас гадна суралцаж буй

зүйлийн концепц зүй тогтлыг мөн давхар ойлгохыг хүсдэг.

- ✓ **Хувиараа бие даан сурах:** Тэд бие даан ганцаарчлан сурах чадвартай бөгөөд энэхүү чадварыг нь технологийн хөгжил илүү дэмждэг.
- ✓ **Багаар ажиллах чадвар муу:** Өмнөх үеүдтэй харьцуулахад тэд багаар ажиллах, хамтын суралцахуйн чадвар муу гэсэн хэдий ч онлайн орчинд ажиллахыг санал болговол илүү үр дүнтэй. / <https://www.buro247.mn/lifestyle/expert/z-eiykhniy-talaar-bid-yuug-medekh-kheregtey-ve.html/>

Цахим сургалтын арга зүйд суралцах, суралцахуйн дизайнер болох. Багш бүр өөрийн заадаг хичээлийнхээ сурах үйл ажиллагааг үр дүнтэйгээр төлөвлөх системийн арга зам бүхий сургалтын дизайныг нь боловсруулж цахим сургалтыг үр дүнтэй явуулах хэрэгтэй. Орчин үеийн шинэ шаардлагын дагуу үр дүнд суурилсан боловсролын чиг хандлага, арга зүйг сургалтдаа ашиглах нэн шаардлагатай. Үр дүнд суурилсан боловсрол буюу CDIO санаачилга нь 2000 оноос дэлхийн улс орнууд дээд боловсролын системдээ CDIO стандарт, арга зүйг хэрэгжүүлж эхэлснээс хойш эдүгээ Европ, Хойд америк, Ази, Англи-Ирланд, Латин америк, Австрали, Африк зэрэг 7 бүсийн 160 орчим их дээд, сургууль энэхүү санаачилгад нэгддэг байна. /<http://www.cdio.edu.mn/>

2015 оноос Монгол Улс уг арга зүйг нэвтрүүлэх үйл явцад албан ёсоор нэгдэж ШУТИС, МУИС, ХААИС энэхүү CDIO стандарт, арга зүйг нутагшуулж эхэлсэн бол 2018 оноос ҮБХИС, СУИС, МУБИС зэрэг сургуулиудаар хүрээгээ тэлж 2020 оны байдлаар ТТДС нэмэгдэн, дээд боловсролын сургалтын зарим хөтөлбөрүүдээ дээрх стандарт, арга зүйн хүрээнд нийцүүлэн шинэчилж, суралцагчдын үр чадвар өсөн, дотоодын болон олон улсын магадлан итгэмжлэлд амжилттай хамрагдаад байна.

ММТТ-ээс заадаг ерөнхий суурь хичээл болох "Мэдээллийн технологийн үндэс" Зкр/цагийн хичээл дээр суралцахуйн

дизайныг/Зураг 2/тодорхойлж, үнэлгээний стратегийг загварчилж цахим сургалтдаа нэвтрүүлсэн. Ингэснээр сургалтын чанар үр дүн сайжирч буй нь суралцагчдын багаар ажиллах, бие даан суралцах явцаас харагдсан. Жишээлбэл бие даан суралцах явцдаа хичээлээр олж авсан мэдлэг дээрээ тулгуурлан жижиг хэмжээний видео, insagram story, facebook foster, хийх мөн оюутан бие биеэ үнэлэх нь үнэлгээг илүү нээлттэй, бодитой болгож байсан.



2 дугаар зураг. Суралцахуйн дизайн

Асуудалд суурилсан аргыг хичээлдээ сонгож ашиглан хүргэх хэлбэрүүдээ дараах байдлаар тодорхойлсон.

- ✓ **Видео контент** – Багш суралцахуйг дэмжсэн чанартай бэлтгэгдсэн видео контентууд, нээлттэй нөөц материал /OER/, бүх нийтэд нээлттэй онлайн курсүүдийг /MOOC/ сургалтдаа нэвтрүүлснээр цахим сургалт үр дүнтэй явагдах нэг алхам болно. Суралцагч шинэ үр чадваруудаа суурь болгон ашиглаж хөгжүүлж байвал суралцахуй /сургалт үр дүнтэй байна.
- ✓ **Тонгоруу анги** - Энэ загварт суралцагчид шинэ ухагдахуун, материалыг эхлээд гэрийн даалгаварт өгч танилцуулна. Дараа нь хичээлийн цагаар шинэ ойлголтын талаар ярилцаж, хичээлийн цагийг суралцагч бүрийн суралцах арга барилд тохируулан, бодит дадлагад чиглэн суралцах цагийг нээж байвал суралцахуй /сургалт үр дүнтэй болно.
- ✓ **Онлайн мобайлд суурилсан сургалт** – Суралцагчид гар утас



таблет ашиглан шинээр олж авсан мэдлэг, ур чадвараа асуудлыг шийдэхэд хэрэглэж байвал суралцахуй / сургалт үр дүнтэй болно.

- ✓ **Багт суурилсан сургалт** – Суралцагчид шинэ мэдлэг, мэдээллийг өөрийн болгож өөртөө тусгаж авдаг, тэр талаараа мэтгэлцдэг, багаар ажиллаж, мэдлэгээ хэрэглэж байвал суралцахуй/сургалт үр дүнтэй байна.

Мөн суралцахуйн гол анхаарах зүйл нь суралцагчид сургалтаас хүлээгдэж буй үр дүнгийн тодорхойлолт юм. Суралцагчдын сургалтын үр дүнгийн зорилго нь багш нарын заах арга зүй, суралцагчдын сурах арга барилыг чиглүүлэх болон явцын болон эцсийн үнэлгээг анхаарах явдал юм. Юун түрүүнд үнэлгээний төлөвлөгөө гаргаж ажиллах нь чухал. Ингэснээр үнэлгээний зорилгоо биелүүлэхэд туслах хөтөч болно, сургалтаа дүгнэх мэдээллийн эх сурвалж болно, суралцахуйн үр дүнгийн биелэлтийг хянах хэрэгсэл болж өгдөг. Үнэлгээг боловсруулахад дараах хүчин зүйлс шаардлагатай:

- ✓ **Сургалтын хөтөлбөр** (тодорхой байдал, холбоо хамаарал, хамрах цар хүрээ, ур чадварын түвшин, агуулга, зохион байгуулалт)
- ✓ **Оюутны ур чадвар** (оюутны ур чадварын зорилгыг хангах түвшин, хөтөлбөрийн тасралтгүй сайжруулалт)
- ✓ **Сургалтын чанар** (оюутны амжилт болон идэвхжилтэд багшийн нөлөөлөл)
- ✓ **Заах арга зүй** (нөхцөл байдалд суурилсан, сургалтын өвөрмөц хандлагуудын нөлөө)
- ✓ **Үнэлгээний туршлагауд** (үнэлгээний хандлагуудын чанар-арга барил, үйл явц)
- ✓ **Сургалтын орчин** (сургалтын орчны нөлөө-оюутан суралцахад шаардлагатай лаборатори, студи, туршилт шинжилгээний материаллаг бааз)

Сургалтын үйл ажиллагааны явцыг үнэлэхдээ үнэлгээний төрөл ангиллыг тодорхойлох хэрэгтэй. Үүний тулд юуг үнэлэх вэ? /суралцахуйн үр дүнг үнэлэх

үнэлгээний арга/, юугаар үнэлэх вэ? /үнэлгээний хэлбэрээр/ яагаад үнэлэх хэрэгтэй вэ? /үнэлгээний ангилал/ гэсэн зарчмаар үнэлнэ. Мөн үнэлгээг бодитой байлгах үүднээс үнэлгээний рубрик зохиох нь үр дүнтэй болгодог. Рубрик нь өөртөө сургалтын тодорхой үр дүнг багтаасан байдаг ба тэр нь үнэлгээ хийхэд нөхцөл байдлыг хангасан боловсруулалт үнэлгээний шалгуурыг тайлбарласан тайлбар толь ба шалгуур үзүүлэлтээс бүрдэнэ. Энэ нь сургалтын явцад тодорхой үнэлгээ өгөх үйл ажиллагааны эхлэх цэг болж өгдөг. Ингээд "Мэдээллийн технологийн үндэс" хичээл дээр өөрсдийн үнэлгээний загварыг дараах байдлаар загварчилсан. Бид суралцагчдын мэдлэг, хандлага, ур чадварыг сэтгэл ханамжийн судалгаа, мэдлэгийн үнэлгээ, суралцахуйн үр дүнгийн үнэлгээгээр CDIO үнэлгээний аргуудыг ашиглан багаар болон хувь хүн бүрээр сургалтын үр дүнгээ тодорхойлсон юм. **(3 дугаар зураг)**

№	Үнэлгээний стратеги		Үнэлгээний аргууд	Сургалтын үр дүн			
				Явцын үнэлгээ		Эцсийн үнэлгээ	
				Багаар	Хувь хүн	Багаар	Хувь хүн
1	Хандлага	Сэтгэл ханамжийн үнэлгээ	Асуулга	★		★	
2	Мэдлэг	Мэдлэгийн үнэлгээ	Ганцарчилсан ярилцлага		★		★
			Даалгавар	★		★	
			Аман асуулга		★		★
3	Ур чадвар	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээ	Шалгалт сорил	★	★	★	★
			Практик	★		★	★
			Рубрик	★	★	★	★
			Дүрд тоглох	★	★		★
			Мэргэжлийн хэлэлцүүлэг	★			★
			Симуляц (Туршилтын үнэлгээ)	★		★	

Нийт: 100

3 дугаар зураг. Үнэлгээний загвар Багаар ажиллах ур чадварын үнэлгээний рубрик

Шалгуур үзүүлэлт	Хүлээлтээс доогуур(1)	Хүлээлтэнд хүрч байгаа(2)	Хангалттай сайн(3)	Оноо
Хандлага (мэдээллийн эрэл хайгуул хийж, төлөвд хувилбарыг санаачилга)	• Асуудалд хандах илэрхийлэл нь төслийн зорилгоос оролцсон	• Асуудалд хандах илэрхийлэл нь төслийн зорилгод үр дүнтэй нийцж байна	• Асуудалд хандах илэрхийлэл нь шинэлэг, төслийн зорилгод үр дүнтэй нийцж байна	
Цэгийн мөнөөмөнт (төслийн үе шатыг төвлөвлөсөн, хугацаана бүрэн дүүрсэг)	• Хугацаа дүүссэны дараа илгэлийг хуваалгасан	• Хугацаа дүүссэны дараа хуваалгасан	• Төслийг хугацаанд нь бусуу өмнө нь хуваалгасан	
Багийн технологийн ур чадвар (онлайн дээр тулгуурласан уулзалт хэлэлцүүлгийг туршиж)	• Илтгэлийг хуваалгадда ямар ч ач холбогдолгүй хандсан	• Онлайн уулзалтад хангалттай ашиглалтын ур чадвар байсгүй.	• Онлайн уулзалтад хангалттай хамрыгдалгүй, програм болон техник технологийн ашиглалт хангалттай биш.	
			• Даалгавар гүйцэтгэлийн хугацаанд хангалттай сайн харилцаа холбоо үүсгэсэн, програм болон техник технологийг ашиглалт маш сайн	

Нийт оноо:

4 дүгээр зураг. Багийн рубрик үнэлгээ Хувь хүний ур чадварын үнэлгээний рубрик



Шалгуур үзүүлэлт	Хүлээлтээс доогуур(1)	Хүлээлтэнд хүрч байгаа(2)	Хангалттай сайн(3)	Оноо
Илтгэх үр чадвар/иэтгэх үнд дүү хоолой уган бус хариуцажиромоо зангаа, ннд, үйл явдал (м) өвч томируулан (сэрэлгэх)	Илтгэх нь үзэгчид ойлгомжтой, дүү хоолой хамир, сул үг их хэрэглэсэн	Илтгэх байдал сайн, үзэгчид ойлгох боломжтой, дүү хоолойны янги жид.	Илтгэлийг сонирхолтой, уран тод илтгэсэн үмэр сонирхол татсан.	
Харилцааны үр чадвар(сэрэг хандлагар бусаддаа нөлөөлнө)	Үний сонголт оноогой биш, асууны төлөвшил хүмүүсийн харилцан аргаартай байдлыг хүлээж авах чадвар дутмаг	Бусдыг сонсох, бусдад зөвлөгөө өгөх, бусдын зорилга шаардлагыг ойлгох болон асууны төлөвшил сайн	Бусдын ялгатай байдлыг хүлээн зөвшөөрч, зөвлөгөө өгөх туслах, сайн сонсох байж, асууны төлөвшил хандлагараа мөнчилж байсан	
Өөрийн мэдлэг туршлагаа ашигласан байдлуурэг харилцагаа ухамсарлан бүтээж хандлагаа хангалттай	Өөрийн мэдлэг үр чадвараа ил гаргажгүй	Мэдлэг үр чадвараа бүрэн дүүрэн ашиглахаас татгалзсан	Мэдлэг үр чадвараа хангалттай сайн ашигласан, үр дүнд хүрсэн	

Нийт оноо:

5 дугаар зураг. Хувь хүний рубрик үнэлгээ

Дүгнэлт. Дээрх сургалтын болон үнэлгээний аргуудыг ашиглаж үр дүнд суурилсан сургалтыг зохион байгуулснаар оюутны эзэмшсэн мэдлэгийг асуудалд суурилсан сургалтаар дамжуулан системтэйгээр сэтгэх чадвар, тасралтгүй суралцах чадвар, ёс зүйтэй байж хариуцлагаа ухамсарлах чадвар, багаар ажиллах чадваруудыг эзэмшиж хувь хүний харилцаа, хандлага өөрчлөгдсөнөөр сургалтын үр дүн сайжирна гэж үзэж байна. "Z" үеийнхэн ном уншиж

суралцахаас илүүтэйгээр компьютер тоглонгоо, сонирхож байгаа мэдээллээ интернэтээс хайж олох, бие даан сурах тал дээр илүү чадамжтай. Мөн багшийн хичээлийг урьдчилан судалж, хичээлийн цаг дээр бусадтайгаа ярилцаж, бие биедээ мэдээллээ солилцох, дүгнэлт гаргах замаар үр дүнтэй суралцдаг болсон. Иймд багш суралцагчдадаа "Урвуу-тонгоруу" буюу "Flipped class" анги үүсгэх сургалтын аргыг ашиглах нь илүү үр дүнтэй харагдаж байгаа юм. Цар тахлын нөлөөллөөс үүдэлтэй их сургуулийн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд цахим сургалт, дижитал технологийг хэрэглэх шаардлага гарсантай уялдуулан ҮБХИС-д цахим сургалтыг хөгжүүлэх бодлого, стратегийг тодорхой болгох, сургалтын нэгдсэн платформ, сургалтыг дэмжих системтэй болох, техник технологийн боломжийг нэмэгдүүлэх, сайжруулах ажлыг эрчимжүүлэх нэн шаардлагатай асуудал болоод байна.

Ашигласан материал:

1. Бадарч Д, Дээд боловсролын шинэчлэлийн инноваци УБ., 2013 он
2. CDIO санаачлагын материал 2013-2017 олон улсын хурлын эмхэтгэлийн түүвэр УБ., "Офсет хэвлэлийн газар" 2019 он., х.х:109.5 ISBN 978-9978-61-55-9
3. <http://www.cdio.edu.mn/>
4. https://www.must.edu.mn/media/uploads/files/Last_Ver_04.pdf
5. <http://baabar.mn/article/generation-z-z-ueiinkhen>
6. <http://www.cdio.edu.mn/>
7. Unesco publishing. (2015). Rethinking Education.
8. Seemiller, C., & Grace, M. (2017). Generation Z: Educating and engaging the next generation of students. About Campus, 22(3), 21-26.



ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗ БА ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖ

Н.ЖАЛБАЖАВ /Шихихутаг Хууль зүйн дээд сургуулийн судалгааны хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D) профессор/

С.БАЙГАЛМАА /ЛБХИС-ийн АБДС-ийн Нийгэм Хүмүүнлэгийн тэнхимийн дэд профессор/

Түлхүүр үг: Төрийн хууль цааз, их засаг хууль, үндэсний ой санамж, шударга ёс, ёс суртахуун, Үндсэн хууль, үндсэн хуульт ёс, хууль тогтоомж, хуульд нийцсэн байдал

Key words: Law-governed state, Ikh zasag law, national memory, justice, morality, constitution, constitutional law, legislation, legality

Хураангуй. Хүмүүнлэгийн ой санамж нь төр улс үндэстний түүхээс гадна олон улсын/нийт хүн төрөлхтний/ болон үндэсний хууль цааз, хууль эрх зүйн сэтгэлгээнд нь тусч шингэсэн байдаг. Хүн нийгэм, хүн, хүн байгаль эх гэсэн гурвалсан харилцааны соёл, хэм хэмжээ, дэг журам бүрэлдэн тогтсон түүх нь хууль цааз, эрх зүйн сэтгэлгээний түүх болно. Энэ түүхэн үйл явцад хүний нийгэмшин амьдрах, хэн нэгний хүч чадал эрх мэдлийн эрхшээлд /эсхүл эрхшээх/ зохион байгуулагдан аж төрөх буюу хүний төрөлхийн "улс төрлөг" мөн чанар илэрдэг бөгөөд үүнийг Аристотель /"улс төр"/, хожим Макс Вевер "Улс төр мэргэжил, хувь тавилан болох нь" /нар "хүний нийгмийн уугуул мөн чанар бол оршихуйн тулд хамтран аж төрөх, хамтрахуйн утга учир нь зохион байгуулалтад", өөрөөр хэлбэл хүн амьдрахын тулд хүмүүний аль нэгэн олонлогт /овог, аймаг, өрх гэр бүл, улс үндэстэн г.м /харьяалагдан, хууль цааз, ёс журам, зан заншил г.м/ багтан засаглагдан /засаглаж/ аж төрөхөөс өөр замгүй гэж тодорхойлжээ. Үүнийг хүний, хүний олонлогийн өнгөрсөн, одоогийн нь туршлага, ой санамжид нь суурилсан оршихуйн арга ухаан гэх бөгөөд эрх зүйн сэтгэлгээ гэж ч нэрлэдэг байна.

Хүмүүн, төр, хуулийн бие биеэ нөхцөлдүүлэх энэ холбоог бүр эртний сэтгэгчид Гераклит, Сократ, Платон, Аристотель нар "хүнд төр хэрэгтэй бол төрд өөрт нь хууль гарцаагүй хэрэгтэй", хаана хууль байна тэнд төр ёс байна", "Хуулинд захирагддаг байх нь төрийн нэг ёсны атрибут¹" гэх зэргээр тайлбарласан

байдаг ажээ. Учир иймд "хүний түүх бол улс үндэстний түүх, улс үндэстний түүх бол төрийн түүх, төрийн түүх бол хууль цаазын түүх" болдог учиртай ажээ.

Хууль цааз, ёс журмыг эрхэмлэн сахих, төр улс, иргэний гол гол хэргүүдээ хуульд захируулан шийддэг нь Монголын ард түмэн, монгол төрийн нандин уламжлал, ой санамжийн нь чухал зүйл нь юм.

Монголчуудын хууль цаазын ухамсар сэтгэлгээ, ой санамжийн чиг баримжаа, түүх уламжлалын "тодоос тод сонин" үнэт зүйл бол Суут богд Чингис хааны "Алд бие минь алжааваас алжаатугай, ахуй төр минь бүү алдраг" алтан сургаал, түүний бодож санаачилсан "Их засаг" хууль юм. Энэ бол бас зөвхөн цөөн монголчуудын төдийгүй, нийт хүмүүн төрөлхтний төр барихуй, хууль эрхийн сэтгэлгээний үнэт зүйл болохыг ертөнцийн мэргэд тэмдэглэсэн нь цөөнгүй. Чингис хаан ухаан бодол, мэргэн ухаан суу залиараа "Дэлхийн хамаг хаадын орой нь байж, хүчирхэг хосоровчуудын тухай бичигдсэн болгоныг, Фараонууд/Египтийн хааны цол хэргэм/, Кесариудын/Юлий Цезарийн нэр/ тухай он дарааллын бичиг, эртний сурвалж бичгүүдийг судлах гэж зүдрэлгүй өөрийн хар толгойгоороо хууль дүрэм тогтоон мөрдүүлсэн юм.

Улс орнуудыг эзлэн авсан арга, дайсныхаа сүр хүчийг мөхөөдөг чадварын тухайд гэвэл тэр түүний соргог ухаанаараа сайтар бодож, боловсруулдаг хүч, өргөн дэвшүүлсэн нөхдийнх нь тус юм" хэмээн Жувейны "Ертөнцийг байлдан дулагчийн түүх"-дээ бичсэн бол Рашид-ад-Дин "Судрын чуулган"-даа "Ирээдүйд таван

¹ Платон .Төр улс .Бүтээлийн 3 боть түүвэр.Орос хэл дээр.М.,1972.т.198-199



зуу, мянга, арван мянган жилд ч хэрэв нарт хорвоод төрж, хаан төр барих удмынхан минь аль ч улс түмэнд хэрэглэгдэхээр Чингис хааны ёс суртахуун, Засаг хуулийг өөрчлөлгүйгээр сахивал тэдний гүрэнд мөнх тэнгэрээс аврал бууж, тэд хэзээ ямагт баяр баясгалантай, аз жаргалтай байх болно" гэх зэргээр бичиж үлдээжээ.

Их Монгол Улсын төрийн хууль цааз, эрх зүйн эх сурвалж нь "Их засаг хууль" байсан бөгөөд уг хуулиар төрийн хэлбэр, дэглэм, хааны эрх мэдэл, төрийн байгууллагын зохион байгуулалт, эрх, үүрэг, ажиллах журам, засаг захиргааны хуваарь, газар нутаг, байгаль хамгаалал, эзэн албатын ёс, алба татвар, ёс заншил, эрүүгийн бодлого, ял ногдуулах ба эдлүүлэх зарчим, журмыг тодорхойлон тогтоожээ. Тухайлбал их засагт гадаад харилцааны цааз, цэргийн цааз, шүүх, шашны цааз/эдгээрийг бүхэлд нь "төр засах цааз"-д, харин ахуй заншил, иргэд хоорондын харилцаа, сургаал сургамж, тэтгэвэр, тэтгэмж, өмч хөрөнгө, өв, залгамжлал, гэрлэлт, гэр бүл, арилжаа худалдааны шинжтэй хэм хэмжээнүүдийг "иргэний аж байдлын цаазад хамруулснаас гадна Их Монгол Улсын төрийн бүрэн эрх, нийгэм төрийн байгууламжийг бэхжүүлэх, түүнчлэн хуулиар тогтоосон бүх хэв журмыг гэмт халдлагаас хамгаалах "эрүүгийн цаазыг тодорхойлон тогтоосон, өөрөөр хэлбэл нийгмийн харилцааг бүхэлд нь эрх зүйн зохицуулалтад оруулжээ². Их засаг хууль хийгээд Их Монгол Улсын төрийн гадаад бодлого нь хил хязгаарын аюулгүй байдлыг хангах, гадаадын халдлага довтолгооноос сэргийлэх, өрнө дорнын улс оронтой улс төр эдийн засаг, соёлын хэлхээ холбоогоо өргөтгөх, мэдээллийн солилцоог идэвхжүүлэх, улс орноо засан тохинуулах гээд хожим хойчдоо төрийн бодлогын "Алтан аргамж" болсон олон санаа шингэжээ. Элчин төлөөлөгчдийн эрх ямба, аюулгүй байдлыг баталгаажуулах, халдашгүй байдлын "Гэрэгэ" тэмдэг олгох зэргээр өнөөгийн дипломат ёсны соёлын төлөвшилтөд монголчуудын оруулсан үнэтэй хувь нэмэр нь юм.

Их засгийн цэргийн цаазад цэргийн алба хаах үүрэг, дайн байлдааны үед баримтлах дэг, тэдгээрийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх ял зэм зэргийг хамгийн өргөн тусгажээ. Тухайлбал:

- эр хүн 20 нас хүрвээс цөм цэргийн алба хаах үүрэгтэй;
- жанжин захирагчаасаа жирийн цэргээ хүртэл дайсангүй цаг үед ч дайны бэлтгэл хийх;
- байлдааны талбарт шархдагсдаа хамаагүй орхиж үл болох;
- хэрэв дийлэгдвэл, довтолгоон эхэлсэн байрандаа эргэж ирэх, эс ирвэл алах ялаар шийтгэх;
- дайны үед ганц нэгээр буюу хэд хэдээр оргож босвол алж шийтгэх;
- дайсныг гүйцэд ялахаас өмнө хэн нэг хүн олз ашиг хайхаар явсан байвал хүндээр ялдан залхаах гэх мэтээр заасан байна.

Гуулин улсын сударт буй мэдээнээс үзэхэд "...цэргийг цэргийн эрдэмд сайтар сурган, бүгдийг гавшгай цэрэг болтол нь хатуужуулах, хүчин буюу данги хүнийг ацаглан жинхэнэ цэргийн оронд хүний тоо бөглүүлж, цэргийн алба хашуулахыг хориглох цэрэг хөдөлсөн үед цэргийн олсон хүн мал, бусад бүх эд таваар нь тус тус тэрхүү цэргийнх болох бөгөөд цэргийг харьяалах дарга захиран хурааж авч болохгүй... Иргэдийн хогшлоос өчүүхэн зүйлийг ч дээрэмдэхийг цаазлан хориглоно" гэх зэргээр зохицуулсан байжээ.

Эх дэлхийгээ бүхэлд нь хайрлан хамгаалж уул, усаа "амилуулан" шүтэж халдах, хандах зан үйлийн хорио цээрлэлийг тогтоон мөрдүүлж, тэр бүхнээ нийт иргэн, үр хойчдоо ухааруулан мэдрүүлж, амьдрал ахуйгаа байгаль орчинтойгоо нягт хослуулан зохицуулж ирсэн өвөрмөц арга уламжлал юм. Байгаль хамгаалах энэхүү монгол уламжлалыг алдалгүй сахин авч явах нь үндэсний төдийгүй нийт хүмүүнлэгийн ой санамжид хадгалагдах учиртай зүйл юм. Хүн төрөлхтний түүхэнд төрийн хууль цаазад эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг

² Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжилал. УБ., 2021. т.89-90



анхлан тусгасан нь Их засаг хууль гэх үндэс бас байна, Тухайлбал, Гуулин улсын судраас профессор Сумьяабаатарын олсон баримтад: "зэрэг захирагч хийгээд цэргүүд хүчиндээ дулдуйдан, шинэ дагасан аливаа хот, гацаанаа эмс хийгээд охидтой хүч түрэн гэрлэж болохгүй" хэмээн заасан байна³. Эрдэнэт хүмүүний амь бие, эд хөрөнгө, эрүүл мэндийг сахин хамгаалах нь Их засаг хуулийн "амин сүнс" нь байсныг онцолбол зохистой. Эдгээрийг зөрчвөл ялын дээд хэмжээ оноохоор хуульчилжээ.

Ийнхүү Их засаг хууль нь тухайн нийгмийн зайлшгүй бодит хэрэгцээ шаардлагаас үүдэн гарсан, хүмүүнлэгийн харилцааны олон талыг хамруулан эрх зүйн зохицуулалтад оруулсан шинжтэй байснаараа жам ёсны хууль байжээ. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нарын тодорхойлсноор Их засаг хууль бол дэлхийн соёл иргэншлийн түүхнээ бүхэл бүтэн нийгэм, улс төрийн байгуулал бүрэлдэн тогтооход томоохон үүрэг гүйцэтгэсэн эртний Вавилоны Хаммурапын хууль, Энэтхэгийн Манугийн хууль зэрэг алдартай хуулиудтай эн зэрэгцэхүйц ач холбогдолтой эрхэмжийн нэн чухал баримт бичиг мөн. Учир нь энэ хуулийн зарчим, үзэл санаа зөвхөн монгол нутагт төдийгүй ертөнцийн талыг эзэгнэсэн их гүрний хэмжээнд үйлчилж байсны хувьд дэлхийн хууль цаазны түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээсэн бүлгээ⁴.

Их засаг хуулийн үзэл санаа, төрийн гол хууль байсан жишиг нь Их Монгол Улс, Юань гүрэн, Богд хаант Монгол Улс, БНМАУ, Монгол Улс гээд монголын буурал түүхийн бүх үед төрийн хуулийн бодлого үйл ажиллагааны нэгэн ширгэшгүй эх ундарга, чиг баримжаа, монголчуудын үндэсний ухамсар ой санамжийн үнэт зүйл нь болж иржээ.

Нэгэн зүйлийг онцлон дүгнэхэд Монголын түүхийг нүүдэлчин монголчууд хэзээнээс дур зоргоороо аж төрдөг, эрхийн соёлгүй гэх мэтээр санаатай, санаагүй мушгин гуйвуулах оролдлого гарсаар иржээ. Энэ тухайд Р.Сайшаал абугай "Чингис хааны нууц товчоон" бүтээлдээ: "Монголчуудад хууль дүрэм байхгүй гэдэг яриа бол монгол үндэстний түүхэн байдлыг мэддэггүй хүмүүсийн дур тавын яриа болно гэжээ. Түүх шастирыг хянан үзэхүл Монгол үндэстэн нэлээд эртнээс хууль дүрэмтэй байжээ. Чингис хаан шинэхэн байгуулсан Монголын хаант улсыг бэхжүүлэхийн төлөө ...нийгмийн ёс дэглэмийг тогтоож энэхүү төрөлх ... зарлиг, дүрмийг тогтоож нүүдэлчин үндэстнээ хуулиар засахын төлөө Монголын ёс дүрмийн эх товчоог тогтоож, үсэг бичгээр анх удаа тэмдэглэсэн хууль цаазын бичиг "Их засаг"-ийг байгуулан бүх улсын заргач түшмэлийг томилжээ" гэж няцаалт өгчээ. Ой санамжаа сэргээж хурцалбал эх түүхээ хамгаалж чадахын жишээ энэ болой.

Ашигласан материал:

1. МНТ.Ц.Дамдинсүрэнгийн орчуулга.УБ., 2009 он.
2. Рашид Ад Дин. Судрын чуулган.УБ., 2009 он.
3. Л.Гумилев нар. Хар домог.УБ.,1992 он.
4. Р.Сайшаал. Чингис хааны товчоон.УБ., 2010 он.
5. Ж.Уеторфорд. Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Эзэн Чингис хаан. УБ.,2009 он.
6. С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахуун - эрх зүйн шаштир.УБ., 2014 он.
7. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр,эрх зүйн түүх, уламжлал.УБ., 2021он.

⁴ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан.Монгол Улсын төр ,эрх зүйн түүхэн уламжилал.УБ., 2021.т.94



МОДУН ШАНЬЮЙН ЦЭРЭГ

Т.ЭРДЭНЭХИШИГ /БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн
ЭШТА, доктор (Ph.D), профессор/

Түлхүүр үг: Морьт цэрэг, цэргийн бэлтгэл, цэргийн хүч чадал

Key words: Cavalry, military training, military power

Хураангуй. 2021 он бол Хүннү гүрэн үүсэн байгуулагдсаны 2230 жилийн ой тохиож байгаа онцлог жил юм. Монголчууд бид өнө эртний өвөг түүхтэй ард түмэн гэдгээрээ бахархахгүй байхын аргагүй бөгөөд НТӨ 209 онд Хүннүгийн Модун шаньюй ази европыг холбосон хүчирхэг гүрэн байгуулахаас хавьгүй өмнө буюу одоогоос 5000 гаруй жилийн тэртээ монгол угсаат нүүдэлчид төр улсаа байгуулсан байсан талаар түүхчид бичих боллоо.

XX зууны Монголын төр, шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн А.Амар 1933-1934 онд туурвисан "Монголын товч түүх" бүтээлдээ Нанхиад судруудад "үүнээс урагш таван мянга шахам жилийн үед Нанхиадын эн тэргүүний эзэн болох Фу си, Шэнь Нун, Хуан Ди хэмээх гурван хуангийн сүүлчийн Хуан Ди хаан нь Чингисийн төрсөн оноос урьд гурван мянга найман зуун тавин найман оноос эхэлж байсан бөгөөд түүний үед Хунь Юйг хойш хөөжээ" хэмээсэн ба мөнхүү Хунь Юй нь Монголын өвөг хэмээжээ гэсэн байна.

Өвөр Монголын нэрт түүхч тайчууд Мансангийн эрхлэн гаргасан "Монгол үндэстний бүрэн түүх" хэмээх 6 боть бүтээлд монголчуудын өвөг дээдсийн байгуулсан анхны төрт улс болох "Хиан улс НТӨ 2033 оноос НТӨ 1562 он болтол 471 жил, түүний халааг авсан Бидгүд улс НТӨ 1562 оноос НТӨ 1066 он болтол нийт 496 жил оршин тогтносон"-ыг хятадын эртний сурвалж бичгүүдийн мэдээ, эртний судлалын баримтад тулгуурлан нотолсон байна.

Эртний тэр цагт улс оршин тогтнохын нэг үндэс нь төр, төр оршин тогтохын нэг үндэс нь хүчирхэг цэрэг арми байлаа. Өнөөгийн Монгол Улсын нутгаар төвлөн сууж байсан эртний монгол угсаат

нүүдэлчид төв азийн тавцанд мандан бадарч, уруудан буурч явахдаа хүн төрөлхтний амьдралын салшгүй үзэгдэл болох дайн байлдаанаас ангид байсангүй.

Аливаа нэг төр улсын хүчин чадлыг цэрэг зэвсгийн хүчин чадлаар нь хэмждэг ёс өнөөг хүртэл байсаар байгаа билээ. Хүчтэй нь хүчгүйгээ гэдэг хууль үйлчилдэг байсан эрт цагт монгол нутагт төр улс байгуулан оршин тогтнож байсан монгол угсаат улсууд гаднын түрэмгийлэл, заналхийлэлд байнга өртсөөр ирсэн ч өнөөг хүртэл тусгаар тогтнолоо хадгалсаар ирсэн нь цэрэг зэвсгийн хүчээр бусдаас дутуугүй байсныг гэрчилнэ.

Монголчуудын өвөг Хүннү нар НТӨ нэг дэхь мянган жилийн сүүлээр Төв Азид өрнөж байсан олон угсаатны түүхийн үйл явцад идэвхтэй оролцон, өмнөд хөрш нангиад аймгуудаас хүн хүчний тоогоор үлэмж дутуу буюу 1:20 гэсэн харьцаатай байсан хэдий ч нэгдсэн Хан улстай цэрэг зэвсгийн хүчээр эн тэнцэхээр барахгүй, зарим талаар илүү хүчтэй байж, ихэрхэг дээрэнгүй ханддаг Хан улсыг өмнөө өвдөг сөхрүүлж явсны тод жишээ бол түүхэнд "198 оны гэрээ" хэмээн нэрлэгдсэн гэрээ билээ. Уг гэрээгээр Хүн нар хятадуудаар нүүдэлчид, суурьшмал иргэдийн хоорондын тэгш эрхийг хүлээн зөвшөөрүүлж чадсан юм.

Хүннү нар хүчирхэгжихээсээ бүр өмнө хүчирхэг морьт цэрэгтэй байсан бөгөөд Хятадын Чжао улсын У-Лин ван Хүннү цэргийн жишгээр цэргийн зэвсэг, дээл хувцсандаа шинэчлэл хийж, цэргээ морь унах, харвах намнахад тусгайлан сургадаг байжээ. Энэ үеэс нэлээд хожуу буюу 400 гаруй жилийн дараа Хан улсын У-Ди хуанди Хүннүтэй байлдахын тулд тэрэгт болон явган цэргээ хүннүгийн жишгээр морьт цэрэг болгон өөрчлөхийн тулд маш их хэмжээний хүч хөрөнгө зарж байжээ.



Хүннү улс аравтын тогтолцоонд суурилсан төр цэргийн нэгдсэн зохион байгуулалттай байсан учир улс орны амьдралд цэрэг онцгой үүрэг гүйцэтгэж байв.

Модун шаньюй олон овог аймгийг нэгтгэх, хөрш зэргэлдээх олон улс орныг эзлэхэд Хүннү цэрэг гол үүрэг гүйцэтгэсэн билээ. Тэрээр "Цэрэг бол төр, улсын гол хэрэгсэл..."¹ хэмээн үзэж улсдаа цэргийн шинэчлэл хийж, цэргүүдийг нэгэн удирдлага дор нэгтгэж, маш хатуу чанд сахилга баттай болгож чадсанаараа хүчирхэг байжээ. Түүхэн сурвалжид бичсэнээр: Модун шаньюй исгэрэн дуугарах дуут сум үйлдээд нэг өдөр ан ав хийж байхдаа гэнэт өөрийн нэгэн хайртай хүлэг морины зүг сумаа харважээ. Цэргүүдийн дийлэнх нь түүнийг даган харвасан боловч нэг хэсэг нь харваагүй тул тэдний толгойг тас цавчжээ. Хэд хоногийн дараа Модун өөрийн хатан руугаа харважээ. Зарим цэргүүд айн тээнэгэлзэж харвалгүй үлдээд мөн толгойгоо авхуулжээ. Дараагийн удаа анд явж байгаад Модун эцгийнхээ хүлэг морийг харвахад цэргүүд цөм даган харважээ. Ийнхүү байсаар Модуны цэргүүд түүний тушаалыг үг дуугүй даган биелүүлэх болсон гэдэг. Хожимхон нь нэгэн удаа Модун эцэг шаньюйн хамт ан ав хийж яваад гэнэт эцгийн зүг сумаа харвахад цэргүүд цөм даган харваж Түмэн шаньюйг хороосон хэмээн тэмдэглэсэн байдаг.

Хүннүгийн шаньюй цэргийн сургалтад хүч бололцоог дээд зэргээр дайчлан сургах зарчим амжилттай хэрэгжиж байсныг НТӨ 201 онд Маодунь Хятадын хилд цөмрөн орж Датун хүртэлх газар нутгийг эзлэн авч ураг найрамдлын гэрээ байгуулснаас харж болно².

Модун шаньюй юун түрүүнд бусадтай дайтах байлдахыг урьдал болгож байгаагүй бөгөөд өөрийн дорнод хөрш Дунху нартай эв найрамдалтай байхын тулд аргамаг сайн хүлэг, хайртай хатнаа

найр тавин өгсөн мөртлөө хэсэг газар гуйхад нь "Газар бол улсын үндэс" хэмээн өгүүлээд өгөхийг зөвшөөрсөн түшмэдийнхээ толгойг авч байжээ. Модун шаньюй тэр нэгэн цагт хэлсэн энэ үг эдүгээ ч гэсэн үнэ цэнээ алдаагүй байна.

Хүннү цэрэг нь тус тусын овог аймгийн цэрэг эр бус, улсын цэргийн нэгдсэн аравтын зохион байгуулалттай байсан бөгөөд улсын дэвсгэр нутгийг хятад болон бусад улс аймгийн түрэмгийллээс батлан хамгаалах, эсхүл бусад орныг довтлон эзлэх, дээрэмдэх үүрэгтэй³ байжээ.

Хүннү улсын цэргийн зохион байгуулалт нь дайны нөхцөлд дээд зэргээр зохицсон байсан ба дайн тулааны цаг болоход цэргүүд нь үтэр түргэн цуглаж нэгдсэн зохион байгуулалтад орж чаддаг байжээ. Хүннүгийн цэргийн тоо зарим үед бараг хагас саяд хүрч байсан байна.

Хүннүгийн цэрэгт хараат орны иргэд ч алба хаадаг байв. Хүннүгийн засаг захиргааны үндсэн доод нэгж нь чжан буюу ло байв. Энэ нь нэг өрх айл гэсэн үг. "Хожуу Хан улсын түүх. Баруун хилийн бүлэг"-т "...нэг өрх нь нөхөр, эхнэр, хүү, охин ойролцоогоор таван хүн байна" гэжээ. Хүннүгийн насанд хүрсэн залуу эрс цөм "Хуягт морьт цэрэг"-т тооцогдоно. Ихэвчлэн нэг өрхийн нэг залуу эр морьт цэрэг болж, арван өрхийн арван эр цэргийн доод нэгжийг бүрдүүлнэ. Тэдний дотроос нь аравтын даргыг томилно. Цэргийн доод нэгж нь нэгдэж 100 хүн болоход зуут болж, зуутын дарга захирна.

Ингэж зуутаас мянгат, мянгатаас түмт болох маягаар арми зохион байгуулагдана. Нэг аймагт ойролцоогоор 5000-6000 хүн байна. Тэд мянгат болж мянгатын дарга удирдана. Хүчтэй ван нь түмэн морьт цэрэгтэй, хүчгүй нь хэдэн мянган морьт цэргийг удирдана. Мөн жижиг ван сянбан, дувэй, данху, цецуюй зэрэг доод тушаалын түшмэд байх ба тэд ванд захирагдана⁴ гэжээ. Хүннүгийн

¹ 史记. 卷110. 匈奴列传

² Орхончимэг.Х. Монгол нутаг дахь эртний улсуудын цэргийн сургалтын мөн чанарыг тодруулах нь. ҮБХИС-ийн Цац сэтгүүл.УБ., 2021.№18(41).т.68-71

³ Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980. т.69

⁴ Ганболд Ж. Хүннүгийн цэргийн тогтолцоо. -Монгол цэргийн түүх судлал, өнөө ба ирээдүй. УБ., 1996. т.68-69

түмт, мянгат, зуут, аравтын дарга нар цэргүүдийн байлдааны бэлэн байдлыг бүрэн хариуцдаг байв.

Хятад сурвалжид өгүүлснээр Хүннү нар хятадуудтай тулалдахдаа давхилт дундаа алсын зайнаас харвахыг илүүд үздэг байсан ба тэд энэ эрдмийг бүр багаас эзэмшдэг агаад нас биед хүрэх үедээ харвах намнах чадвараар гойд сайн болсон байдаг байв. Энэ тухай "Ши цзи" буюу "Түүхэн тэмдэглэл"-д "Хүүхэд дөнгөж хонь унаж чадах болмогцоо хулгана, зурам харвах ба нэлээд өсөж ирэхлээрээ үнэг, туулай харваж иднэ. Нум хэрэглэж чадах хүн болгон цэрэг болно"⁵ гэсэн байна. Ийнхүү дээр өгүүлсэнчлэн Хүннүгийн насанд хүрсэн эр хүн бүр "Хуягт морьт цэрэг болдог"⁶ байсан ба Монгол, Өвөр-Байгальд явуулсан археологийн судалгаанаас үзвэл бараг эр хүн бүрийн булшинд зэр зэвсгийн зүйлийг дагуулан оршуулсан байна.

"Давс төмрийн маргаан"-д өгүүлснээр: "Айл өрх бүр шаардлагатай үед хэрэглэх зэвсэгтэй. Аюул тулгаран ирсэн цагт тэд нум сумаа шүүрэн авч, мориндоо мордоход л гүйцээ... хэдэн арван хоногоор хүрэлцэх хоол хүнс базаах боловч (цэргийн хоол хүнс) тэр нь нүдэнд анзаарагдахгүй, тэд уул, хад агуйг бэхлэлт хэрэм мэт ашиглаж, өвс, усыг үр тарианы агуулах мэт хэрэглэж чаддаг"⁷ гэжээ.

Хүннү цэрэг дайнд явахдаа ачаагаа хариуцуулахаар гэргий, хүүхдээ авч явдаг, түүнийгээ "Гэр цэрэг" гэдэг байв. "Хожуу хан улсын бичиг. 79 дүгээр бүлэг", "Давс төмрийн бодлого. Гавьяа бүлэг" зэрэгт өгүүлснээр "Хүннү эмс охид цэргийн хуарандаа мал сүргээ хариулдаг. Ар талын нүсэр ажлыг дангаар гүйцэтгэдэг.

Алсын аян дайны үед эмэгтэйчүүд, хөгшид үхэр, хонь, адуу, луусаа даган нүүдэллэж цэргийг хоол хүнсээр огт үл тасалдуулдаг"⁸ байжээ.

Хүннүд хойд эх, бэр, бэргэнтэйгээ нөхөр нь үхэхээр суух тэтгэх гэрлэлт (левират)⁹ болох овгийн байгууллын үеийн ёс заншил хадгалагдсаар ирсэн нь Хүннү цэргийн байлдааны чадварт ихээр нөлөөлдөг байв.



Хүннүгийн морьт цэрэг (БНМАУ-ын түүх УБ, 1966 номоос дам авав)

Хүннүгийн морьт цэрэг. (БНМАУ-ын түүх. УБ., 1966 номноос дам авав)Учир нь цэрэг эр дайнд үрэгдэвч бэлэвсэн гэргий, үр хүүхэд нь өнчрөлийн зовлон амсдаггүй, эр цэрэг дайн тулаанд орохдоо ар гэртээ санаа зовохгүйгээр байлддаг нь Хүннү цэргийн сэтгэл зүйн бэлтгэлийн хувьд шийдвэрлэгдсэн чухал асуудлын нэг байв¹⁰. Хүннүд мөн цэргийн сэтгэл санааг дэмжиж урамшуулахын тулд "Дайсны толгойг авчирсан хүнийг нэг ваар дарсаар шагнаж, олсон олзыг нь бүгдийг өгдөг"¹¹ байв.

Хүннү "Намар адуу мал таргалах үеэр бүх хүмүүс ой модыг самнан ан хийдэг"¹² байсан ба энэ мэт зохион байгуулалттай

⁵ Si Ma qian. Shi ji. Juan110. xiong nu lie zhuan. Le tian chu shu ju. Chu ban. Zhong hua min guo liu shi san nian. Di 2876 ye

⁶ Meng gu shi lun wen xuan ji. Di wu. Hu he huo te. 1983., di 93 ye.

⁷ Хуань куань. Спор о соли и железе. М., Т.И. 2001. т.167

⁸ Хуань куань. Спор о соли и железе. М., Т.И. 2001. т.69

⁹ Сүхбаатар Г. Монголын эртний түүх судлал. IY боть. (Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн эмхэтгэл) УБ., 2005. т.155

¹⁰ Ганболд.Ж. Дээрх зохиол. т.70

¹¹ Худяков.Ю.С. Вооружение средневековых кочевников южной сибир и центральной азии. Новосибирск., 1986. с. 52

¹² Бичурин Н.Я. Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена.Том I . М-л., 1950. с. 49-50



ав хомрог нь нэг ёсны цэргийн сургууль болдог байв. Нум сум бол Хүннүгийн байлдааны болоод ангийн гол зэвсэг байсан бөгөөд Хүннү-Парфяны нум нь НТӨ I зууны сүүлч гэхэд хамгийн шилдэгт тооцогдож байжээ. Тийм учраас Хүннү нар хятадуудтай тулалдахдаа давхилт дундаа алсын зайнаас харвахыг илүүд үздэг байв.

Хүннүд их цэрэг, цоохор цэрэг гэж хоёр төрлийн цэрэг байсан ба их цэрэг нь байнгын, цоохор цэрэг нь түр цэрэг байсан тухай сурвалжид¹³ гардаг байна. Дээрх хоёр төрлийн цэргээс гадна Хүннү улс хил хамгаалах цэрэгтэй байжээ. Энэ талаар Шицзи-д: "Дунху Хүннүгийн хоорондох хүн нутагладаггүй орхигдсон эзэнгүй нутаг 1000 гаруй ли газар үргэлжилнэ, тус бүр хоёр захаар оуто болон нутаглана" гэсэн мэдээ байдгаас

харахад дээрх оуто гэгч нь Хүннү, дунху хоёрт хоёуланд нь байжээ. Оуто гэх үгийн утгад хилийн хамгаалалттай холбоотой бүхий л асуудлууд багтаж байсан бололтой. Шицзи-д мөн "Оуто болон сууцгаана" хэмээн тоотой олон тоогоор бичсэнээс үзэхэд Хүннүгийн хилийн цэрэг цөөн бус байсан ба хилийг хариуцан захирсан ванг "Оуто ван" хэмээн нэрлэж байжээ. Сурвалжийн мэдээнээс харахад Модун шаньюйгаас бүр өмнө Хүннү, Дунху хоёр улсын хооронд ч хилийн ийм зурвас нутаг байсан байна.

Эцэст нь өгүүлэхэд нүүдэлчид газар тариалангийн суурьшмал соёл иргэншилт орнуудаас хөдөлгөөнт чанар, зэр зэвсэг, цэргийн хэргийн мэдлэгээр илүү байсан учир тухайн үедээ бүс нутагтаа тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байсан нь судалгаанаас харагдаж байна.

Ашигласан материал:

1. Бичурин Н.Я. Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена. Том I. М.-Л., 1950.
2. Ганболд Ж. Хүннүгийн цэргийн тогтолцоо. -Монгол цэргийн түүх судлал, өнөө ба ирээдүй. УБ., 1996
3. Доржсүрэн Ж. Умард хүннү. УБ., 1981
4. Орхончимэг Х. Монгол нутаг дахь эртний улсуудын цэргийн сургалтын мөн чанарыг тодруулах нь. УБХИС-ийн Цац сэтгүүл. УБ., 2021. №18(41).
5. Саруул И. Хүннү гүрний хилийн харуул ба хамгаалалт. // Археологийн судлал. Т. XVI, F.1-11, УБ., 1996
6. Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980
7. Худяков. Ю.С. Вооружение средневековых кочевников южной сибирей и центральной азии. Новосибирск., 1986
8. Хуань куань. Спор о соли и железе. М., Т. II. 2001
9. Si Ma qian. Shi ji. Juan 110. xiong nu lie zhuan. Le tian chu shu ju. Chu ban. Zhong hua min guo liu shi san nian.
10. Meng gu shi lun wen xuan ji. Di wu. Hu he huo te. 1983
11. 史记. 卷. 110. 中华民国六十三年. 台北

¹³ Доржсүрэн Ж. Умард хүннү. УБ., 1981. 87-88 дахь тал

¹⁴ 史记. 卷. 110. 中华民国六十三年. 台北. 第2889页

¹⁵ Саруул И. Хүннү гүрний хилийн харуул ба хамгаалалт. // Археологийн судлал. Т. XVI, F.1-11, УБ., 1996. 105 дахь тал



МОНГОЛЫН ЭРТНИЙ ЦЭРГИЙН СУРГАЛТЫН ЗАРИМ АРГЫН ҮНДСИЙГ ТОДРУУЛАХ НЬ

Х.ОРХОНЧИМЭГ /БХЭШХ, Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн ЭШАА, доктор (Ph.D), дэд профессор/

Түлхүүр үг: Цэргийн сургалт, сургалтын арга барил, сургалтын зэвсэг

Key words: Military training, teaching method, drill ammunition

Хураангуй. Монгол цэргийн сургалт, боловсролын тогтолцоо үүсэн бүрэлдсэн үйл явцыг нарийвчлан судлах нь чухал ач холбогдолтой. Эрт үеэс монголчууд оршин буй нутаг дэвсгэр, байгаль цаг уурын орчин нөхцөлтэй зохицолдож улс аймгаа хамгаалахын зэрэгцээ хүчирхэгжин батжиж байсан нь тэдний өөрсдийн бий болгон хөгжүүлж ирсэн олон арга барилуудтай холбоотой. Энэ өгүүлэлд монголчуудын ахуй амьдралдаа өргөн хэрэглэж хүнс, тэжээлээ олох, аюулаас хамгаалах, овог аймгаа өргөтгөх хүчирхэгжихэд үндсэн арга болон хэрэглэгдэж байсан нум сумаар тулалдах аргын үндэс болон монгол нутагт амьдрагсад хөрш зэргэлдээ орны цэргийн сургалтад нэвтрүүлж, буудлага харвааны сургалтын арга барилын хөгжилд монгол цэрэг дайчдын оруулсан үнэтэй хувь нэмэр болсныг тодруулахыг зорилоо.

Монгол цэргийн сургалтын онол, аргуудын үндсийг эх сурвалж баримтуудаас тодруулах асуудал чухал байна. Цэргийн бэлтгэл сургуулийн амжилт нь сургалтын зохих аргыг зөв сонгон авч, тэдгээрийг бүтээлчээр чадварлаг хэрэглэхээс олон талаар шалтгаална. Сургалтын зарчмууд нь сургалтад хэрэгтэй шаардлагуудыг тусгадаг бол арга нь сургалтыг зохион байгуулах, явуулах ажиллагааг тодорхойлж байдаг. Цэргийн сургалтын тухай бичигдсэн баримт материалуудыг судалж сургалтын аргыг боловсронгуй болгох хөгжилд ямар хувь нэмэр оруулсан, монголчууд цэргийн сургалтад ямар арга хэрэглэж үр дүнд хүрч, ирснийг тодруулах хэрэгтэй. Цэргийн сургалтын арга гэдэг бол багшийн удирдлагын дор болон бие дааж суралцагсдаас шинэ мэдлэг, чадвар, мэргэжлийн чадвар эзэмших, танин мэдэх арга ухаанаа хөгжүүлэх зорилго

бүхий сургагч суралцагсдын хамтарсан үйл ажиллагааны арга барил, хэрэгсэл, хэрэглэгдэхүүнүүдийн нийлбэр цогц, тавигдсан зорилтыг хэрэгжүүлэх арга зам юм гэж тодорхойлж ирсэн. Тэгвэл цэргийн сургалтын уламжлалт аргуудын зарим нь эрт үед хэрхэн үүсэж бий болж хэрэглэгдэж ирсэн үндсийг тодруулж байна.

Сургалтын аргуудыг дэвшилтэт ба уламжлалт аргууд гэж ангилан үзэх хандлага байдаг. Уламжлалт аргуудад ярианы арга, хэлэлцэх арга, үзүүлэн таниулах арга, практик үйлийн арга, бие дааж сурах арга, дасгалын, дадлагын аргуудыг голчлон хамааруулдаг. Эдгээр аргуудын зарим нь эртний монгол цэргийн урлагт хэрхэн хэрэглэгдэж, хөгжих үндэс болж байсныг авч үзье.

Монголын эртний цэргийн урлагт нум сумаар тулалдах арга барил хэрхэн хэрэглэгдэх үндэс бүрэлдсэн асуудлыг тодруулах хэрэгтэй. Монгол нутагт амьдарч байсан эртний хүмүүсийн амьдрах арга хэлбэрт нум сум хэрэглэгдэх болсон үйл явц нь дундад чулуун зэвсгийн үеэс эхлэлтэй. "Мезолитийн үед НТӨ 15000-7000 жилийн тэртээ дэлхийн бөмбөрцгийн хойд хэсэгт мөсөн бүрхүүл хайлж, байгаль, цаг уур, хүрээлэн буй орчинд ихээхэн өөрчлөлт орж, хүн амын аль алин шилжин нүүх хөдөлгөөнд орсон. Төв Ази, Монгол, Сибирийн нутагт арслан заан, савагт хирс, мөхөн үгүй болж, цаа бугын сүрэг хойд туйл руу нүүдэллэн оджээ. Умар зүг рүү нүүдэллэж одсон амьтдын нүүдлийг дагаж, хүмүүсийн их нүүдэл болж, Төв Азиас Умард Америкт хүмүүс нүүдэллэн очиж суурьшсан. Палеолитийн үеийн хүмүүсийн агнаж, хамгийн их мах авдаг байсан том ангууд үгүй болж олон тооны ан агнах шаардлага үүссэн. Үүнтэй уялдан ан агнадаг зэвсгээ



илүү дэвшилттэй сайн зэвсгээр өөрчлөх хэрэгцээ үүсч, мезолитын үед модны уян хатан чанарыг мэдэж, ашиглан сэдэж хийсэн хамгийн анхны механик хүчийг ашигласан зэвсэг болох нум сумыг зохион бүтээж хэрэглэсэн байна. Нум сумны мөсийг модоор зэвийг чулуу ясаар хийдэг байжээ. Мезолитын үеийн сумны чулуун зэв Хэнтий аймгийн Рашаан хад, Өвөрхангай аймгийн Мойлтын ам зэрэг олон соёлт давхарга бүхий суурингуудын дээд давхаргууд болон Дорноговь аймгийн Дулаанговь зэрэг суурингуудаас элбэг олддог бөгөөд хэлбэр төрхийн хувьд хэд хэдэн янз байдаг"¹.

Үүний дараа Хүрэл, Төмөр зэвсгийн түрүү үед цэрэг эрс хоорондоо явган болон морьтой тулалддаг байсныг хадны зургуудаас харж болно. Өвөрхангай аймгийн Тэвш уулын хадны зурагт дүрслэгдсэн цэрэг эрсийн дүрс, тэдний зэр зэвсэг, хувцас зэргийг эрдэмтэд судлаад "хүрэл зэвсгийн сүүл, төмөр зэвсгийн эхэн үед цэрэг эрс иж бүрэн зэвсэгтэй байсан ба цэргийн жагсаал буй болсон байна"² хэмээх дүгнэлтэд хүрсэн. Энэ нь Монгол нутагт амьдарч байсан олон овог аймгуудын амьдралд дайн тулаан чухал үүрэгтэй болсныг нотолно хэмээн эрдэмтэд үздэг. "...Тайчууд Мансан Монгол үндэстний бүрэн түүх бүтээлдээ "Хиан Монгол улсын цэргийн байлдааны тэрэгний баг гурван хуягт цэрэгтэй байсан ба тэдний голд дэлбэлэгч, байрлаж, түүний зүүн гарт нум сум бүхий харваач, баруун гарт жадчин цэрэг зогсож тулалддаг байсан" гэжээ. Дашрамд дурдахад монголчууд аливаа дайны ажиллагааг зохион байгуулахдаа фронтын дагууд ихэвчлэн гол, баруун гар, зүүн гар гэж цэргээ хуваадаг байсан уламжлал эндээс үүдэлтэй ч байж мэдэшгүй. Археологийн баримт түшвэл хүрэл зэвсгийн үе буюу НТӨ II мянганд хамааралтай Буган чулуун хөшөө болон хиргисүүрийн соёлыг

тээгчдийн үед байлдааны тэрэг түгээмэл хэрэглэдэг байсан нь нотлогдож байна. Эртний судлаач Ю.С.Худяков, Н.Эрдэнэ-Очир нар хүрлийн үеийн булшнаас гарсан баримтуудад тулгуурлан хос морь хөллөсөн байлдааны тэргийг сэргээн дүрсэлж судалгааны эргэлтэд оруулжээ. Дээр дурдсантай адил бүрэлдэхүүнтэй байлдааны тэргийг тэр үед эртний хятадууд хэрэглэдэг байсан ба Хүннү гүрэн байгуулагдах үед ч байлдааны тэрэг Хятад цэргийн цохилтын нэг гол хэрэгсэл байсаар байв. Харин тэр үед Хүннүчүүд байлдааны тэргийг нэгэнт хэрэглэхээ больж, зэвсэгт хүчин нь дан морьт цэргээс бүрдэх болсон байна. Учир нь байлдааны тэрэг тулалдааны талбар, зам харгуйг ихэд голдог, мөн дан морьт цэргээс хурдаар дутуу байсан тул морьтон монголчууд хүрэл зэвсгийн үеийн сүүлч, төмөр зэвсгийн эхэн гэхэд тийнхүү дан морьт цэргээр дайтах болсон түүхтэй"³.

Хятад сурвалж бичгүүдэд умар зүгийн нүүдэлчдийг довтолсон тухай хэсэг бусаг мэдээ байх боловч эртний нүүдэлчдийн цэргийн зохион байгуулалт, сургалт, зэр зэвсэглэлийн тухай үнэнээр нь дурдсан зүйл бага. "Монгол нутгаас олддог зэр зэвсгийн дотор сумны зэв олон. Эдгээрийг В.В.Волков 3 үндсэн (онгит навчин зэв, онгитой 3 хянгат, 3 талт зэв, шилбэтэй зэв), 25 зүйл болгон хуваасан. Хадны зургийн дотор нум сумны холбоотой зураг маш элбэг байгаа нь эртний нүүдэлчдийн үндсэн зэвсэг нь нум сум байжээ гэдгийг мөн чулуун зэвсгийн үед буй буй болсон гэдгийг шинжлэх ухаанд нэгэнт тодорхой болсон. Нум сум бол эртний нүүдэлчдийн алс зайн тулалдаан довтолгооны гол зэвсэг байжээ"⁴. Өөрөөр хэлбэл монгол нутагт амьдрагсад нум сумыг чулуун зэвсгийн үеэс үндсэн зэвсэг болгон хэрэглэж хөгжүүлсэн байна.

Нум сум бол хүн төрөлхтний өвөг, хүй овгийн ахуй амьдрал, хөгжил,

¹ Монгол Улсын түүх. Тэргүүн боть.УБ.,2004.т.106

² Окладников.А.П, Худяков.Ю.С, Образ война на писаницах Монголий. В.кн. Военное дело древних племен Сибири и Центральной Азии. Новосибирск. 1981.стр.21-29. Монгол Улсын түүх. Тэргүүн боть. УБ.,2004.т.178

³ Базарсүрэн.Ж.Цэрэг гэдэг үгийн гарал, хийгээд Монголын зэвсэгт хүчний үүслийн тухайд. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл.№23(33).УБ.,2017.т.140-142

⁴ Гонгоржав.У, Өлзийбаяр.С.Монголын эртний нүүдэлчид.УБ.,2014.т.89

дэвшилд онцгой ач холбогдолтой байсан. Алсын зайн харвааг эзэмшигчдээс зохих хэмжээний мэдлэг, туршлага, дадал, чадвар шаардаж байсан тул бэлтгэл хийх эрэлт хэрэгцээг бий болгожээ. Энэхүү эрэлт ихсэх тусам нум сумаа боловсронгуй болгох, хүчийг нэмэгдүүлэх, хэрэглэх дадлыг хэвшүүлж байсан нь Монгол нутгаас ихээр олдож буй археологийн олдвороор илэрч буй янз бүрийн хэлбэр хийц бүхий чулуу, яс, хүрэл, төмөр зэвээс харагдаж байна.

Харвах бэлтгэл сургуулийг тогтмол хийх болсон нь цэрэг дайчдыг бэлтгэх сургалтын таатай үндэс бүрдүүлжээ. "Хэнтий аймгийн Батноров сумын нутгаас нум сумаар харваж олон сум шигдсэн зарим зэв сумны ором нүхнүүд бүхий чулуу олдож буй нь үүний нотолгоо юм. А.П.Окладников Их тэнгэрийн амны хадны зургийг судлаад хүрэл зэвсгийн эхэн үед холбогдуулжээ. Хүрлийн үеийн зэв харвалтын дадал сургуулилт нь зохион байгуулалттай тэмцээн наадам, ав хомрог, дайн байлдааны тусгай нум гарах болсон⁵. Чухам эдгээр нь нум сумаар харвах дадал нь байнгын сургалтын шинжтэй болсныг харуулж байна.

Монгол цэрэг дайчдыг сургаж байсан аргууд нь дотроос нум сум харваа нь эртний хүмүүсийн ан хийх, аюулгүй байдлаа хамгаалах хэрэгцээнээс үүдэлтэй юм. Нум сум харвааны шинэ хэлбэр хийцүүд монгол нутгаас ихээр олдож буй нь том дэвшил болсон төдийгүй энэ нь хүн төрөлхтний хөгжлийн түүхэн дэх хамгийн том ололтуудын нэг болсныг харуулж байна. Мөн хүн төрөлхтөн энгийн багаж хэрэгслийг нийлмэл хэрэгсэл болгон өөрчлөх чадвартай болсны илрэл юм.

Эдгээр судалгааны чухал ололт бол цэргийн сургалтын үндсэн арга болон хэрэглэгдэх болсон нум сумаар тулалдах хэлбэр нь хөрш зэргэлдээ орны цэрэг дайчдыг сургах аргад хэрхэн нөлөөлснийг тодруулах боломжийг олгож байна.

Хятад сурвалжид эртний нүүдэлчдээс авч хэрэглэсэн ялангуяа цэрэг дайчдыг сургаж байсан зүйлийн тухай тодорхой

бичсэн мэдээ төдийлөн судлагдаагүй байна. Гэхдээ Хятадын зарим судлаачдын үзэж буйгаар "Хятад бол эрт дээр үеэс олон үндэстэн ястны улс байсан бөгөөд олон мянган жилийн турш үндэсний өөрчлөлт, соёлын давалгаанд өртөж ирсэн. Орчин үеийн дарь зэвсэг гарахаас өмнө хүрэл зэвсгийн эрин үед нум сум нь дайнд шийдвэрлэх зэвсэг байсан. Үүгээр зогсохгүй байт харваа нь эртний Хятадад чухал боловсролын арга хэлбэр, хамгийн их тархалттай, олон оролцогчтой байсан. Хожим нь үзвэр үйлчилгээ болон бусад чиг үүргийг бий болгох үндсийг тавьсан. Мөн эртний Хятадад "буудлага"-тай харвааны олон соёлын системийг бүрдүүлжээ"⁶.

Хятадын археологичдын судалгаагаар эртний Хятадын байт харваа нь эртний харвааны түүхийн эхлэл мөн болохыг нотлох баримт байхгүй байна. Күнз, Даосизм, цэргийн стратегичид бүгд байт харваанд маш их анхаарч, суралцаж байжээ. Энэ хугацаанд нум сум харваа нь цэргийн бэлтгэлийн чухал хэрэгсэл болсноор эрх баригчид өндөр үнэлж дайнд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Цэргийн бэлтгэлийн аргын хувьд "намар буудлага" тэмцээн нь мөн хамгаалалтыг сурталчлахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Тан, Сүн улсууд харвах чадварыг үнэлэх, сургахад ихээхэн анхаарч, ур чадварыг сайжруулах, сургах харьцангуй бүрэн тогтолцоог бий болгож, сур харвааг сургалтын байнгын үйл хэрэг болгосон. Тулааны урлагийн системд байт харваа нь цэргийн авьяас чадварыг сургах үндэс болсон. Байт харваа нь Тан, Сүн гүрний үеийн цэргийн бэлтгэлийн сургалтын гол арга, агуулга болж байв. Мөн тулааны урлагийн систем нь Чин гүрний үед цэцэглэн хөгжиж, нум сум харвах нь сургалтын гол хэлбэр болсон байна. Энэ нь нум, сумны үйлдвэрлэлийн түвшнийг тасралтгүй сайжруулсан. Нийгэм оршин тогтнох үндсэн хэрэгцээг хангахуйц ач холбогдол бүхий байт харваа нь аажмаар цэрэг, наадам, ёс зүй, боловсрол, ардын аман зохиол зэрэг олон чиг үүрэгтэй нийгэм, соёлын хэлбэр болон хувирчээ.

⁵ Гонгоржав.У, Өлзийбаяр.С.Монголын эртний нүүдэлчид.УБ.,2014.т.114-115

⁶ 陈新华.中国古代射箭史研究.2017. <http://cdmd.cnki.com.cn/Article/CDMD-10285-1018084596.htm>



Мянга мянган жилийн турш эртний Хятадын соёл иргэншлийн хөгжилд аажмаар цөм нь болсон байт харваа нь Хятадын эртний сурын харвааны олон соёлт тогтолцооны үндэс болсон" гэж үздэг байна.

Ийнхүү нум сум харваа нь Хятадын цэргийн сургалтын чухал хэлбэрт тооцогдож, суралцан хөгжүүлж байжээ. Гагцхүү түүний эх үндэс ямар нутгаас эх үүсэлтэй болохыг нотлох шаардлагатай.

Манай эртний түүх судлаачид зарим сонирхолтой саналыг дэвшүүлжээ. Тухайлбал Т.Эрдэнэхишиг "Сурвалж, судалгааны зохиолд: "Чжоу улсын У-лин (武灵) ван урьдын зан заншлыг халж, хятадын хөдөлгөөн муутай хүнд морин тэрэгт цэргийг өөрчлөн, хүннү нарын хувцсыг өмсөн, морь унах, нум харвахыг сураад, умар зүгт Линьху, Лоуфань нарыг бут цохисон..."⁷ гэсэн Хятад сурвалжийн мэдээг эш татан тэмдэглэснийг гүнзгийрүүлж судлах хэрэгтэй юм. Мөнхүү археологийн судалгааны үр дүнд нум сумны үүсэл, хөгжил, тархалтыг нотлох олон баримт монгол нутгаас олдож буй нь нум сумны үүсэл, хөгжил эртний монгол нүүдэлчидтэй холбоотой төдийгүй тэдний бүс нутаг болон хөрш зэргэлдээ орнуудын цэргийн сургалтад оруулсан чухал хувь нэмэр болсныг гаргаж болохоор байна.

Дүгнэлт. Цэргийн сургалтын арга нь сургалтын аль нэг тусгай зорилтыг шийдвэрлэх, ямарваа нэгэн зорилтыг хангах, сургалтын агуулгыг боловсронгуй болгох зэрэгт чухал нөлөө үзүүлж ирсэн. Монгол цэргийн сургалт, боловсролын тогтолцоо үүсэн бүрэлдсэн үйл явцыг тэр дундаа цэрэг дайчдыг бэлтгэж ирсэн арга технологийг нарийвчлан судалснаар

тэдний бүс нутгийн хөгжилд оруулсан хувь нэмрийг тодруулахад чухал ач холбогдолтой юм. Монгол нутагт оршин амьдарч байсан нүүдэлчдийн цэргийн сургалтын үндсэн хэлбэрт чухал нөлөө үзүүлэх болсон нум сумаар тулалдах арга нь бүс нутгийн тэр дундаа хөрш зэргэлдээ орны цэргийн сургалтын хэлбэрт ч чухал үүрэгтэй байсныг онцлох хэрэгтэй юм.

Археологичдын үзэж байгаагаар Хятад нутгаас нум сумны үүсэл гарлын уг үндсийг тодруулах баримт хангалттай олдоогүй байсаар байна. Мөн байт харваа нь эртний Хятадад боловсролын чухал арга хэлбэр, хамгийн их тархалттай, олон оролцогчтой байсан бөгөөд хожим нь үзвэр үйлчилгээ, бусад чиг үүргийг бий болгож, эртний Хятадад "буудлага" -тай харвааны олон соёлын системийг бүрдүүлжээ. Хятадын судлаачдын үзсэнээс харахад Монгол дайчдын хэрэглэж байсан нум сум харвааны аргуудаас тэд суралцаж байсан бололтой. Учир нь нүүдэлчдээс авч хэрэглэсэн эсэх сурвалжийн мэдээ тодорхойгүй ч археологийн сурвалжийн мэдээгээр нум сумны үүсэл гарал, тархалт, хөгжлийн үйл явц монгол нутагтай хамааралтай уг үндэс болох нь судалгааны үр дүнгүүдээс тодорхой болж байгаа нь үүнийг нотолно. Ийнхүү цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга болох нум сумаар тулалдах урлагийн үүсэл хөгжил өвөг монголчуудтай холбогдох төдийгүй цэргийн сургалтын голлох арга болон хөгжих үндэс болжээ. Мөн буудлага харвааны сургалтын арга барилын хөгжилд монгол цэрэг дайчдын оруулсан үнэтэй хувь нэмэр гэж үзэж болохоор байна.

Ашигласан материал:

1. Базарсүрэн.Ж.Цэрэг гэдэг үгийн гарал, хийгээд Монголын зэвсэгт хүчний үүслийн тухайд. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл.№23(33).УБ.,2017
2. Гонгоржав.У, Өлзийбаяр.С.Монголын эртний нүүдэлчид.УБ.,2014
3. Монгол Улсын түүх. Тэргүүн боть.УБ.,2004.т.106
4. Т.Эрдэнэхишиг. Хүннү Хан улсын цэрэг улс төрийн харилцаа.УБ.,2021.т.94
5. Окладников.А.П, Худяков.Ю.С, Образ война на писаницах Монголий. В.кн. Военное дело древних племен Сибири и Центральной Азии. Новосибирск. 1981.стр.21-29. Монгол Улсын түүх. Тэргүүн боть.УБ.,2004.т.178
6. 陈新华.中国古代射箭史研究.2017. <http://cdmd.cnki.com.cn/Article/CDMD-10285-1018084596.htm>

⁷ Т.Эрдэнэхишиг. Хүннү Хан улсын цэрэг улс төрийн харилцаа.УБ.,2021.т.94



ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖИЙГ ХАДГАЛЖ ӨВЛҮҮЛЖ ИРСЭН ТҮҮХ УЛАМЖЛАЛ

Ч.СОСОРБАРАМ /Доктор (Ph.D) дэд профессор, бригадын генерал/
Н.ОЮУНДЭЛГЭР /ҮБХИС-ийн АБДС-ийн Нийгэм Хүмүүнлэгийн тэнхимийн багш, магистр/

Түлхүүр үг: Үндэсний ой санамж, түүх, уламжлал, түүх бичлэг

Key words: National memory, history, tradition, historiography

Хураангуй. Ой санамжийн талаар онол, арга зүйн судалгааг эхний бүлэгт дэлгэрэнгүй хийсэн учраас ой санамжийн үндсэн судлагдахуун болох түүх бичлэгт энэ уламжлал хэрхэн туссаныг авч үзнэ.

Хүн төрөлхтний түүх, мэдлэгийн сан хөмрөг, үнэт зүйлс улс үндэстний ой санамжаар дамжин бүрэлдэн тогтож, үеэс үед уламжлагдан хөгжиж, баяжиж, өргөжин тэлж байдаг ажээ.

Хүн төрөлхтний эрт үеийн оюун санааны хөгжил, амьдрах үйл ажиллагаа, хүмүүсийн тухайн үеийн ой санамжийн илэрхийлэл болсон хадан дээрх сүг зураг, чулуун болон бусад зэвсэг, оршуулгын ёс зан үйл, хөшөө дурсгалын хэлбэртэй буюу өнөөдрийн археологийн түүхэн олдворууд байжээ. Эдгээр хөшөө дурсгал дээрх уншигдсан уншигдаагүй олон дүрс, бичиглэлээр тэдний ой дурсамж, санамж ахиж дэвшсээр хулс-папиросон дээр бичиглэл хийх чадвартай болсон нь хүмүүн хэмээх сүүн тэжээлтнийг бусад төрлөөсөө илүү холдон хөгжих явцыг тодорхойлж өгсөн гэлтэй.

Хүн төрөлхтний ой санамж "бичиг үсэг" үүсмэгц бичмэл түүхтэй болсноос үүдэн Ази, Ойрх дорнод, Европт сүм хийд, сургуулиуд байгуулагдаж, архив, номын сангийн хуримтлал бий болох үеэс чанарын шинэ түвшинд хүрч хөгжиж эхэлсэн билээ.

Өнөөгийн бидний уншиж чаддаг болсон бичиг үсэгт тулгуурласан жүүд, библи, кораны судар, буддын, күнзийн сургаал нь шашин, гүн ухааны суртал, сургаал болон дэлгэрч дэвшсээр сүм, дацангийн удам судрын бүртгэл, хаадын түүх цаашлан улс гүрний түүх болон хүн төрөлхтний ой санамжийн суурь үндсийг бий болгосон гэдэгтэй маргах хүн гарахгүй биз ээ.

Хүн төрөлхтөн ерөнхийдөө шударга

ёс, хайр хүндэтгэл, хайр сэтгэлийн талаар нийтлэг адилхан ойлголт, үзэлтэй байдаг нь тэднийг төрүүлсэн ертөнц, хүрээлсэн байгаль, амьдрах орчинтой холбоотой бөгөөд европын сонгодог хөгжим, нүүдэлчдийн хөөмий, Африкийн бөмбөрийн хэмнэлийг газар газрын хүмүүс ихэнхдээ нэг л мэдрэмжээр хүлээн авч таашаал, баясал авдаг билээ. Хүн төрөлхтний дундаас өөр өөр цаг үед амьдарч байсан их сэтгэгчид Аристотель, Платон, Кунз, Бэкон, Кант, Гейгель, Маркс, Неру, зохиолчид Таагүр, Дюма, Бальзак, Достоевский, Толстой, Твен, хөгжмийн их зохиолчид Моцарт, Бетховен, Чайковский нарыг аль ч тивийн ямар ч мэргэжлийн хүмүүс адилхан мэдэрч ойлгож хүлээн авдаг.

Гэхдээ хүн төрөлхтнийг нийтлэг хамтран амьдрах арга, ёс зүй нь газар зүйн онцлог, цаг агаарын өөр өөр байдлаас болж тухайн бүлэг хүмүүст яг адилхан байдаггүй байх нөхцөл шаардлага бодитой байдаг бөгөөд дээр нь тухайн орчинд түгээмэл тархсан шашин, сургаалын нөлөө, амьдарч байгаа газрын хэл ярианы зөрүүгээс болж улс үндэстэн болон хуваагдаж хил хязгаартай, соёлын ялгаа заагтай хөгжиж ирсэн нь жам ёс юм.

Гэхдээ хэвлэлийн машин бүтээгдсэнээр хүн төрөлхтөн оюун санааны мэдлэг мэдээллээ номоор дамжуулан бүгдээрээ харамгүй хуваалцах боломж бий болж, энэ нь өнөөгийн хөгжил дэвшлийн хурдцыг тодорхойлох болов. Ялангуяа шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжил "Даяаршил" хэмээх сайн, муу олон нөлөөтэй үзэгдэлтэй нүүр тулахад хүргэж байна.

Ой санамжийг хүн төрөлхтнөөс эхэлж авч үзэх үү хувь хүний ой санамжаас эхлэх үү? аль анхдагч вэ? гэх асуулт нь



"тахиа өндөг хоёрын аль анхдагч вэ" гэдэгтэй агаар нэг асуудал болох юм. Хүн нийгмийн бүтээгдэхүүн, хүн төрөлхтөн хүнээс бүрддэг... гээд дуусахгүй маргаан гарна.

Ой санамжийг ерөнхийд нь **Бодгалийн (хувь хүний), Хамтын буюу олонлогийн, Улс үндэстний, Хүн төрөлхтний нийтлэг ой санамж** хэмээн судлаачид ангилан авч үзсэн байна.

Бодгалийн (хувь хүний) ой санамжийн түүхэн хэлбэр нь намтар судлалаар голлон илрэх бөгөөд нүүдэлчдийн хувьд удам угсаагаа мэдэх хэлбэр нь долоон үеэ ой санаандаа цээжилсэн-тогтоосон байх явдал байсан бөгөөд христийн сүм хийдүүдийн бүртгэл хүний удам угсааны үндсэн түүх болдог.

Хамтын буюу олонлогийн ой санамжийн гол илэрхийлэл нь байгууллагын түүх (намын түүх бичлэг), аймаг сумын түүх, угсаатны, гэр бүлийн түүх бичлэг бөгөөд сургууль бүр төгсөлтийн ном гаргадаг болсон бол Ерөнхийлөгчийн Тамгын газрын 25 жил, ҮАБЗ-ын 25 жил гэх шинэхэн түүх бичлэг дэлгэрэх болсныг дурдаж болох юм.

Хүний хамтлагийн үндсэн хэлбэр нь гэр бүл, овог аймаг, үндэстэн, ястан, улс үндэстэн бөгөөд тэдгээрийн гишүүн нь байж нийгэмшин аж төрснөөр хүмүүний ой санамж хамтын (олонлогийн) шинж чанарыг шингээн төлөвшдөг байна.


Хүмүүсийн олонлогийн хөгжлийн тусгал нь тэдгээрийн зан заншил, нийгмийн ёс зүй, ёс суртахуун, улмаар төр ёс, хууль цааз, тэдгээрийн түүх билээ.

Хүний олонлог хувьсаж хөгжсөөр **улс, үндэстнүүд төлөвшин** тэдгээрийн түүх, соёл, иргэншил, үнэт зүйлс нь бүрдэж бий болжээ. Ой санамж ч үүнийг даган үндэстний (үндэсний) бөгөөд улам нийлмэл, нарийн шинж төлөвийг олсоор байна. Ой санамжийн төлөвшил, хувьсалд тухайн олонлог (гэр бүл, ургийн бичиг, үндэс угсаа, улс үндэстний түүх гэх мэт) түүх, түүх бичлэг, мөн үнэт зүйлс, уламжлал, туршлага, сургамж (нийгэм, түүхийн, ахуй амьдралын гэх мэт)-ын зүйлүүд чухал нөлөөтэй. Иймээс бидний судалгаанд **түүх ба ой санамж, ой санамж ба үнэт зүйлс** гэх мэт учир шалтгааны уялдаа холбоо чухал байр суурьтай байх болно.

Товчоор хэлэхэд үндэсний хэл, соёл иргэншил, түүх, төрт ёс, хууль цааз, ертөнцийг үзэхүй, шашин шүтлэг, аж төрөх арга ухаан зэргээр үеэс үед уламжлагдан хадгалагдаж иргэн, төр, нийгмийн аж төрөх, оршин тогтнох, хөгжин дэвших арга ухааныг үндэсний ой санамж гэх үндэстэй байна.

Үндэсний эрх ашгийн үүднээс түүхэн үйл явцыг тайлбарлах үйл ажиллагаа "шаардлага" өнөөдөр байсаар байна. Тэгэхээр хүн төрөлхтний болон бусдын түүх

Үндэсний ой санамж





бичлэгээс өөрийнхөө эрх ашгийг ойлгож сугалж авах, нөгөөтэйгүүр түүнд зөв талаас нь өөрийнхөө түүхийг "хэлж өгөх"-оруулах нь их, бага үндэстнүүдийн хувь өнөөгийн цаг үед чухал асуудал хэвээр байсаар байна. Жишээ нь солонгосчууд түүхээ хэрхэн бичиж байгааг бид харж байна.

Бидний судалгааны ажлын зорилго нь төрийн бодлого, үйл ажиллагааны онол, арга зүйн үндсийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх явдал учраас энэхүү судалгаанд **"үндэсний ой санамж"-ыг голлон илэрхийлэгч улс, үндэсний түүхийн асуудлыг** голлон авч үзсэн.

Соёлын үнэт зүйлсийн талаар 2019 онд БСШУЯ-наас томоохон төсөл Соёл урлагийн сургуулиар дамжуулан хэрэгжүүлж тусгайлан санал, зөвлөмж боловсруулсныг бид энэхүү судалгаандаа нийгмийн ой санамж, соёл урлагийн биет болон биет бус өвийн талаар ашиглах болно.

Монголчууд бид нүүдэлчин ард түмний хувьд соёл, уламжлал заншлын баялаг өвөрмөц түүхтэй хүмүүс. Айрагны соёлтой холбоотой зан үйл Сорхон шарын гэрт, Тэмүжиний анхны анд Борохулын элэн дээр яаж болж байсныг XII зуунд яруу сайхан буулгасан "Нууц товчоон" дээр байсантайгаа бараг хэвээрээ "хөхүүртээ айргаа бүлж, таргаа эсгэн ааруул, бяслагаа идэж, бүжиглэж, хуурдаж" амьдарч байгаа онцлогтой ард түмэн бид билээ.

МУ-ын Ерөнхийлөгч асан Н.Багабандийн хэлсэн хөтөл үг¹-нээс жишээ татахад: Ард түмэн түүхээ бүтээдэг гэдэг. Өмнөх үеийнхний түүх, түүний сургамж нь өнөөдрийн ба ирээдүйн түүхийг бүтээгчдийн их багш буюу. Ийм учир бидний өндөр өвөг дээдэс өөрсдийн амьдрал ахуй, үнэмлэмж хүслээ эд өлгийн зүйлс, хадны сүг зургаар ч болов илэрхийлэн, хойч үедээ үлдээж, нийгмийн ой ухааны их өв санг үүсгэн хөгжүүлсэн нь орчин цагийн түүхэнд мэдээллийн чухал эх сурвалж болсоор байна. Хүн төрөлхтөн бичиг үсгийг бүтээн хэрэглэх болсон нь гайхамшигт дэвшил төдийгүй аливаа улс үндэстнүүд өөрсдийнхөө түүх, соёлын нандин өв уламжлалыг нийгмийн ой

ухаанд хадгалан үлдээхэд ач холбогдолтой зүйл болсон билээ.

Үндэсний ой санамжийг монголын түүх бичлэгт туссан уламжлалыг тодруулан гаргахын тулд дараах хэсгүүдэд хуваан авч үзэж судалгаа хийж байна. Үүнд:

1. Үндэсний ой санамж ба түүх бичлэгийн уялдаа холбооны онцлог
2. Монголын эрт үеийн түүх бичлэг дэх үндэсний ой санамжийн асуудал
3. Монголын дунд үеийн түүх бичлэгийн уламжлал монголчуудын язгуур эрх ашиг
4. Монголын орчин үеийн түүх бичлэг ба үндэсний ой санамжийн тусгалын бодит байдал

Монгол судлал, Чингис судлал нь монгол үндэстний төдийгүй дэлхийн түүх, хүн төрөлхтний хөгжил-ой санамжид оруулсан монголчуудын хувь нэмрийн тухай судлах төдийгүй үндэсний ой санамжийг сэргээхэд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа бөгөөд сүүлийн жилүүдэд идэвхжиж байна.

Монголын археологичид, эртний түүх судлаачдын цаашдын чиг хандлага нь археологийн олдворыг олон шинжлэх ухааны бэлчир зангилаан дээр ялангуяа байгалийн шинжлэх ухаан ололтыг ашиглах, археологийн судалгааг бичмэл эх сурвалжтай уялдуулан нотлох, монголчуудын угсаа гарвал, нутагшлыг нарийн тодруулах, эртний түүхийн үе бүрийн тодорхой шалгуур зааг ялгааг тогтоох, өөрөөр хэлбэл Хүннүгийн дараах үеийн улсуудын угсаа, соёлын хамаарал онцлогийг гаргах, Их Монгол улсын үеийг эртний улсуудын залгамж халаа болохыг батлах явдал мөн. Ер нь түүх археологи, хэл соёлын хамтарсан чармайлтыг сүүлийн үеийн судалгаанууд шаардах болжээ.

Дээрхийг эцэст нь дүгнэхэд Монголын эртний түүх археологийн уламжлал бол монгол, төв азиар зогсохгүй хүн төрөлхтний ой санамжийн чухал бүрэлдэхүүн болдгоороо онцлог байдаг. Энэ үйл ажиллагаа дараагийн зуунуудад үргэлжилсээр байх бололтой.

Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүнд байсан улс, үндэстнүүдийн судалгааг

¹ Монгол Улсын Ерөнхийлөгч асан Нацагийн Багабанди 2003 оны тавдугаар сар. Улаанбаатар



гүнзгийрүүлж, 2019 онд Шинжлэх ухааны академийн түүх археологийн хүрээлэн болон МУИС-ын түүхийн багш нар тус тусдаа "Монголын эзэнт гүрний түүх" 5 боть ном хэвлүүлсэн нь Монгол Улсад түүхийн шинжлэх ухааны хөгжил, түүхчдийн чадавх нэмэгдсэнийг харуулсан явдал болсон билээ. Түүхийн хүрээлэн академик-сонгодог байдлаар, их сургууль задгай-чөлөөтэй хэлбэрээр ном хийж өрсөлдсөн нь зөв зүйтэй хэрэг юм. Харин түүхчдийн хоорондын өрсөлдөөн нь тэмцэл, зөрчилд хүрч болохгүй болохыг бас харууллаа.

Манай түүхчид орчин үе, дундад зуун, Чингис хааны үеийн түүхээс дундад зууны буюу чухам өнөө цаг үед сургамжтай бутрал доройтлын үеэ хамгийн бага судалсан нь энэ үеийн түүхэнд монголчуудын хоорондын зөрчил тэмцлийн түүхэн баримтууд олон тохиолддог бөгөөд гүнзгий, бодитой судлах гэсэн түүхчид "үндэсний үзэлтэн" болж хэлмэгддэг аюултай цаг үе саяхан болтол байснаас үүджээ. Монголын дундад зууны үеийн судалгаанд Монголын улс төрийн бутралын үеийн улс төр, нийгэм-эдийн засгийн амьдралыг иж бүрэн харуулсан цогц бүтээл туурвих, Чин улсын Монголд явуулж байсан бодлогыг монгол, манж, хятад, төвд хэлээрх сурвалжийг ашиглан тодорхой цаг үе, газар нутаг, тодорхой үйл явдлыг сонгон авч хөөн судлахад анхаарах, дотоод зөрчил, тэмцэл, зүүн барууны зөрчлийн үндсийг өнөөдрийн Монгол Улсын эрх ашгийн үүднээс тайлбарлах талаар төрийн бодлогын чиглэл байх нь зүйтэй.

Монголын ойрх үеийн судалгаанд хамгийн их орхигдсон 1950-1980 аад оны түүхэн үйл явдлын судалгааг даруй эрчимжүүлэх нь тулгамдсан зорилт юм. Учир нь энэ үеийн нам, төрийн баримт бичгүүд багагүй улс төржсөн байдаг бөгөөд иймд түүнийг залруулахын тулд тухайн цагийн үйл явдалд шууд оролцож, хийж бүтээж ирсэн ахмад үеийнхэн эдүгээ амьд сэрүүн байгаа дээр аман түүхийн судалгааг далайцтай хийх хэрэгтэй байна.

1990 оны үйл явдалтай холбоотой иргэд, судлаачид болон, түүхийн судалгааны бүтээлүүд гарч эхэлж байгааг дээр дурдсан. Гэхдээ олон талаас нь харсан түүх бичлэгийн шаардлага хангасан бүтээл төрийн ой санамж, сургамж талаасаа нэн хэрэгтэй байгааг өнөөгийн намуудын төлөвшил шаардаж байна.

Мөн орон нутаг аймаг, сумдын түүхүүд шинэчлэгдэн бичигдэх болсон бөгөөд эдгээрийг нэгтгэн дүгнэдэг боловсруулдаг үйл ажиллагаа тулгамдаж байна.

Монгол угсаатны түүх, шашны түүхийг судлахдаа улс үндэстний аюулгүй байдал, батлан хамгаалах төрийн бодлоготой холбож судлах нүүдэлчдийн төрийн бодлого, ахуй амьдралаас урган гарч байгааг хэрэгжүүлэх шаардлага байна.

Эдүгээ Монголын түүх бичлэгийн шинэчлэлийн талаар: ...түүхийн ухаан ялангуяа Монголын түүхийн судалгаа, түүх бичлэгийн тухайд түүхэн матерлизм төдийгүй шинэ онол-арга зүйн шинэ хандлагыг хайж монгол хөрсөнд суулгах шаардлага тулгарч байгааг болон "Монголын түүхчид ... онолын уйгагүй эрэлхийлэл хийж, нийгэм түүхийн бодит шалтгаанаар хөллөсөн жам ёсны үйл явц, түүхийн дотоод чанадыг нээн харуулах шаардлага" тулгарч байгааг эрдэмтэд судлаачид тэмдэглэх болжээ. Зарим түүх судлаачид түүх бичлэг, түүхийн боловсролын сургалтын чухлыг тэмдэглэх болсон. Тухайлбал "Түүхийн сургалт боловсролын явцад суралцагчдад хүн төрөлхтний түүхэн туршлага, үнэт зүйл, нийгмийн үзэл санааг тэдний танин мэдэхүй, үйл хөдлөл, биеэ авч явахуйн дотоод хөдөлгөгч хүч буюу эерэг үйлдэлд нь өдөөгч, сөрөг үйлдлээс нь татгалзуулагч болгон хувиргахуй нь мэдлэгийг дотоод үйл болгох жамаар хэрэгжвэл тэдгээр мэдлэг, үнэт зүйл нь тухайн хүний хувийн үнэт зүйл болж чадах билээ. Ийм замаар бие хүнд эх оронч үзлийг төлөвшүүлж чадахаас даяарчлагдаж буй эринд үндэсний түүх соёлоо аварч үлдэж чадах билээ"² гэжээ.

Ерөнхийдөө 1990 оноос хойш Монголын түүхийн үндсэн үеүдийн

² Х.Орхончимэг. Түүхийн боловсролын уламжлал шинэчлэлийн зарим асуудалд. ҮБХИС-ийн АБС. Эрдэм шинжилгээний бичиг. Сэтгүүл.№4.УБ.,2018.т.30



судалгаанаас гадна салбар, хавсарга шинжлэх ухааны чиглэлээр олон арван бүтээл гарч хөгжлийн замдаа оржээ гэж үзэж болох боловч түүнийг төрийн бодлогоор хангах асуудал байсаар байна. Монголын түүхчдийн холбооны үйл ажиллагааг тогтмолжуулж, төр, ШУ, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах энэ үйл хэрэгт Соёлын яамны оролцоо, чадвар өндөр байх ёстой.

Энэ хэрэг явдал төрийн үүрэг ялангуяа ҮАБЗ-ийн түүх уламжлалын чиглэлээр бодлогын чиглэл, зөвлөгөө өгдөг боломж, чадавхтай байх явдал тулгамдсан асуудал болохыг цаг үе харуулсаар байна.

Энэ нь үндэсний ой санамж, үндэсний үнэт зүйлсийг тодорхойлох үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, ҮАБЗ-ийн тэргүүний оролцоо өндөр байх шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Ашигласан материал:

1. Бира. Ш. Монголын түүх соёл, түүх бичлэгийн судалгаа. III боть.УБ.,2001.т.148. Жамбалдорж.Т.Монголын түүх бичлэг.УБ.,2015.
2. Х.Пэрлээ. Эртний Монголчуудын нүүдэлч соёл иргэншлийн түүхийн зарим асуудал / докторын зэрэг горилогчийн холбогдох материал/ ШУА-ийн Түүхийн хүрээлэн. Түүхийн баримтын сан. Ф-6,ХН.118.
3. Сумьяабаатар Б., Монголын нууц товчоо,УБ., 1990.
4. Цэрэнсодном Д., Монголын нууц товчооны орчуулга, тайлбар, Бээжин, 1993.
5. Элдэндэй, Ардаажав, Монголын нууц товчооны сийрүүлэл, тайлбар, Хөх хот, 1986.

МАХЦ-ИЙГ ӨРГӨТГӨН ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР МАРШАЛ Г.ДЭМИДИЙН УДИРДАН ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Н.НАРАНХҮҮ /БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвийн ЭША, хошууч /

Түлхүүр үг: Боловсон хүчин, сургалт, цэрэг-техник

Key words: Personnel, training, military-technical

Оршил. Маршал Г.Дэмид бол дотоодын эсэргүү бослого, баруун хил хязгаарт халдан довтолсон хасагийн дээрэмчид, Япон, Манжгогийн цэргийн зэвсэгт өдөөн хатгалгыг няцаан бут цохих байлдааны ажиллагааг амжилттай удирдаж ялалтад хүргэсэн цэргийн нэрт зүтгэлтэн хүн байсан. Тэрээр амьдралынхаа эцсийн мөчийг хүртэл Монгол Улсынхаа тусгаар тогтнол, бие даасан байдал, батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэхийн төлөө бүхий л хүч чадал, эрдэм мэдлэгээ зориулан ажилласан байдаг. Ялангуяа улсыг батлан хамгаалах бодлого, тухайн үеийн МАХЦ-ийн бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчин, улс төр, зэвсэглэл техник, цэргийн эрх зүй, сахилга, цэргийн сургалт бэлтгэл, түүний чанарын түвшин, цэргийн алба хаагчдын эрүүл мэнд, ар тал, ахуй хангалт зэрэгт онцгой анхаарал хандуулан ажиллаж байжээ. Өөрөөр хэлбэл тухайн үедээ Монгол Улсын гол холбоотон улс байсан дэлхийн хүчирхэг гүрний нэг Зөвлөлтийн Улаан армийн туршлагад тулгуурлан шинэчилж, гэхдээ монгол орны онцлог, байгаль цаг уурын өвөрмөц нөхцөлд тохируулан хөгжүүлэх, цэргийн урлагийн үндсийг боловсруулах, дүрмүүдийг боловсронгуй болгох, байлдааны бэлэн байдал, байлдах чадварыг дээшлүүлэх, цэргийн боловсон хүчин бэлтгэх, шинэ зэвсэг техник эзэмшүүлэх, цэргийн албыг зохион байгуулах, байлдааны ажиллагааг удирдах урлагт дарга нарыг сургах, эрүүл мэндийн болон ар тал ахуй хангалтыг сайжруулахад эрдэм мэдлэг авьяас чадвараа зориулсан билээ.

Маршал Г.Дэмидийн санаачилга шийдвэрээр МАХЦ-т зохион байгуулалтын өөрчлөлт хийж, байлдааны үндсэн нэгжүүд болох хороо, дивиз, корпусын

зохион байгуулалтад оруулан их буу, хуягт танк, холбооны хороо болон нисэх, хуягт бригад зэрэг төрөл мэргэжлийн ангиудыг шинээр байгуулжээ. Морьт цэргийг механикжуулах бодлого нь хуягт танк, нисэх онгоц, их буу, пулемёт, автомашин зэрэг орчин үеийн зэвсгээр зэвсэглэх, холбоо, хими, инженерийн техник хэрэгслээр хангах, цаашид төрөл мэргэжлийн ангиудыг шинээр буй болгоход чиглэж байсан.



1 дүгээр зураг МАХЦ-ийн хуягт бригад

1930-аад оны үеэс олон улсын байдал хурцдаж, тус улсын хил хязгаар түгшүүртэй болсон зэргээс үүдэн МАХЦ-ийг өргөтгөж эхэлсэн нь анги нэгтгэлүүдийг мэдлэг боловсрол сайтай, техникийн бэлтгэлтэй даргалах бүрэлдэхүүнээр хангахыг шаардсан юм¹. Ийм ч учраас Г.Дэмид тухайн үеийнхээ цэргийн тэргүүний онол, техникийн түвшинд МАХЦ-ийг байгуулах явдлыг голлон анхаарч "Бүх дэлхий дээр дэлгэрч гарч буй ямар ч улсын доторх оюун, техникээс манай улаан цэрэг хожимдож хоцорвоос цэрэг гэж тоолж, цэрэг гэж дайсны өмнөөс тэмцэхэд бэрхтэй"² гэж удаа дараа тэмдэглэж байв.

Тухайн үед дарга, улс төрийн ажилтнуудын цэрэг, техникийн мэдлэг байлдааны ажиллагааг удирдах дадлага чадварыг нэмэгдүүлэх талаар олон талт

¹ "Хорьдугаар зууны монгол цэрэг" /БХЭШХ/ УБ., 2001.

² "БНМАУ-ын ҮИ их хурлын илтгэл, тогтоол", УБ., 1934.



арга хэмжээнүүдийг авч явуулав. 1933 онд БНМАУ-ын Хувьсгалт Цэргийн Зөвлөлөөс "Байлдааны бэлтгэл сургуулийн тухай" тусгай тогтоол цэргийн дарга нарын байлдааны бэлтгэлийг өөрчлөн байгуулах шийдвэр гаргажээ. Байлдааны бэлтгэлийн гол зорилтыг тодорхойлохдоо: "...эдүгээ цагийн байлдаанд цэргийг удирдах нарийн арга маягийг дүүрэн мэдэх ба морьт цэргийн штабаас их буу, хуягт анги, нисэх онгоцны зэрэг тусгай төрлийн цэргийн штабууд лугаа харилцан ажиллах явдалд хатуу дадлыг олгох хийгээд олон төрлийн цэргийн харилцах байлдах төлөвлөх арга маягийг хатуу чанга сурах эдгээр зорилгыг биелүүлэх" явдал гэж заасан³.



2 дугаар зураг МАХЦ-ийн нисэх хүчин

Өөрөөр хэлбэл МАХЦ-ийн бүх шатны даргалах бүрэлдэхүүнд байлдааны ажиллагаанд цэргийг удирдах ба техник цэрэгтэй харилцан ажиллах дадлага туршлагатай болох, байлдааны тактиктэй болох гэсэн үндсэн шаардлагыг тавьж байсан юм⁴.

1934 оны 10 дугаар сард гаргасан Бүх цэргийн жанжны бз тоот тушаалд "Үндэсний хувьсгалт улаан цэрэг нь



3 дугаар зураг МАХЦ-ийн удирдах бүрэлдэхүүний буудлагын бэлтгэл



4 дүгээр зураг. МАХЦ-ийн их буучид

ялангуяа сүүлийн хэдэн жилийн дотор өөрийн үндэсний боловсронгуй дарга, улс төрийн ажилтан⁵-аар нэмэгдэн өсч байлдааны ба улс төрийн бэлтгэлийг дээд шатнаа гаргаж, шинэ зэвсэг техникээр зэвсэглэж, монгол ард улсын гавшгай бат хэрэм хамгаалалт болж чадсан бөгөөд өнөө үед манай олон дарга, улс төрийн ажилчид нь өөрийн ажил хэргийг сургагчгүйгээр өөрсдөө ажиллаж чадах бүхий нэгэн гавьяа нь манай олон дарга, улс төрийн ажилчид нь өөрийнхөө ажил хэрэгт Холбоот улсаас уригдаж ирсэн эрдэмтэн сургагч⁶ нөхдийн зөв тусламж зөвлөгөөнийг авч, ажил хэрэг дээрээ үнэн идэвх чармайлтыг гарган ажиллаж суралцсаны үрээр өнөө ийнхүү

³ Батлан хамгаалахын төв архив. ф.4, т.2, хн.8, т.160

⁴ Эрдэм шинжилгээний өгүүлэл. №4, УБ., 1987. т.44

⁵ МАХЦ нь бүх шатны удирдах боловсон хүчнээр хангагдахын хамт удирдлагын бүх шатанд нэгтгэн захирах ёсыг тогтоох үүднээс 1931 онд тогтоосон бүрэлдэхүүний цол, дүрэмт хувцасыг өөрчилж, 1936 он -ы 2 дугаар сарын 21-нд хуралдсан БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчид ба Ардын Сайд нарын зөвлөлийн гишүүдийн хамтарсан XIV хурлаас: "БНМАУ-ын өрлөг жанжин" Маршал гэх цэргийн алдар цолыг баталж, цэргийн дарга нарт дэслэгч, ахлах дэслэгч, ахмад, хошууч, хурандаа, корпус, дивиз, бригад командлан захирагч, дэслэгч жанжин цол, Улс төрийн ажилтан нарт улс төрийн удирдагч, улс төрийн ахлах удирдагч, хороо, бригад, дивиз, корпусын комиссар, цэргийн ерөнхий комиссар цол, Техник, аж ахуй, шүүх /прокурор/, хүн, мал эмнэлгийн албан тушаалтанд дээрх цолтой дүйцэхүйц инженер, мэдэгч, шүүгч, хянагч, эмч зэрэг цол олгох тухай "МАХЦ-ийн дарга, улс төрийн ажилтан нарт алдар цол олгох" тогтоол батлагдаж байв.

"Монгол ардын хувьсгалт цэргийн түүхэнд холбогдох баримт бичгүүд" /1921-1945/, УБ. 1974. т.343-347

⁶ 1930-аад оны эхээр МАХЦ-т цэрэг, нам улс төр, ар тал, нисэх, хүн малын эмч, авто хуягт танк, холбоо, артиллер, инженер,, морин цэрэг, байр зүй, барилгагжим зэрэг цэргийн 17 мэргэжлээр 54 албан тушаалд улаан армийн 150 гаруй сургагч ажиллаж байв. "Батлан хамгаалахын төв архив" ф.1, т.3, хн.226, т.17



богино хугацааны дотроо үртэй амжилт олж, өөрийн шинэ хүчнээр элбэгжиж чадваржсан хэмээн тэмдэглэнэ..."⁷ гэжээ.

Цаашид МАХН-ийн Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1936 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар улсыг батлан хамгаалах хүчийг зузаатгах тухай Г.Дэмидийн тавьсан илтгэлийг хэлэлцэж сайшаагаад цэргийн тоог нэмэгдүүлж, тэдний байлдааны болон улс төрийн бэлтгэлийг дээшлүүлэн, шинэ техникээр зэвсэглэх, цэргийн зохион байгуулалтыг өргөтгөх заалт өгсөн байдаг.

БНМАУ-ын Засгийн газар 1936-1937 онд улс орны Батлан хамгаалах хүчийг цаашид зузаатгах талаар ихээхэн арга хэмжээ авав. МАХЦ-ийн зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, корпусын системийг өөрчлөн дивизийг биеэ даасан нэгтгэл болгож шинэ төрлийн анги, нэгтгэлүүдийг байгуулсан бөгөөд удирдах болон техникийн боловсон хүчнээр цэргийн ангиудыг бэхжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн түүхтэй⁸.

Г.Дэмид 1936 онд бичсэн өгүүлэлдээ: "...Энэ 15 жилийн дотор монголын үндэсний хувьсгалт цэрэг нь байлдааны ба улс төрийн ухвар мэдрэл хийгээд боловсролын талаар ихээхэн дэвшиж

чадсан төдийгүй боловсронгуй сайн чанарын техник зэвсгээр зэвсэглэн түүнээ дүүрнээр хэрэглэж чадах сурлага мэргэжилтэй болжээ..."⁹ гэж үнэлсэн.

Түүний удирдан хэрэгжүүлсэн цэргийн шинэчлэлийн бодлого амжилттай явагдаж байсан нь дараа дараагийн болсон үйл явдлууд тодорхой харуулсан билээ.

Тэрээр механикжуулсан морьт цэрэг бүхий хөдөлгөөнт нэгтгэлүүдийн үүргийг зөв ойлгож байсан нь 1936 оны 2 дугаар сарын 12-ны өдөр Булан дэрсний харуулд, мөн оны 3 дугаар сарын 29-31-ний өдөр Адаг дулааны районоор халдан довтолсон Япон, Манжийн цэргийн түрэмгийллийн эсрэг явуулсан байлдааны ажиллагааны утга санаанд тод илрэн гарсан. Өөрөөр хэлбэл нисэх онгоцоор дэмжүүлсэн МАХЦ болон хязгаарын цэргийн анги салбаруудын морьт цэрэг, хуягт, их буу бүхий төрөл мэргэжлийн цэргийн харилцан ажиллагаагаар цагийн байдлын нарийн төвөгтэй нөхцөлд үр ашигтай хориглон, нисэх онгоцны дайралт, их бууны оновчтой галаар дайсны давуу хүчний давшилтыг амжилттай няцаан улмаар давших байлдаан хийж, дайсанд хатуу цохилт өгч улсын хилээс хөөн гаргасан юм¹⁰.

⁷ "МАХЦ-ийн түүхэнд холбогдох баримт бичгүүд" /1921-1945/ УБ., 1974. т.226-227

⁸ Дэмид.Г., "Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг" /1930-1937/ /Цэргийн түүхийн хүрээлэн/ УБ., 1991. т.9

⁹ Дэмид. Г., "МАХН ба Ардын хувьсгалт цэрэг" өгүүлэл, "Үнэн" сонин, №27, 1936.2.21-нд нийтлэгдсэн.

¹⁰ "БНМАУ-ын хязгаарын цэргийн түүхэн замнал" /Хязгаарын ба Дотоодын цэргийн түүхэн замнал/ УБ., 1972. т.79

¹¹ М.Н.Тухачевский 1893 оны 2 дугаар сарын 16-нд Смонленск мужид төржээ. 1918 оны 4 дүгээр сард Оросын коммунист намд элссэн бөгөөд улаан армийн эгнээнд орж Дорнод фронтын 5, 1 дүгээр арми, Кавказын болон Баруун фронтын командлагчаар томилогдон ажиллаж улаан армийг шийдвэрлэх ялалтанд хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Иргэний дайны үед гадаад, дотоодын дайсны эсрэг арми, фронт командлан гавьяа байгуулсан учир "Улаан туг"-ийн одонгоор шагнагджээ. Тэрээр дайны дараа цэргийн тойрог командалж, М.В.Фрунзээр толгойлуулсан Ажилчин тариачны улаан армийн шинэ штабт, Б.М.Шапошников /хожим ЗХУ-ын маршал, Улаан армийн жанжин штабын дарга болсон/-ын хамт туслах, 1930-аад оны үед Батлан хамгаалах ардын комиссарын 1 дүгээр орлогчоор ажиллаж, орчин үеийн шинэ арми байгуулахад их үүрэг гүйцэтгэжээ. "Советская военная энциклопедия" /Военное издательство министерства обороны СССР/ М., 1980. стр.151

Тэрээр цэргийн том онолчдын нэг бөгөөд "Орчин үеийн стратегийн асуудлууд" (1926), "Морьт цэргийн байлдааны дүрэм"(1931), "Маневр ба артиллер", "Явган цэргийн байлдаан", "Манай сургууль-тактикийн зорилтууд" зэрэг ном бичиж, Жанжин штабын академи болон бусад цэргийн сургуулиудад оператив-стратегийн гэх чухал хичээлүүдийг заадаг байв. "ru. Wikipedia. org"

Түүний тухай ЗХУ-ын маршал Г.К.Жуков дуртгалдаа: "Орчин үеийн дайнд Зөвлөлтийн Зэвсэгт хүчний янз бүрийн төрөл чухам ямар роль гүйцэтгэхийг сайн мэдсэн, ямар ч асуудалд бүтээлчээр хандаж чаддаг хүн байлаа. Стратеги, тактикийн асуудлаар хийх зарчмын бүх дүгнэлтээ Зөвлөлтийн болон гадаад орнуудын шинжлэх ухаан, техникийн өрнүүн хөгжил дээр тулгуурлаж үндэслэдэг, энэ байдал нь зэвсэгт хүчнийг зохион байгуулах, ирээдүйн дайныг явуулах аргад шийдвэрлэх нөлөө үзүүлнэ гэдгийг онцлон тэмдэглэдэг байв. Хожим хэвлүүлсэн зохиолуудаа Герман, агаар, кесантын мөн түргэн хөдөлгөөнт хүчирхэг цэргээс, гол төлөв механикжуулсан ба хуягт танкийн хүчнээс бүрдсэн хамтын довтолох хүчтэй арми бэлтгэж байна" гэж тэмдэглэсэн. Жуков.Г.К., /Зөвлөлт Холбоот Улсын маршал/, "Дуртгал, бодол" УБ., 1977. т.130-131

Тэрээр ЗХУ-ын маршал Тухачевский¹¹, В.К.Блюхер¹² нарын баримталж байсан орчин үеийн армийн тухай үзэл баримтлал, цэргийн номлолыг тууштай баримтлагч, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө тэмцэж байсан цэргийн зүтгэлтэн байв.

Г.Дэмидийн үйл ажиллагааг Дарьзав, Ж.Малж, Самбуу, Өлзийбат, Т.Дашзэвэг, Г.Дамба нарын зэрэг МАХЦ-ийн дээд тушаалын дарга нар идэвхтэй дэмжиж байсан¹³ бөгөөд МАХЦ-ийг орчин үеийн зэвсэг, техникийн үндсэн дээр өөрчлөн зохион байгуулахын төлөө хүчин зүтгэсэн бөгөөд түүний санаачилгын дагуу нам, засгаас авсан арга хэмжээний үрээр МАХЦ-ийн бие бүрэлдэхүүнд техникийн цэргийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлж шинээр их бууны хороо, холбооны хороо, хуягтын тусгай хороодыг бие даалган байгуулсан бөгөөд 1936 оныг 1930 онтой харьцуулбал хуягт машин 20 дахин, ачааны машин 17 дахин, нисэх онгоц 4 дахин, пулемёт 1 дахин, их буу 6 дахин нэмэгдсэн¹⁴ байдаг.

Дүгнэлт. 1930-аад оны эхээр Зөвлөлтийн Улаан армийн морьт дивиз дөрвөн морьт, нэг механикжуулсан /БТ-5 танкаар зэвсэглэсэн/, артиллерийн нэг хороотой, морьт хороо сэлэмт суман дөрөв, пулемёт суман нэг, хорооны батарей, АДЭХ тусгай салаа, химийн тусгай салаа¹⁵-тай байсан бол 1934-1935 оны байдлаар МАХЦ-ийн 7 дугаар морьт дивизийн бүтэц, зохион байгуулалтыг авч үзэхэд хоёр морьт хороо, их бууны хороо

/37мм-ийн танк эсэргүүцэх их буу М1930 (1-К)/, моторт хороо нь хуягтын суман хоёр /хөнгөн хуягт ФАИ, дунд хуягт БА-3/, моторт их бууны батарей нэг, моторт пулемёт суман нэг, буудлагын суман хоёр, тагнуулын салаа, ажлын команд, холбоо салаатай¹⁶, харин морьт хороо нь байлдааны орон тоогоор сэлэмт суман дөрөв, пулемёт суман нэг, холбооны салаа, агаарын дайсан эсэргүүцэх салаа, танк эсэргүүцэх салаа, химийн тасгаас бүрдэж байв¹⁷. 1937 онд морьт дивизүүдийн их бууны хороог их бууны дивизион, моторт хороог хуягт дивизион болгон өөрчлөн зохион байгуулсан. Ийнхүү МАХЦ нь түүний зохион байгуулалтын шинж чанар, байлдаан хийх аргыг ихэд өөрчилсөн зэвсэг, техникээр зэвсэглэсэн юм.

Г.Дэмид МАХЦ-ийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд Монгол цэргийн түүхэн уламжлал, тухайн үеийн Зөвлөлтийн Улаан армийн хөгжилтэй ойртуулсны дээр зохион байгуулалтын олон асуудлыг онол, практикийн талаас шийдвэрлэсэн бөгөөд зэвсэгт хүчний цаашдын хөгжлийн нүүр царай, дүр төрх, хөгжлийн чиг хандлагын үндэс суурь бүрэлдэн төлөвших үндэс суурийг тавьж, доктор С.Ганболд абугайн хэлснээр тухайн үеийн боломж нөхцөлд тохирсон "техникжсэн морьт цэрэг"¹⁸ буюу механикжсан морьт цэргийг байгуулахад жинтэй хувь нэмэр оруулсан билээ.

¹²Блюхер, Василий Константинович (1889-1938) Зөвлөлтийн цэрэг, төр, намын удирдагч; ЗХУ-ын маршал (1935). Ярославль мужийн Рыбинск дүүргийн Барщенка тосгонд төрсөн. Дэлхийн I дайн ба Иргэний дайнд оролцсон, Хасан нуурын дэргэд Японы армийн эсрэг тулалдаанд Улаан армийг удирдан оролцсон. 1924-1927 онд. Чан Кайшигийн цэргийн ахлах зөвлөхийн албан тушаалд оролцсон. 1927-1929 онд. Украины цэргийн тойргийн командлагчийн туслах. 1929 оноос хойш Алс Дорнодын тусгай армийн командлагч. 1938 оны 10 дугаар сарын 22-нд Улаан армийн хэлмэгдүүлэлтийн үеэр баривчлагдсан. 1938 оны 11 дүгээр сарын 9-нд тэрээр Лефортово (Москва) шоронд нас барсан. 1939 оны 3 дугаар сарын 10-нд нас барсны дараа маршалын цолыг "буцаж" хасаж, "Японы талд тагнуул хийсэн", "Зөвлөлтийн эсрэг зохион байгуулалтад оролцсон, цэргийн хуйвалдаанд оролцсон" хэргээр цаазаар авах ял оноов. 1956 онд түүнийг нөхөн сэргээсэн.

¹³Ариунболд, А. "Нармай монгол-изм /Панмонголизм/-ын хэрэгт хэлмэгдсэн монголчууд" /1937-1941/ УБ., 2012. т.37

¹⁴"Монголын ардын арми 50 жил" УБ., 1971, т.12

¹⁵Жуков, Г.К., /Зөвлөлт Холбоот Улсын маршал/, "Дуртгал, бодол" УБ., 1977. т.131

¹⁶Хүдэрбат, Н. "Байшинтын 7 дугаар морьт дивизийн түүх" /1932-1945/ УБ, 2020., т.13

¹⁷"Эрдэм шинжилгээний өгүүлэл" №7, "Цэргийн түүхийн хүрээлэн" УБ., 1990. т.27

¹⁸С.Ганболд. "Төр цэргийн гарамгай зүтгэлтэн Гэлэгдоржийн Дэмид" /Монгол Улсын төр, цэргийн гарамгай зүтгэлтэн Гэлэгдоржийн Дэмид/ БХЭШХ /Монгол

**Ашигласан материал:**

1. Монгол Улсын Батлан Хамгаалахын Их Сургууль, УБ., 2001
2. "Үнэн" 1937.10.18, №117
3. "Хорьдугаар зууны монгол цэрэг" /БХЭШХ/ УБ., 2001
4. Батлан хамгаалахын төв архив. ф.4, т.2, хн.8
5. Эрдэм шинжилгээний өгүүлэл. №4, УБ., 1987
6. "БНМАУ-ын VII их хурлын илтгэл, тогтоол", УБ., 1934
7. Монгол ардын хувьсгалт цэргийн түүхэнд холбогдох баримт бичгүүд" /1921-1945/, УБ. 1974,
8. Батлан хамгаалахын төв архив. Сх.1, т.3, хн.226
9. "МАХЦ-ийн түүхэнд холбогдох баримт бичгүүд" /1921-1945/ УБ., 1974
10. Дэмид.Г., "Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг" /1930-1937/ /Цэргийн түүхийн хүрээлэн/ УБ., 1991
11. Дэмид. Г., "МАХН ба Ардын хувьсгалт цэрэг" өгүүлэл, "Үнэн" сонин, №27, 1936
12. "БНМАУ-ын хязгаарын цэргийн түүхэн замнал" /Хязгаарын ба Дотоодын цэргийн түүхэн замнал/ УБ., 1972
13. НТА ф.1, т.5, хн.178
14. Жуков.Г.К., /Зөвлөлт Холбоот Улсын маршал/, "Дуртгал, бодол" УБ., 1977
15. Ариунболд.А., "Нармай монгол-изм /Панмонголизм/-ын хэрэгт хэлмэгдсэн монголчууд" /1937-1941/ УБ., 2012
16. "Монголын ардын арми 50 жил" УБ., 1971
17. Хүдэрбат.Н., "Байшинтын 7 дугаар морьт дивизийн түүх" /1932-1945/ УБ, 2020
18. "Эрдэм шинжилгээний өгүүлэл" №7, "Цэргийн түүхийн хүрээлэн" УБ., 1990
19. Ганболд.С., "Төр цэргийн гарамгай зүтгэлтэн Гэлэгдоржийн Дэмид" /Монгол Улсын төр, цэргийн гарамгай зүтгэлтэн Гэлэгдоржийн Дэмид/ БХЭШХ /Монгол Улсын маршал Гэлэгдоржийн Дэмидийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал/ УБ., 2001
20. "Советская военная энциклопедия" /Военное издательство министерства обороны СССР/ М., 1980



ЮАНЬ ГҮРНИЙ ЦЭРГИЙН ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ НЭГЭН ЯПОН ХЭЛЦИЙН УЧИР

О.ГЭРЭЛМАА /УБХИС-ийн Гадаад хэлний сургалтын төвийн багш/
Т.ЭРДЭНЭХИШИГ /БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн
ЭШТА, доктор (Ph.D), профессор/

Түлхүүр үг: Юань гүрэн, Хубилай хаан, Юань гүрний усч цэрэг, "Мүкүри Кокури" хэлц үг
Key words: Yuan dynasty, Kubilai khan, Yuan sailors, "Mukuri Kokuri" idiom

Хураангуй: Эрт цагт 13-р зууны үед Японд хүүхэд уйлахад "Монгол, солонгос чөтгөр ирлээ" /蒙古高句麗の鬼が来る/ (Mo:ko ko:kuri no oni ga kuru) гэж хэлэн эмээлгэдэг байжээ. Энэхүү хэлц үг нь Хубилай хааны монгол, солонгос зэрэг олон үндэстний усч цэрэг 1274 болон 1281 онд Япон руу довтолсон түүхэн үйл явдлаас үүдэлтэй ажээ. Дээрх хэлц үгийг товчлон хурааж япончууд "Мүкүри Кокури" /むくりこくり/ гэж хэлэх нь ч бий.

"Мүкүри Кокури" хэлц үгийн "Мүкүри" нь Монголыг, "Кокури" нь Солонгосыг хэлдэг байна. Японы зарим нутагт "Мооко ирнэ шүү" гэж хэлдэг байна. "Мүкүри Кокури" хэлц үгийн утга аажмаар анхны утгаасаа холдон хийсвэрлэгдэж орчин цагийн япон хэлэнд ямар нэг аймшигтай, ёс бус зүйлийн илэрхийлэл болон хэлэгдэх болсон байна.

"Мүкүри Кокури" - хэлцтэй холбоотой сэтгэлгээ нь япон соёл, зан ахуйд тусгалаа олсон байна. Тухайлбал Кюүшюүгийн Икино аралд "Мүкүри Кокури хүүхэлдэй" гэдэг тоглоом урладаг байжээ. Аомори мужийн Кизүкүри хотод "Мооко но комори ута" гэдэг ардын дууг ам дамжин дуулж ирсэн байдаг бөгөөд түүнд "Уйлвал уулнаас Мооко ирнэ шүү, битгий уйлаарай" хэмээн эртний монгол шюүрай буюу довтлогчийн аймшиг сүрийг хүүхдийн дру болгон дуулдаг байжээ. "Мооко ирнэ шүү" хэлц үг нь энэ цагийн Японы ахмад үеийнхэнд амаар дамжин уламжлагдан иржээ.

Оршил: Хэлц үг нь /idiom/ ард түмний мянга мянган жилийн сэтгэлгээ, түүх соёлын хөгжлийн үр дүнд буй болж хэвшсэн хэлний гүн утгат өвөрмөц

нэгж юм. Эрдэмтэн Ж.Баянсан "хэлц үг үүсэхдээ хэлний үгийн сангийн бэлэн нэгж, түүнийг холбож нийлмэл дохио үүсгэх хэл зүйн бэлэн загварыг ашигладаг ч дүр дүрслэлийг сэдлийн үндэс болгодгоороо өвөрмөц" гэжээ. Иймээс хэлэнд хэлц үг үүссэн сэтгэлгээ, түүх, бүтсэн ур маягийг судалж үзэх нь хэлний гүн бүтцийн чухал асуудал юм.

Үндсэн хэсэг: Хубилай хаан 1260 онд хаан сууснаасаа хойш өмнөх хаадын адил газар нутгийн хэмжээг өргөтгөн тэлэх бодлогыг баримталж байв. Хубилай хаан Өмнөд Сүн улс, Солонгосыг эрхшээлдээ оруулаад зогссонгүй далай тэнгисээр хүрээлэгдсэн арлын орон Японыг эрхшээн захирахыг хүсч олон удаа элч илгээж байжээ. Хубилай хаан 1268-1274 оны хооронд Японд хэд хэдэн удаа элч илгээсэн ч хариу эс авсан учир дайнд шуурхайлан бэлтгэж, Юань улсын усч цэрэг 1274, 1281 онд Япон руу довтолсон билээ. Юань гүрний үед Хубилай хааны усч цэргийн довтолгоо дэлхийн цэргийн түүхэнд төдийгүй япон хэл, соёлд ч тодхон ул мөрөө үлдээжээ.

Эрт цагт, тодорхой хэлбэл 13-р зууны үед Японд хүүхэд уйлахад "Монгол, солонгос чөтгөр ирлээ" /蒙古高句麗の鬼が来る/ (Mo:ko ko:kuri no oni ga kuru) гэж хэлэн эмээлгэдэг байжээ. Дээрх хэлц үгийг товчлон хурааж япончууд "Мүкүри Кокури" /むくりこくり/ гэж хэлэх нь ч бий.

Япон хэлний тайлбар толь¹: "Мүкүри Кокури" гэдэг үг нь Юань гүрний үед "Монгол, Солонгос чөтгөр ирлээ" хэмээн айн сүрддэг байснаас улбаалж үүссэн. "Мүкүри Кокури" гэдэг нь ямар

¹ Япон хэлний тайлбар толь. 1992 он. Сансэйдо хэвлэх үйлдвэр.



нэг аймшигтай зүйлийн төлөөлөл, мөн уйлсан хүүхдийг айлгахад хэлдэг үг гэж тайлбарлажээ.

"Мүкүри Кокури" үгийн "Мүкүри" нь /"Мооко"- эртний ханзны хэллэг/ Монголыг, "Кокури" нь Солонгосыг хэлдэг байна. Монгол, Солонгосын улсын усч цэрэг Японы Кююшюү арал руу хоёр ч удаа довтолж түүнээс айн сүрдэхдээ ард олон "Мооко Корё чөтгөр ирлээ" хэмээдэг байжээ. Тийнхүү энэхүү үгийн утга нь шилжиж хувирсаар "Мүкүри Кокури чөтгөр ирнэ шүү" хэмээн дур зоргоороо аашилж уйлагнасан хүүхдийг эмээлгэх зан заншил болсон байна. Японы зарим нутагт "Мооко ирнэ шүү" гэж хэлдэг байна. Мөн тухайн цаг үеийн Камакурагийн засгийн төгсгөл үеийн "Сатамирэншэ" буюу Бүкэгийн засаглалын хууль цаазын бичигт "Мооко гэдэг нь харь орон Монголыг хэлнэ" гэж бичсэн байна².

Аливаа түүхэн хэлц нь он цаг өнгөрсөөр анхны утгаасаа улам бүр холдож утга нь шилжиж хийсвэрлэгддэгийн адилаар дээрх хэлцийн утга нь хувирсаар "Мүкүри Кокури" гэдэг нэртэй чөтгөр үнэхээр байдаг юм шиг төсөөлөгдөх болжээ. Энэ үгийг ихэнхдээ Хубилай хааны цэргүүдийн зэрлэг хэрцгий үйл явдлаар тайлбарладаг ч заримдаа "тэрхүү цэргүүдийн усанд живсэнийг хэлж байна"³ гэсэн ойлголт ч бий ажээ.

Орчин үеийн хэл шинжлэлд хэлний нэгжүүдийг хэлц, хэлц бус гэж ангилж байгаа бөгөөд хэлц нь тухайн ард түмний зан заншил, сэтгэлгээний гүн утгатай хэлний үзэгдэл юм. Доктор Д.Баттогтох "Хэлц нь үгийн сангийн гол нэгж болох үгээс өргөн, агуулга, хэлбэр, бүтэц, бүрэлдүүлбэр, илэрхийлэх утга, мэдээлэл хадгалах, дамжуулах, яриа бичигт хэрэглэгдэхийнхээ хувьд өгүүлбэртэй адил тэр ч байтугай эхийн түвшинд судалж үзмээр хэлний онцгой нэгж юм" гэжээ.

"Мүкүри Кокури"-тай холбоотой

япон сэтгэлгээ нь соёл, зан ахуйд бас тусгалаа олсон байна. Тухайлбал Кююшюүгийн Икино аралд "Мүкүри Кокури хүүхэлдэй" гэдэг тоглоом урладаг байжээ. Аомори мужийн Кизүкүри хотод "Мооко но комори ута" гэдэг ардын дууг ам дамжин дуулж ирсэн байдаг бөгөөд түүнд "Уйлвал уулнаас Мооко ирнэ шүү, битгий уйлаарай" хэмээн эртний монгол шюүрай буюу довтлогчийн аймшиг сүрийг хүүхдийн дуу болгон дуулдаг байжээ.



Японы Мүкүри Кокури хүүхэлдэй. 13-р зуун

Солонгосын олон улсын судлаач И Хан Сү "Мүкүри Кокури" /무쿠리 고쿠리 귀신이 온다/ хэлц үгийн талаар "Кююшюүгийн өмнөд далайд онгоцоор ирсэн үй олон монгол, солонгос цэргийг хараад япончууд маш ихээр айж балмагдсанаас үүдэж энэхүү үг үүсчээ"⁴ гэжээ. Түүхэнд Солонгос нь Юань гүрний усч цэргийн том түшиц байсныг тэмдэглэсэн баримт нилээдгүй бий. Хубилай хаан 1268 онд Японы ванд илгээсэн жуух бичигтээ "Миний хаан суурин суусан эхэн үед Солонгос улсын ард иргэдийг хилсээр зэвсгийн үзүүрт зовох вий хэмээн өршөөж цэрэглэхийг азнаж, урьдын манай эзэлсэн газар нутаг, олзолсон иргэдийг ч буцаан өгсөн. Солонгос улсын эзэн түшмэд найр хишгийг сүсэглэж бараалхахаар ирсэн ажгуу. Ёсыг дагаж хэдийгээр хаан түшмэл боловч эцэг хүү мэт бодвоос танай эзэн хийгээд түшмэл ухан ойлгох бус уу. Солонгос улс манай зүүн халхавч болой. Япон улс Солонгос улстай ойр.

² "Камакура ибүн" буюу Камакурагийн түүхийн бичиг. Түүхийн ухааны эрдэмтэн Такэучи Ризогийн эмхтгэл. 42-р дэвтэр-Эртний судар бичиг. "Токио До Шюппан" хэвлэх үйлдвэр.

³ "Ооножёо хотын түүх" Гуравдугаар боть - Дундад зуун, Нэгдүгээр бүлэг-Түүх давтагддаг, Гуравдугаар бүлэг-Монгол Шюүрай ба Ооножёо хот, 1-р хэсэг Мүкүри Кокуригийн дурсамж. Хуудас 510-512. Кююшюүгийн Их Сургуулийн академик мэдээллийн сангаас 2005 оны 7 сарын 31

⁴ "Чусон Илбу" сонин. БНСУ. 2013 оны 5-р сарын 8. хуудас А34

Улс байгуулагдсанаас хойш Дундад улсад тогтсон ёсоор надад ирж золговоос зохилтой"⁵ гэж бичжээ.

Мөн 1271 онд Хубилай хаан хөлөг онгоц хийх ажлыг даалгаж, монгол цэргийн хүнсийг Солонгост бэлтгэх, тариа тарих зарлиг гаргажээ. 1273 онд Монгол, Солонгосын нэг түмэн цэргийг Чечу аралд байрлуулжээ. Чечу арал нь байрлалын хувьд Сүн, Солонгос, Япон, Юань гүрний дунд босгосон "харуулын цамхаг" төдийгүй олон улсын зам харилцаа, худалдааны төв байжээ. 1274 оны арав дугаар сард Юань улсын том жижиг 900 онгоц хөлөглөсөн 25000 гаруй усч цэрэг Японы Ичи арлыг амжилттай довтолж Кюүшюү аралд буужээ. Аравдугаар сарын хоринд тулалдаан ширүүсч монгол жанжид зөвлөлдөж цэргээ онгоц руугаа татах шийдэлд хүрчээ. Тэр шөнө далайн хүчтэй шуурга болж Юань улсын 700 хөлөг онгоц сүйдэж 13000 цэрэг амь үрэгджээ. Хэрэв далайн шуурганд өртөөгүй бол монголчуудын довтолгоо ихээхэн хохирол учруулж, Камакурагийн засгийг ихээхэн сандралд оруулж мэдэхээр байсан байна. Үүнээс хойш Камакурагийн засгийн газар Кюүшюүд эргийн хамгаалалт барих ажлыг эхлүүлж 2.5 метр өндөр, 20 км урт чулуун хэрмийг долоон жилийн турш барьж босгожээ⁶.

Чухамхүү япончуудыг айлгаж балмагдуулсан Хубилай хааны усч цэргийн довтолгооны сүр хүчийг Японы эх сурвалжид "бидний нум сум урт байтлаа дайсны хориглолтод хүрэхгүй, монголчуудын нум богино атлаа бидний талд элбэг тусч байлаа. Дэлбэрдэг буу нь хохирол учруулахаасаа тулалдааны тэргүүн шугамыг замбараагүй болгоход илүү нөлөөтэй байв. Толгойд яваа хөлөг онгоц улаан тугаа өргөхөд бүрээ дуугарч цан бөмбөр нижигнэн цуурайтдаг. Энэ дуунаар газар тэнгэр доргин, манай цэрэг алмайрч, морьд цовхчин замбараагаа алдав" зэргээр бичжээ⁷. Ийнхүү монголчууд Ази, Европыг дамнасан асар том хэмжээний

газар нутгийг эзлэн авах явцад маневр, хурд сайтай дан ганц морьт цэргээс гадна их бууч, усч зэрэг олон төрлийн цэрэгтэй болтлоо өргөжин тэлжээ⁸.

"Мооко ирнэ шүү" хэлц үг япон хэлэнд одоо ч хэрэглэгдсээр байгаа баримт байна. Сэтгүүлч Д.Болдхуягийн⁹ "Би монгол хүн болж төрнө" нийтлэлд / Niitlech.mn 2015.11. 23/ Монголд олзонд байсан япон цэрэг Тамура Хирошигийн тухай өгүүлжээ. Тамура Хироши 1945 онд 14 настайдаа цэрэгт элсэх хүсэлт гаргахад нь "Үгэнд орохгүй бол чамайг Мооко ирж авна даа" гэж гэрийнхэн нь айлгаж байсан хэдий ч сэмээр цэрэгт явсан ажээ. Тамура Хироши дурсамжиндаа дээрх хэлц үгийн тухай "Мооко гэдэг нь Монгол юм. Хубилайн хааны хоёр удаагийн довтолгоо далайн шуурганд сүйрсэн ч догшин түүхийн ул мөр Японы ард түмний ахмад үеийнхий ой тойнд ам дамжин уламжлагдсаар ирсэн" гэж тайлбарласан нь сонирхолтой.

Дүгнэлт. Орчин үеийн хэл шинжлэлд хэлний нэгжүүдийг хэлц, хэлц бус гэж ангилж байгаа бөгөөд хэлц нь тухайн ард түмний зан заншил, сэтгэлгээний гүн утгатай хэлний үзэгдэл юм.

Хубилай хаан 1260 онд хаан сууснаасаа хойш өмнөх хаадын адил газар нутгийн хэмжээг өргөтгөн тэлэх бодлогыг баримталж байв. Хубилай хаан Өмнөд Сүн улс, Солонгосыг эрхшээлдээ оруулаад зогссонгүй далай тэнгисээр хүрээлэгдсэн арлын орон Японыг эрхшээн захирахыг хүсч олон удаа элч илгээж байжээ. Хубилай хааны усч цэргийн Япон руу хийсэн хоёр түүхэн довтолгоо нь тухайн ард түмний сэтгэлгээ, соёл зан заншилд тусгалаа олж, хэлний өвөрмөц нэгж болох "Мүкүри Кокури" хэлц үг, ардын дуу, соёлын хэрэглэгдэхүүн хүүхэлдэйг үүсгэжээ. "Мүкүри Кокури" хэлц үг нь "монгол, солонгос цэрэг ирлээ" гэх бодит утгаас шилжиж ямар нэг аймшигт ёс бус зүйлийг илэрхийлсэн утгатай болон хийсвэрлэгджээ.

⁵ Базарсүрэн .Ж, Эрдэнэхишиг.Т "Хубилай хааны цэргийн түүхийн хураангуй" 2015 / төсөлт ажил/ т.78.

⁶ Базарсүрэн .Ж, Эрдэнэхишиг.Т "Хубилай хааны цэргийн түүхийн хураангуй" 2015 / төсөлт ажил/ т.78.

⁷ Мөнхцэцэг.Т "Япон дахь Монголын түүхийн судалгаа".2006 он. т.66.

⁸ Эрдэнэхишиг.Т "Юань улсын усч цэрэг" эрдэм шинжилгээний өгүүлэл. Цац сэтгүүл. 2015. 02 дугаар.

⁹ www.Niitlech.mn 2015.11.23

**Ашигласан материал:**

1. Япон хэлний тайлбар толь.1992 он. Сансэйдо хэвлэх үйлдвэр.
2. "Камакура ибүн" буюу Камакурагийн түүхийн бичиг.Түүхийн ухааны эрдэмтэн Такэучи Ризогийн эмхтгэл. 42-р дэвтэр-Эртний судар бичиг. "Токио До Шюппан" хэвлэх үйлдвэр.
3. "Ооножёо хотын түүх" Гуравдугаар боть - Дундад зуун,Нэгдүгээр бүлэг-Түүх давтагддаг, Гуравдугаар бүлэг-Монгол Шюүрай ба Ооножёо хот, 1-р хэсэг Мүкүри Кокуригийн дурсамж. т.510-512. Кюүшюүгийн Их Сургуулийн академик мэдээллийн сангаас 2005 оны 7 сарын 31
4. "Чусон Илбу" сонин. БНСУ. 2013 оны 5-р сарын 8. т.А34
5. Базарсүрэн.Ж, Эрдэнэхишиг.Т "Хубилай хааны цэргийн түүхийн хураангуй" 2015 /төсөлт ажил/ т.78.
6. Мөнхцэцэг.Т "Япон дахь Монголын түүхийн судалгаа" . 2006 он. т.66
7. Эрдэнэхишиг.Т "Юань улсын усч цэрэг" эрдэм шинжилгээний өгүүлэл. Цац сэтгүүл. 2015. 02 дугаар
8. www. Niitlelch.mn 2015.11.23
9. Баттогтох.Д "Зуун хэлц эх, хэлц дасгал, хэлц сорилго" УБ. 2006.